

БАЯНХОНГОР АЙМГИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ 2010 ОНЫ  
ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

2011.03.29

Баянхонгор

Мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт			
Хяналтад авсан нийт тоо		153	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо			
Үүнээс	Биелсэн /100%/		117
	Хэрэгжих шатандаа		
	Үүний дотор	90%	21
		70%	7
		50%	3
		30%	2
		10%	2
	Тасарсан		1
Хэрэгжилтийн дундаж хувь: 93,5%			

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАСГИЙН ДАРГА

М.ӨНӨРЖАРГАЛ

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.ГОМБОДОРЖ

НЭГ. НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Зорилго	Зорилт	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	
<p>1.1. Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, суралцагчдад адил тэгш боломж олгож, тэдний нийгэмшил төлөвшилд төр, эцэг эх, олон нийтийн оролцоо хамтын ажиллагааг идэвхжүүлнэ.</p>	<p>1.1.1. СӨБ болон бага дунд боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлж, сургууль завсардалтыг бууруулна.</p>	<p>-Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 81.0, ЕБС-ийн хамран сургалтыг 98,5, сургууль завсардалтыг 0,15 хувиас хэтрүүлэхгүй байна.</p>	<p>Сургуулийн насны /6-15 насны/ хүүхдийн дэлгэрэнгүй судалгааг шинэчлэн 14330 хүүхдийн судалгаа мэдээллийн баазтай болсон. Үүнээс өдрөөр 14038, дүйцсэн хөтөлбөрөөр133, эчнээгээ 4 хүүхэд нийт 14175 хүүхэд суралцаж, суурь боловсролын хамран сургалт 99%-тай байна.7-14 насны сургуулийн гадна байгаа 294 хүүхдийн 13 буюу 4,5%-ийг өдрөөр, 134 хүүхэд буюу 45,5%-ийг АББ-д хамруулаа. Цэцэрлэгийн насны 6466 хүүхдийн дэлгэрэнгүй судалгаатай болж хамран сургалтыг 78 хувьд хүргэн өмнөх оныхоос 2 хувиар өссөн бөгөөд . 2008-2009 онд нийт сургууль завсардалтын бага боловсрол дахь сургууль завсардалт нь 24 хувийг эзэлж байсан бол 2009-2010 оны хичээлийн жилд 12 хувь болон өмнөх оныхоос 50 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Сургууль завсардалт энэ оны хичээлийн жилд өмнөх оны хичээлийн жилийнхээс 0,06% хүртэл буурсан.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100 % /</b></p>
	<p>1.1.2. Боловсролын үйлчилгээний стандарт хангалтын түвшинг өмнөх оныхоос нэмэгдүүлнэ.</p>	<p>-СӨБ-д хамрагдагсдын стандарт хангалтыг өмнөх оныхоос 2,5 хувиар, ЕБС-ийн сурлагын амжилтыг 5-8 хувиар ахиулна.</p>	<p>Стандарт хангалтын хяналт шинжилгээг аймгийн ИТХ-ын нэрэмжит болгон ЕБ-ийн сургууль, цэцэрлэгийг хамруулан хийлээ. Шалгалтаар 27 сургуулийн давхардсан тоогоор 867 багшийн заадаг хичээлээр стандартын түвшин тогтоосон бөгөөд нийт 10319 сурагч хамрагдан шалгагдав. Сурлагын түвшин тогтоох шалгалтын аймгийн нэгдсэн дүнгээр 10319 хүүхдийн цуглуулах нийт 172282 онооноос 82072 оноо цуглуулж даалгавар гүйцэтгэлийн дундаж 47,6%-тай сурлагын дүнгээр А-490, В-701, С-875, D-1431, F-6810 дүн үзүүлж сурлагын амжилтын аймгийн дундаж 33,9%, А ба В үнэлгээтэй шалгуулагчдын хувийн жин 11,6%-тай шалгагдалаа. Шалгалтын дүнг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн өргөтгөсөн хурлаар хэлэлцүүлж ИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанаас тогтоол гарган. Тогтоолыг хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаа. 2010 оны 10,11 дүгээр саруудад 2 дахь шатны шалгалтыг зохион байгуулж 2-11 дүгээр ангийн сурагчдаас бүх хичээлээр шалгалт авахад сурлагын амжилт өмнөх шалгалтын дүнгээс 3,1%, чанар 1,2%-иар тус тус ахисан байна. БСГ-аас хөндлөнгийн шалгалтын стандарт хангалтын түвшинг сүүлийн жилүүдийн дунджаар гарган сургуулиудад хүргүүлсэн бөгөөд энэ хичээлийн жилийн түвшин</p>

			<p>тогтоох шалгалтыг 4, 10- сард зохион байгуулж 2-11-р ангид хичээл заадаг багшийг хамруулан стандарт хангалтын түвшинг тогтоож багш нар сургалтын хөтөлбөр боловсруулах арга зүй, хичээл судалгаагаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө. ЕБСийн стандарт хангалт сурлагын амжилт 10-12 хувиар, чанар 2-7,2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100 % /</b></p>
	<p>1.1.3. Хүүхдийн сэтгэх чадварын болон их эрдэмтэн Ш.Лувсанвандангийн мэндэлсний 100 жилийн ойн хүрээнд явагдах монгол хэл бичгийн улсын олимпиадуудыг аймагтаа зохион байгуулна.</p>	<p>-Багшийн нарын заах аргын ур чадвар дээшилж, сурагчдын сэтгэн бодох, эх хэлээ судлан шинжлэхэд гарсан ахиц дэвшилээр -Улсын олимпиадад сурагчдын үзүүлсэн амжилтаар</p>	<p>Баянхонгор аймгийн Өлзийт сумын уугуул Монгол улсын Төрийн шагналт, гавьяат багш, академич, хэл шинжлэлийн ухааны доктор, профессор Шадавын Лувсанванданы мэндэлсний 100 жилийн ойг улс орон даяар тэмдэглэх ажлын хүрээнд монгол хэл, бичгийн улсын 41дэх удаагийн олимпиадыг их эрдэмтний нэрэмжит болгон түүний төрсөн нутагт Баянхонгор аймагт 2010 оны 5 дугаар сарын 8,9-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.Олимпиадыг олимпиад зохион байгуулах хороо, аймгийн ИТХ, ЗДТГ, БСГ, “Номгон” ахлах сургууль хамтран зохион байгуулж Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргээс шалгарсан багш сурагчид оролцож, эх хэлний мэдлэг, чадвараа сорьж, уралдлаа. Баянхонгор аймагт зохион байгуулагдах улсын монгол хэл бичгийн 41дүгээр олимпиадыг угтаж ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлсэн бөгөөд Монгол хэл бичиг, уран зохиолын багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулж, төрөлх нутгаасаа төрөн гарсан монгол хэл бичиг судлалын эрдэмтэд болон зохиолчдын намтар, зохиол бүтээлийг уншиж судлах,сурагчдын эх хэлээ судлан шинжлэх,мөн 11 жилийн сургуулиудтай хамтарч монгол хэлний багш нарыг хөгжүүлэх, эх хэлний сургалтыг дэмжсэн бүтээлч ажлуудыг зохион явуулснаар багш нарын заах арга дээшилж сурагчдын эх хэлнийхээ талаарх мэдлэгээ дээшлүүлэх,төрөлх нутгаасаа төрөн гарсан эрдэмтээр бахархах үзлийг төрүүлсэн төдийгүй Монгол хэлний мэргэжлийн багш нар нэрт эрдэмтний бүтээлийг уншиж судлан Монгол хэлний мэргэжлийн бус багш нар, сурагчид Шадавын Лувсанвандан эрдэмтний талаар мэдээлэлтэй болсон. Манай аймгаас орсон Номундалай цогцолбор сургуулийн багш Гунгаагийн Энхтуяа 32 оноогоор тусгай байр, Халзангийн Уранцэцэг 31 оноо авч VII байр, Номундалай цогцолбор сургуулийн сурагч Мөнхбатын Билгүүнчимэг 27,5 оноо авч мөнгөн медаль, Номгон ахлах сургуулийн сурагч Сүхбатын Хандаамаа 20 оноо XII байр эзэлсэн амжилттай оролцлоо.Монгол хэлний багш нарын сургалт зохион</p>

		байгуулж /үндэсний сургагч багш нарын/ багш нарын мэргэшлийн болон заах арга зүйн мэдлэг чадвар дээшилсэн.  <b>/Хэрэгжилт 100%/</b>
1.1.4. Бага насны хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын шалгуур үзүүлэлтийг боловсруулан туршин хэрэгжүүлнэ.	-Шалгуур үзүүлэлт боловсрогдон 28 цэцэрлэгийн 750 хүүхдэд сургуульд бэлтгэгдсэн байдлыг шалгаснаар	2010-2011 оны хичээлийн жилд 1-р ангид элсэх хүүхдийн судалгааг гаргахад нийт 1553 хүүхэд байгаагаас өмнөх хичээлийн жилд 5 настай 153 хүүхэд 1-р ангид элсэн суралцаж, энэ хичээлийн жилд 1400 хүүхэд 11-р ангид элсэн суралцлаа <b>5 настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг</b> <ul style="list-style-type: none"> <li>• Бие бялдар эрүүл мэнд</li> <li>• Оюун ухаан танин мэдэхүй</li> <li>• Сэтгэлийн хөдөлгөөн, нийгэмшихүйн хөгжил</li> <li>• Сурах хандлага, суралцах арга барилын суурь тавигдсан байдлыг үнэлэх</li> </ul> <p>гэсэн 4 чиглэлээр аргачлалыг боловсруулан “ цэцэрлэгийн эрхлэгч, бэлтгэл бүлгийн багш нарт “ Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг үнэлэн илрүүлэх аргачлал” түүнийг хэрэгжүүлэх арга зүйг танилцуулах сургалтыг зохион байгуулж,цэцэрлэгийн багш, эрхлэгч 54 хүн хамрагдан 27 цэцэрлэгийн үндсэн бүлэгт болон хувилбарт сургалтанд хамрагдсан 690 хүүхэд, цэцэрлэгийн бэлтгэл бүлэг дээр ажиллаж буй 28 багш, бага боловсролын 52 багш, 160 эцэг эхийг хамруулан хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлыг илрүүлэх танадалт явууллаа.</p> <p><b>/Хэрэгжилт 100 %/</b></p>
1.1.5. Сургууль, цэцэрлэгийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлж үр дүнг тооцож үнэлгээ дүгнэлт өгнө.	-Сургууль, цэцэрлэгүүдийн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнгээр	Энэ оны 4-р сард аймгийн нийт сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл ажиллагааны одоогийн байдал, зөвлөлөөс хэрэгжүүлж, хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагаатай танилцаж шинжилгээ хийлээ. Нийт сургууль, цэцэрлэгийн 87,2% нь сургууль, цэцэрлэгийн зөвлөлөө хуульд заасанчлан 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан..Аймгийн нийт сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн үйл

			<p>ажиллагааны одоогийн байдал, зөвлөлөөс хэрэгжүүлж, хийж гүйцэтгэж байгаа үйл ажиллагаатай танилцаж шинжилгээ хийлээ. Нийт сургууль, цэцэрлэгийн 87,2% нь сургууль, цэцэрлэгийн зөвлөлөө хуульд заасанчлан 7-9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан хэдий ч үйл ажиллагаа нь тогтмолжоогүй, сонгогдсон гишүүд юу хийхээ тодорхой мэдэхгүй, энэ ажлын талаар гарсан эрх зүйн баримт бичгээ төдийлөн сайн судлаагүй хийж гүйцэтгэх ажлын чиглэлээ сайн мэдэхгүй байгаа байдал ажиглагдлаа. Сургууль цэцэрлэгийн зөвлөлийн дарга нарын сургалтыг 2010 оны 5 сарын 1-ний өдөр зохион байгуулж явууллаа. Сургалтанд СЦЗ-ийн дарга, гишүүд 20 хүн хамрагдлаа. СЦЗ-ийн ажлын чанарыг сайжруулах, СЦЗ нь тухайн сургууль, цэцэрлэгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор сургалтыг зохион байгуулснаар СЦЗ-ийн үйл ажиллагааг цаашид сайжруулах зарим санаа сэдвүүдээр ярилцаж, ажиллах тодорхой чиглэлийг өгч ажилласан.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100 %/</b></p>
	1.1.6. Албан бус боловсролын гэгээрлийн төвүүдийн үйл ажиллагааг иргэдийн боловсролыг дээшлүүлэхэд чиглүүлнэ.	- Бичиг үсэг үл мэдэгч 300 хүнийг бичиг үсэгт тайлснаар	<p>Сумын нийгмийн бодлогын ажилтан, багийн дарга, албан бусын арга зүйчид хамтран иргэдийн бичиг үсгийн боловсролын чадавхын судалгааг авсан ба судалгааны нэгтгэлээр насанд хүрэгчдийн 1,2% нь бичиг үсэг үл мэдэгч, 19,6% хагас бичигтэн, 42,5% нь бичигтэн, 37,6% нь функциональ бичигтэн байна.</p> <p>Насанд хүрэгчдийн бичиг үсгийн сургалтыг зуны сургалт, шавилан сургалт, явуулын сургалт хэлбэрээр сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгууллаа. Энэ сургалтаар 235 иргэний бичиг үсгийн чадварыг дээшлүүллээ.</p> <p>Иргэдийн эрэлтэд тулгуурлан сумын ЗДТГ, эмнэлэгтэй хамтран хөдөө аж ахуй, байгаль экологи, эрүүл мэнд, хууль, төсөл бичих, газар тариалангийн чиглэлээр 3638 иргэнд сургалт өгч боловсролын түвшнийг дээшлүүлсэн байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт -100 %/</b></p>
1.2. Ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангаж тэдний	1.2.1. Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх багшийн хөгжлийн загвар төвийг бүсийн төв сургуулиудад байгуулна.	-Баянцагаан, Богд, Бууцагаан, Жаргалант сумдад загвар төв бий болсноор	<p>Багшийн мэргэжил дээшлүүлэх багшийн хөгжлийн төвийг бүсийн төв сургуулиудад түшиглэн байгууллаа. Баянцагаан, Богд, Бууцагаан, Жаргалант сумдад загвар төв бий болсон. Богд сумын сургуульд “Багшийн хөгжлийн загвар төв”-д шаардлагатай тавилга, техник тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

мэргэжлийг дээшлүүлнэ.			
1.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа их дээд, мэргэжлийн боловсролын сургуулиудын боловсролын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	1.3.1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг судлах, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа мэргэжлийн боловсролын сургуулиудын өрсөлдөх чадвар нэмэгдсэнээр	Их, дээд сургууль болон МСҮТ-ийн сургалтын чанарт ахиц гарсан байдлыг 5, 12 сард 2 удаа үнэлгээ хийхээр төлөвлөн ажилласан бөгөөд 5 сард МСҮТ-үүд болон 2 дээд сургуулийн хэмжээнд МХГ-тай хамтран багш нарын боловсролын баримт бичиг, төгсөх курсийн өдөр, эчнээ ангиудын бичиг баримт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, хичээлийн хуваарь, ангийн журнал зэргийг үзэж, цагийн норм нормативын талаар хяналт шалгалт хийж дүгнэлт гаргасан. 2011 онд мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах, аж ахуй эрхлэх сургалт, мэргэжлийн чиг барилжаа олгох, зөвлөх үйлчилгээнд 2780 хүнийг хамруулах захиалгыг ХХҮГазарт хүргүүлээд байна. <b>/Хэрэгжилт 100 % /</b>
	1.3.2. Нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааг өргөжүүлж, дээд сургууль төгссөн мэргэжилтэй ажилчдыг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлсэн ажил олгогчдыг дэмжинэ.	-Түншлэгчдийн идэвх оролцоо нэмэгдсэнээр	МСҮТ-ийн сургалтын төлөвлөгөө нь түншлэлийн үйл ажиллагаан дээр тулгуурладаг учраас түншлэгчид рүү чиглэсэн үйл ажиллагааг ихээхэн хийж ажиллалаа. Тухайлбал: Уулзалт ярилцлага зохион байгуулах, мэргэжлийн холбоодыг байгуулах, хооронд нь уулзуулж, туршлага судлах ажлуудыг хийлээ. БСШУЯ-ны харьяа МСҮТ нь 2008-2009 оны хичээлийн жилд 86 аж ахуй нэгж байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулж ажилласан бол 2009-2010 оны хичээлийн жилд 94 аж ахуй нэгж байгууллагатай түншлэлийн гэрээ байгуулан ажиллаж түншлэгчдийн тоо 8,5 хувиар нэмэгдсэн байна. Мэргэжлийн холбоодыг байгуулж ажилласнаар түншлэгчдийн идэвхи оролцоо нэмэгдэж, сургуультай хамтарч ажиллах сонирхол өссөн байна. <b>/Хэрэгжилт 100 %/</b>
1.4. Боловсролын байгууллагын материаллаг баазыг нэмэгдүүлнэ.	1.4.1. Баацагаан сумын сургуулийн спорт заалны халаалтын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж засварлана.	-Спорт заалны халаалтыг засварласнаар	Сургуулийн спорт заалны халаалтын засварыг Тогтвортой амьжиргаа төслийн 12 сая төгрөгийн ажлын тендер зарлагдаж “Ганмөнхжин” ХХКомпани шалгарч ажлаа эхлээд байна. <b>Хэрэгжилт 100 %</b>
	1.4.2. Баянхонгор аймгийн 7-р багт цэцэрлэгийн барилга барина.	- Цэцэрлэгийн барилгыг барьж дуусгаснаар.	Баянхонгор сумын 7-р багт барих 75 хүүхдийн цэцэрлэг баригдаж, ашиглалтанд ороход бэлэн боллоо. Барилгыг улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хангадаж, дотоод тоног төхөөрөмж тавилга хэрэгслийг БСШУЯ-наас татан авлаа. <b>/Хэрэгжилт 100 %/</b>
2.1. Аймгийн соёл, урлагийн	2.1.1. Аймгийн Номын санг LIB4U цогц программд	- Фондын номын 60 хувь буюу 26160	2010 онд 10153 ширхэг буюу нийт номын фондын 38.8 %-ийг электрон каталогт оруулан, 17000 номыг зураасан бар кодтой

байгууллагуудын үйл ажиллагаанд зах зээлд өрсөлдөх соёлын шинэ нэр төрлийн үйлчилгээг бий болгож, уран бүтээл, үйлчилгээний тоо, чанар, хамрах хүрээг нэмэгдүүлж, хүүхэд, залуучууд, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний үр өгөөжийг дээшлүүлнэ.	шилжүүлэх, электрон катологт фондын номыг оруулах, уншигчдын E-мэйл хаягийн тоог нэмэгдүүлж, номын сангийн үйлчилгээг автоматжуулна.	номыг электрон катологт оруулж, уншигчдын E-мэйл хаягийн тоог урьд оноос 20 хувиар нэмэгдүүлж, уншигчдад үзүүлэх үйлчилгээг 50 хувийг автоматжуулснаар	болгосон. 240 хүн интернетээр үйлчилүүлж, 60 уншигч E-мэйл хаягаа нээлгэсэн. E-мэйл хаягтай уншигчдын тоо урд оны мөн үеэс 30 хувиар нэмэгдсэн. Вольвис ХХК-ны мэргэжилтнүүдийг урьж ирүүлэн номын санч нарт 3 өдрийн сургалт зохион байгууллаа. Мөн номын санч Я.Гэрэлтуяаг Хүүхдийн номын ордонд “Номын сан мэдээллийн төв” болох нь 7 хоногийн сургалтанд хамруулсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	2.1.2. Аймгийн Музейн соёлын өвийн судалгаа, шинжилгээний ажлыг нэмэгдүүлж, түүх, соёлын ховор үзмэрийн хадгалалт, хамгаалалт, сэргээн засварлалтыг сайжруулж, музейн стандартын хэрэгжилтийг хангаж, фондыг шинэ үзмэрээр баяжуулна.	- Улирал тутамд 200-гаас доошгүй соёлын өвд эрдэм шинжилгээний тодорхойлолт бичиж, Соёлын өвийн төвд явуулснаар - Хосгүй үнэт, үнэт үзмэрийг видео камераар цаг тухай бүр харж, хадгалалт, хамгаалалтыг сайжруулснаар -Музейн улсын стандартыг хэрэгжүүлснээр - 5 саяаас доошгүй төгрөгөөр хосгүй үнэт, үнэт үзмэрийг худалдан авч музейн фондыг баяжуулснаар	600 үзмэрт эрдэм шинжилгээний тодорхойлолт бичиж,10 үнэт үзмэрийг засварлуулахаар Соёлын Өвийн Төвд явуулснаас 4 танка бурханыг эргүүлэн хүлээн аваад байна.  “Соёлын өвийн судалгаа” 3 сарын аяны ажлын хүрээнд уралдаан зарлаж, соёлын биет бус өвийг өвлөн тээгч 127 хүний судалгаа гаргаж, ард иргэдийн гар дээр хадгалагдаж байгаа хөдлөх түүх, соёлын 40 дурсгалыг Музейн бүртгэл мэдээллийн санд оруулаад байна. ТСҮХДЗ-ийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах үндэсний хөтөлбөрийн хүрээнд Аймгийн нутаг дэвсгэрт байгаа дурсгалуудаас 32 түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг аймгийн Засаг даргын 263 дугаар захирамжаар томилогдсон комисс очиж тоолж, 65 дурсгал, газрын цэгийг тогтоож, зураг авч, бичлэг хийн аймгийн бүртгэл мэдээллийн санд авлаа.  Иргэдээс 8 үзмэрийг 3,129,000 төгрөгөөр, 64 үзмэрийг бэлэг хандиваар авч сан хөмрөгөө баяжуулаад байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	2.1.3. Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлнэ.	-2011 оны төсвийн хүрээний мэдэгдэлд “Морин хуур, уртын дуу”, “Монгол хөөмий, бий биелгээ”, “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах,	Засгийн газраас соёл, урлагийг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж буй “Морин хуур, уртын дуу”, “Монгол хөөмий”, “Монгол уламжлалт бий, биелгээ” үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Морин хуур, уртын дуу, хөөмэй, бий биеэлгээний 21 хоногийн сургалтыг Монголын хөөмэйн урлагийн ассосоцын тэргүүн Ч.Бат-Оюун, Баян-Өлгий аймгийн нэрт биич, Ардын жүжигчин Р.Самжид, аймгийн ХДТ-ын морин хуурч Ч.Отгонбаяр, уртын дууч

		хадгалах, сэргээн засварлах” зэрэг үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг тооцож оруулснаар -Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах үлдсэн зардлыг 2012 оны төсөвт тусгуулж хэрэгжүүлснээр	Д.Хорлоо нар явууллаа. Сургалтанд нийт 63 хүүхэд, залуучууд, ардын авъястнууд хамрагдлаа. Амжилттай суралцсан 20 хүнд орон нутагт сургалт зохион байгуулах “Сургагч багш”-ийн Сертификат олголоо.  <b>/Хэрэгжилт-100%/</b>
2.2. Салбарын байгууллагуудын материаллаг хангамж, нөхцлийг сайжруулж, үйлчилгээний шинэ орчин бүрдүүлэх	2.2.1. Бууцагаан, Баянцагаан сумын Соёлын төвийг шинээр, БаянӨндөр, Шаргалжуут тосгоны соёлын төвийг гүйцээн барьж, Жаргалант, Баянлиг сумын соёлын төвд ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөрөөр их ба урсгал засвар хийж, Галуут сумын соёлын төвийг халаалттай болгож, Гурванбулаг, Баацагаан, Баянговь сумын соёлын төвийн шинэ барилгын зураг, төсвийг хийлгэж бэлэн болгоно.	-1 сумын соёлын төвийг шинээр, 2 сумын соёлын төвийг гүйцээн барьж, 2 сумыг халаалттай, 1 сумын барилгад их ба урсгал засвар хийх, 3 сумын соёлын төвийн барилгын зураг, төсвийг хийж бэлэн болгосноор	Баян-Өндөр, Шаргалжуут тосгоны соёлын төв ашиглалтанд орсон. Оорцог Уул” ХХК Бууцагаан сумын соёлын төвийн барилгын ажлыг эхэлж, суурийг тавьсан 199.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн. Жаргалант сумын Соёлын төв их засварын 300 сая төгрөгийн зураг, төсөв хийлгэсэн. Галуут сумын соёлын төв тогтвортой амьжиргаа төслөөр 2 сая төгрөгийн өртөгтэйгээр халаалттай болж, Эрдэнэцогт сумын соёлын төвийн 50 сая төгрөгийн их засварыг “Халзан хайрхан” ХХК хийж ашиглалтанд оруулсан.  <b>/Хэрэгжилт-100%/</b>
	2.2.2. Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв, Баянбулаг, Хүрээмарал, Өлзийт сумын Соёлын төв, Музейд техник хэрэгсэлийн шинэчилэл хийх төсөл, аймгийн Номын санд дохиололын систем суурилуулах төсөл боловсруулж, хөрөнгийн эх	Номын сан, Музей, Баянбулаг, Өлзийт сумын соёлын төвд хөрөнгө оруулалт хийгдэж эхэлснээр - Хүүхэд, залуучуудын хөгжлийн төв, Баянбулаг, Хүрээмарал сумын	-Хүрээмарал сумын Соёлын төв 3,2 сая төгрөгийн, Баянлиг сумын Соёлын төв 11,2 сая төгрөгийн техник аппаратур, аймгийн ИТХ-ын хөрөнгө оруулалтаар ХДТ 2 сая төгрөгийн үндэсний болон европ хөгжмийн зэмсэгтэй болсон -Хүүхдийн “Тэмүүжин” театрын уран бүтээлийг дэмжиж төсвөөс 2,1 сая төгрөг, ДЗОУБ-аас 1,5 сая төгрөг, УИХ-ын гишүүн Х.Баттулга 3,0 сая төгрөгийн, БСШУЯ шинэ заалны сандал, техник аппаратур авахад зориулж 120,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Музей тог баригч 180.000 төгрөг, архив албан хэрэг хөтлөлтийн

	үүсвэрийг шийдвэрлэнэ.	соёлын төвд техник, тоног төхөөрөмжийн шинэчилэл хийгдэж эхэлснээр	цахим программ 200,000 төгрөгөөр худалдан авч тоног төхөөрөмжийн шинэчлэл хийлээ. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	2.2.3. Ламын гэгээний цогцолборыг 157,0 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд оруулах	-Цогцолборын барилга байгууламж ашиглалтанд орсноор	“Унага трейд” ХХК Цогцолборын барилгын суурийг тавьж эхэлсэн боловч барилгын зургийн алдаа гарсан тул барилгын ажил зогссон. /барилгын арматурын төмрийн голчийг буруу тооцсон байсан. 2011 онд шийдвэрлэхээр зохицуулалт хийгдсэн./ <b>/Хэрэгжилт-10%/</b>
	2.2.4. Аймгийн Музейн стандартын барилгын зураг, төсвийг хийлгэнэ.	-Барилгын газар, зураг, төсвийг бэлэн болгосноор	Аймгийн Музейн шинэ барилгын газрын зөвшөөрлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 61-р тогтоол, аймгийн Засаг даргын 2010 оны 367-р захирамжаар батлуулан барилга барих 0,12 га газрыг хуучин АҮ-ний ард “Эв санааны нэгдэл”цэцэрлэг дотор авч, цахилгаан, дулааны инженерийн шугам сүлжээний зураглал, зөвшөөрлийг авсан. Одоо барилгын зураг, төсвийг хийлгэхээр саналаа холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна. <b>/Хэрэгжилт-90%/</b>
3.1. Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.	3.1.1. Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлөөр нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэж, үр дүнг тооцно.	Нийгмийн эрүүл мэндийн 14 хөтөлбөрийн тайланг хэлэлцэж бодит үр дүнг тооцсноор	Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэн хэрэгжилтийн хугацаа дууссан хөтөлбөрүүдийн үнэлгээг хийж, ЭМСайдын тушаалаар шинэчлэгдэн гарсан “БЗДХ, ХДХВ/ДОХ”-тусламж, үйлчилгээний удирдамж, “Зөв хооллолт-хөдөлгөөн”, “Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа”-ны үндэсний стратегийг орон нутагт хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэлэлцэж баталсан. Нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал, НЭМ-ийн тулгамдсан асуудлаар 2010 оны 9 дүгээр сарын 16-17-нд “Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн шинэ чиг хандлагыг хөгжүүлэх замаар Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх нь” сэдэвт аймгийн зөвлөгөөнийг аймгийн удирдлагууд сумдын Засаг дарга, хүн эмнэлгийн эрхлэгч, нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг хамруулан хийлээ. Зөвлөгөөний үеэр Жаргалант сумын Засаг дарга НЭМСЗөвлөлийн ажлын сайн туршлагын талаарх мэдээлэл хэлэлцүүлж, зөвлөмж гаргалаа. <b>Хэрэгжилт 100%</b>
	3.1.2. “Орчны эрүүл мэнд” аймгийн дэд хөтөлбөрийг	Хөтөлбөр боловсрогдон	Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг дэд хөтөлбөрийг боловсруулан Засаг даргын зөвлөлийн хурлаар

	“Агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөр”-тэй уялдуулан боловсруулж хэрэгжүүлж эхэлнэ.	хэрэгжиж эхэлснээр	хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлж эхлээд байна.  <b>Хэрэгжилт 100%</b>
	3.1.3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээг өргөжүүлж, өвчин эсэргүүцэх тарилга, вакцин, эм хангалтыг нэмэгдүүлнэ.	Халдварт өвчний эрт илрүүлэлт нэмэгдэж, халдварт өвчнийг эмчлэх вакцин, эмийг 70-аас дээш хувь хангаснаар	2010 оны эхний 11 сарын 29- ны байдлаар халдварт А хэлбэрийн шар нийт 524 тохиолдол бүртгэгдэн дэгдэлт хэлбэрээр гарч байгаа, мөн 12-24 сартай хүүхдүүдийг энэхүү өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг захиалсан бөгөөд улсын хэмжээнд вакцины нөөц хомсдолтой байдлаас 600 хүн тун вакцин тархвар судлалын заалтаар 2-9 насны хүүхдүүдэд хийсэн. Улаан бурхан, гахай хавдар, улаанууд өвчний хавсарсан вакцинд хамрагдвал зохих 9 сартай хүүхдийн 95,8 хувь, 2 настай 96,9 хувь хамрагдан аймгийн дундажаар 96,4 хувьтай байна. <b>/Хэрэгжилт-50%/</b>
	3.1.4. Халдвартын шинэ эмнэлгийн зураг, төсөв хийлгэх асуудлыг эхлүүлнэ.	Барилгын зургийг хийлгэснээр	Халдварт, сүрьеэгийн эмнэлгийн барилгыг барих төсөв, хөрөнгийн асуудлыг ЭМЯ-ны Барилга, захиалагчийн албанд тавьж 2011 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 807 сая төгрөгийн төсөвт өртөгөөр баригдахаар шийдвэрлэгдсэн болно.  <b>Хэрэгжилт 100%</b>
3.2. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан эх, нялхсын эндэгдлийг бууруулна.	3.2.1 50 ортой төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийг ашиглалтад оруулж, эх хүүхдийн эндэгдлийг улсын дундажид хүргэнэ.	Эх хүүхдийн эндэгдэл буурч аймгуудын дундажид хүрснээр.	-2010 оны 11-р сарын 21-нд аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн 50 ортой барилгыг ашиглалтанд хүлээн авч ажиллаж эхлээд байна. Мөн ЭМЯ, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 12,3 сая төгрөгний өртөг бүхий эхчүүдийн амрах байрны тавилга, тоног төхөөрөмжийг дээрхи тасагт хүлээлгэн өгснөөр аймгийн НЭ-т сумдаас ирж төрж буй эхчүүд төрөхийн өмнөх байранд тав тухтай амрах нөхцөл бүрдээд байна. -Эхний 11 сарын байдлаар эхийн эндэгдэлгүй байгаа боловч нялхасын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл улсын дунджаас өндөр байсаар байна. Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 27,5 промилль байгаа нь улсын дунджаас 8 промилиэр өндөр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 34,2 промилль байгаа нь улсын дунджаас 9,4 промилиэр өндөр байна.  <b>Хэрэгжилт 70%</b>
	3.2.2. Эрүүл мэндийн салбарын ажил үйлчилгээнд хөндлөнгийн хяналтын тогтолцоог бий болгож,	Хяналтын тогтолцоо бий болж, ажил үйлчилгээ сайжирснаар	Засаг даргын 2010 оны 262, дугаар захирамжаар “Эрүүл мэндийн салбарын ажил үйлчилгээнд хөндлөнгийн хяналт тавих аймгийн зөвлөл”-ийг ард иргэд, ТББ, ажил олгогч болон үйлдвэрчний эвлэлийн төлөөлөлийн оролцоотой байгуулсан. Тус зөвлөл эрүүл

	эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ		мэндийн салбарын ажил үйлчилгээнд ард иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авч, Засаг даргын зөвлөлд танилцуулахаар бэлтгэж байна. <b>Хэрэгжилт 100%</b>
	3.2.3. Хөдөөгийн алслагдсан малчид, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн явуулын багийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, үр дүнг тооцно	Явуулын багийн үйлчилгээний чанар, үр дүнг тооцсноор	Сумдаас урьдчилан сэргийлэх үзлэгийн захиалга авч график гарган Урьдчилан сэргийлэх үзлэгийг хангай, говийн чиглэлээр 2 удаа явж Галуут, Гурванбулаг, Баянбулаг, Хүрээмарал, Жаргалант, Баян-Өндөр, Шинэжинст, Бууцагаан, Баянговь, Баянлиг сумын иргэдэд дотор, мэдрэл, мэс засал, хүүхдийн эмчийн үзлэгт 470 хүн хамруулав. Урьдчилан сэргийлэх үзлэгийн явцад 6 хүнд мэс заслын эмчийн нарийн мэргэжлийн тусламжийг газар дээр нь үзүүлсэн. /дотор 157, мэдрэл 198, хүүхэд 19/ Мөн 408 хүнд хөдөлмөр зохицуулалт хийж, 258 хүнд НД-ын хууль, Эрүүл мэндийн даатгалын хууль болон бусад зонхилон тохиолдох өвчний талаар ЭМБО сургалтыг хийлээ.Цаашид 2010 оны 12 сард Бөмбөгөр, Жинст суманд хүүхэд, дотор, шүд, Арьс-БЗДХ, эмэгтэйчүүдийн ЭХО, мэс заслын эмч нарын бүрэлдхүүнтэй урьдчилан сэргийлэх үзлэг хийхээр төлөвлөж байна. 2010 оны 07 сарын 07-ны өдөр Эрүүл мэндийн газар, "Бат-Сайхан сэтгэл"ТББ, УЗХороо, Онгцой байдлын хэлтэс хамтарч Галуут сумын Далт алтны газарт мэргэжлийн эмч нар нарийн мэргэжлийн үзлэг хийж, эрүүл мэндийн сургалт хийсэн. Сургалтад 15 хүн оролцож эрүүл мэндийн идэвхтнээр бэлтгэгдсэн. Оролцогсдын мэдлэгийн түвшин сургалт хийхээс өмнө 30%-тай байсан бол сургалтын дараа 85%-тай болсон байна. Дэлхийн-Зөн олон улсын байгууллагаас төсөл хэрэгжүүлж сум бүрээс 3 хүнийг сургалтанд хамруулж сум бүрт мультивитамин болон бичил тэжээлийн холимог, витамин Д, зэрэг бэлдмэлийг тарааж өгсөн. <b>Хэрэгжилт-100%</b>
	3.2.4. 2010 оныг "Өрхийн эмнэлэг, багийн эмч"-ийг дэмжих жил болгон багийн эмчийг багт нь тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг үзүүлнэ.	Жилийн ажлыг дүгнэж, үр дүнг тооцсноор	Жилийн ажлын хүрээнд 2010 оны 09-р сарын 18-19-ны хооронд 19 сумын 65 багийн бага эмч оролцсон ажил мэргэжлийн уралдааныг ДЗБОНХХ, Эрүүл мэндийн газартай хамтран зохион байгууллаа. ХӨЦМ, эх барихын тусламж үйлчилгээ, эхэд өгөх хооллолтын зөвлөгөө сэдвүүдээр онолын болон гардан үйлдлийн шалгалт өгч уралдсанаас 1-р байр Өлзийт, 2-р байранд Баянбулаг,3-р байранд Баянговь сумын багийн бага эмч нар шалгарч урамшуулал мөнгөн шагналаар шагнагдлаа. Мөн 45 багийн эмчид Эрүүл мэндийн яамнаас багийн эмч нарын иж бүрэн хувцас, 18 мотоциклийг хуваарилан цаашдаа 3 жил тутамд энэ уралдааныг тогтмол зохион

			байгуулахаар төлөвлөөд байна. <b>Хэрэгжилт-100%</b>
	3.2.5. Богд сумын хүн эмнэлгийн барилгын дээврийг засварлах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж засварын ажлыг эхлүүлнэ.	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэнээр	Богд сум дундын эмнэлгийн барилгын дээврийн засварын ажилд Эрүүл мэндийн сайдын багцаас 70 сая төгрөгийн санхүүжилтээр хийгдэхээр төсөвлөгдөн гүйцэтгэгчээр барилга үйлчилгээний “Хаш гоёо” ХХК шалгаран ажлыг бүрэн гүйцэтгэснийг ашиглалтанд хүлээн аваад байна. <b>Хэрэгжилт-100%</b>
3.3. Хүн амыг чанарын баталгаатай эмээр хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ.	3.3.1. “Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер” зарлаж, хүн амыг өндөр идэвхтэй, чанарын баталгаатай үндэсний зайлшгүй шаардлагатай эм, биобэлдмэлээр жигд хүртээмжтэй хангаж, үр дүнг тооцож ажиллана.	Үндэсний зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангаснаар	Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, сум дундын эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийг 2010 онд ханган нийлүүлэх нэгдсэн тендерээр 16 багцад 380 нэр төрлийн 388,3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн бэлтгэн нийлүүлэх гэрээг 10 эм ханган нийлүүлэх байгууллагатай хийж, хэрэгжилтийн байдалд хяналт тавин ажилласнаар энэ оны эхний 11 сарын байдлаар хэрэгцээт эмийн 90%-ийг татан авч, зайлшгүй шаардлагатай эмийн хангалт аймгийн хэмжээгээр 85%-тай байна. 2010 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 31 эмийн сангийн 96,8 хувь нь стандартын шаардлага хангасан байранд үйл ажиллагаа эрхэлж байна. Жор маягтын хангалт, жор бичилтийн стандартыг мөрдөх чиглэлээр сумдын эмнэлгээс захиалга авч 30 мянган ширхэг жорын маягтаар ханган, жор бичилтийн талаар сум, багийн эмч нийт 106 эмч, мэргэжилтэнг сургалтанд хамруулаад байна. <b>Хэрэгжилт-90%</b>
4.1. Нийтийн биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлын үр нөлөөг сайжруулж, хамрах хүрээг өргөтгөж, иргэд, хүүхэд залуучууд чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрөөх нөхцөл бололцоог бүрдүүлнэ.	4.1.1. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох судалгаа хийнэ.	Судалгаа хийгдэж, судалгааны үр дүнг тооцсноор	Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажилчдаас бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилын дүнг нэгтгэн биеийн тамирын багш, биеийн тамирын арга зүйч нарт хүн амын бие бялдрын хөгжлийн түвшинг сайжруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна. <b>Хэрэгжилт-70%</b>
	4.1.2. Нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлт, спортын талаар үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, үр дүнг тооцно.	“Үндэсний спортыг хөгжүүлэх”, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангагдсанаар	Үндэсний спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд 2010 оны 4, 5 дугаар сард аймгийн аварга шалгаруулах шагайн харваа, үндэсний бөхийн насанд хүрэгчдийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгууллаа. Тэмцээнд 13 байгууллагын 50 тамирчин оролцож авхаалж самбаа хурд хүчээ сорьсноос багийн дүнгээр тэргүүн байрыг Д.Туваан дасгалжуулагчтай Бууцагаан сумын баг тамирчид, 2-р байранд Дамдин дасгалжуулагчтай Баацагаан сумын баг тамирчид, 3-р байранд Эрдэнэхүү дасгалжуулагчтай

			<p>Баянбулаг сумын баг тамирчид тус тус шалгарлаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, үндэсний спортоор хүүхэд залуучуудыг хичээллүүлэх, сурталчилах зорилгоор сум бүрт шагайн харвааны клуб байгуулж ажиллахыг сумдын ИТХ-ын дарга нарт үүрэг болгосон албан бичгийг аймгийн ИТХ-ын дарга бөгөөд аймгийн шагайн харвааны товчооны тэргүүн Г.Батжаргалын албан бичгийг хүргүүлж, сумдад шагайн харвааны клуб ажиллаж байна. Мөн сумдын үндэсний бөхийн холбоонд бөхийн дэвжээ олгосон.</p> <p>Аймгийн нийгмийн хөгжлийн хэлтэстэй хамтарч 52 долоо хоногийн сургалтын төлөвлөгөө гаргаж 7 хоног бүрийн мягмар гаригт удирдах ажилтаны шуурхай дээр биеийн тамир спортоор хичээллэхийн ач холбогдлыг сурталчлах, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулж мэдээлэл өгөхийн зэрэгцээ аймгийн Засаг даргын 2009 оны 503 дугаа захирамжаар сумдад биеийн тамирын орон тооны бус аргазүйчийг ажиллуулж, сар бүр биеий тамир спортын арга хэмжээ зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хүргүүлэн сар бүр хийсэн ажлын тайланг нь авч, орон тооны бус арга зүйчийг удирдлага, арга зүйгээр ханган ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-100%</b></p>
4.2. Хүүхэд залуучуудын спортоор хичээллэлтийг дэмжиж улс, бүсийн уралдаан тэмцээнийг аймагтаа зохион байгуулна.	4.2.1. Хүүхдийн спортын сургууль байгуулах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх эхлэлийг тавина.	Асуудлыг шийдвэрлүүлснээр	<p>Хүүхдийн спортын дунд сургуулийн барилга, газрын зургийг хийлгэн сургуулийн тогтмол болон хувьсах зардлын төсвийг хийж, 2012 оны төсөвт суулгуулахад бэлэн болсон.</p> <p>Боловсрол соёлын газартай хамтран Номун далай” сургуульд сагсан бөмбөг, “Номгон” сургуульд чөлөөт бөх, “Эрдэм” сургуульд волейболын төрөлжсөн ангиудыг нээн хичээллүүлж байна.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт-100%</b></p>
5.1. Хүүхэд залуучууд эмэгтэйчүүд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах, тэдний хөгжлийг хангахад чиглэсэн бүхий л үйлчилгээг	5.1.1. Гэр бүлийн харилцааны үнэт зүйл, ёс зүйг төлөвшүүлэх талаар соён гэгээрүүлж, зөвлөн туслах үйлчилгээний шинэ төрлүүдийг хөгжүүлнэ.	3-аас дээш төрлийн үйлчилгээг шинээр бий болгосноор Үйлчилгээ авсан гэр бүлийн тоо нэмэгдсэнээр	<p>Бий болсон үйлчилгээ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Шинэ гэр бүлийн баталгааг ёслол төгөлдөр гардуулах эхлэлийг бий болгосон.</li> <li>2. Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн</li> <li>3. Гэр бүлүүдийг алдаршуулан туршлагыг түгээн дэлгэрүүлдэг урамжлалтай болсон.</li> <li>4. Өрх гэр бүлийг чадваржуулах сургалтуудыг болон ургийн баярыг хийж удам угсаа мэдэх ялангуяа генетикийн өөрчлөлт иргэд төрөхөөс урьдчилан сэргийлэх арга</li> </ol>

<p>хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ</p>			<p>хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>5. Гэр бүлүүдийн туршлагыг бусдад түгээх, дэлгэрүүлэх, суралцах боломжийг бүрдүүлэх зорилгоор улсын болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсан. Дээрх үйлчилгээнүүдэд --- гэр бүл хамрагдсан. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдтай байгуулсан хүн амын хөгжил бүтээгдэхүүний хүрээнд сайдын багцаас шилдэг гэр бүл, алдарт эхчүүдийн арга хэмжээнд 1,8 сая төг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах болон туршлагыг түгээн дэлгэрүүлэх, сургалт зохион байгуулахад аймгийн Засаг даргын нөөцөөс 1,7 сая төгрөг зарцуулсан. Дэлхийн зөн-Баянхонгор орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөрийг хэрэгжүүлэх 40 сургагч багш, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг хүргэгч сургагч багшийг Мерси кор олон улсын байгууллагатай хамтран 25 хүнийг багшаар тус бэлтгэсэн нь өрх гэр бүлийг чадваржуулах боловсон хүчний нөөцтэй болсон. Нийгмийн цогц суурь үйлчилгээ хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн зарим судалгаагаар хүүхдэд ээлтэй орчин орон нутаг, өрх гэр бүлүүдийг бий болгох хэрэгцээ шаардлага байна гэж 62 хувь, сайн эцэг эх байж чадахгүй байна гэж нийт үнэлгээнд оролцсон өрхийн 82 хувь, хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол хэрэгтэй гэж 55 хувь, хөдөлмөр ба аж ахуй эрхэлдэггүй гэж 58 хувь хариулсанаас үзэхэд эдгээр асуудал өрх гэр бүлд хамгийн нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой асуудал болж байгаа нь харагдаж байна. Сургагч багш нарыг 2011 онд нийгмийн цогц суурь үйлчилгээний хөтөлбөр болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээг сум бүртээ хэрэгжүүлэх, тайланг ирүүлж байх талаар чиглэл өгсөн.</p> <p style="text-align: right;"><b>Хэрэгжилт 100%</b></p>
	<p>5.1.2. “Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулах цогцолбор хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж эхэлнэ.</p>	<p>Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилт 90-ээс дээш хувьтай биелснээр</p>	<p>Урьд онд хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсан хүүхдүүдийн эцэг эхийг ажилтай болгож хүүхдүүдийн сурах хөгжих эрхийг хэрэгжүүлэх чиглэлийг сум, аж ахуй нэгж байгууллагуудын хүүхдийн асуудлыг ажлын байрандаа оруулж хариуцан ажиллаж байгаа ажилтануудад өгч, тэднийг чадваржуулах сургалтыг хийсэн. Хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрийг хариуцагч болон хүүхдийн төлөө ажилладаг боловсон хүчинг чадавхижуулах “Боловсрол, урлаг, хэвлэл мэдээллээр хүүхдийн эрхийг дэмжихүй” шинэ модулийн 12 загвар, “Хүүхдийн хөгжил төлөвшлийг сайжруулах” аймгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй, “ Хүүхдийн эрх хамгааллын арга зүй”, “Хүүхдийн хөгжил,</p>

			<p>хамгаалалд-хүүхдийн элчийн үүрэг-оролцоо”, “Хүүхдийн хөгжил, хамгаалалд-сургуулийн нийгмийн ажилтны үүрэг,оролцоо” “Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдийн нийгмийн хамгаалал”, “ Гэр бүл, эцэг эхчүүдийг чадваржуулах үйл ажиллагаа” сэдвээр сургалт тус тус сургалт хийж, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тулгамдаж буй асуудал”-аар бүлгийн ажил явуулж хэрэгцээгээ тодорхойлох арга зүйд суралцуулж чадваржуулсан. Энэ онд аймгийн Засаг даргын санаачилгаар хэрэгжүүлж байгаа хүүхэд хөгжүүлэх хөтөлбөрт 302 хүүхдийг 100 байгууллага дааж авч, хүүхдийн эрх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, тэднийг хөгжүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.</p> <p>Урьд хөтөлбөрт хамрагдсан 578 хүүхдийн хөгжилд 4-р сард Хүүхдийн төлөө хэлтсийн ажилтнууд сум орон нутагт ажиллаж мониторинг хийсэн. Баянхонгор сумын шинээр сонгогдсон 150 хүүхдэд эх үрсийн баярыг тохиолдуулан эхний ээлжинд УИХ-ын гишүүн Г.Занданшатарын гарын бэлэг, 9-р сард 1-р ангид элсэн орсон 6 настай 1600 гаруй хүүхдэд хичээлийн хэрэглэл олгож сурах эрхэд нь дэмжиж, бүх сумын сургуульд шатрын сургалтын хэрэглэгдэхүүн олгож, сурагчдын оюун ухааныг хөгжүүлэх орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Хөтөлбөрт хамрагдсан 12 хүүхдийг зуны зусланд амраан зардалд нь ХХҮХэлтэс 576000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100%/</b></p>
	<p>5.1.3. Хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийлэл, хорт зуршилд автсан залуучуудыг нийгэмшүүлэх, иргэний боловсрол олгох, залуучуудад гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд, өсвөр үеийг хариуцлагатай, бүтээлч, тусч энэрэнгүй, тодорхой зорилго, тэмүүлэлтэй амьдрах хүмүүжил олгох, нийгмийн идэвхтэй иргэн болгож төлөвшүүлэх чиглэлээр</p>	<p>3.0-5.0 сая төгрөгийн 5 төндэр зарлан сонгон шалгаруулалт хийж, хэрэгжүүлэн үр дүнг тооцсноор /</p>	<p>Хөтөлбөрийг сурталчлах, агуулга, зорилт үр дүн хэрэгжүүлэх төслийн талаар сумдын Засаг дарга, нийгмийн ажилатнуудад сургалт явуулснаар 1000 насанд хүрэгчид, 500 гаруй хүүхдэд танилцуулж, тэдний оролцоог бий болгож, хүүхдийн төлөө ажиллах сэтгэл зүйн орчинг бий болгов.</p> <p>ЗДТГ-ын цэргийн штаб, Нийтийн номын сан, МСҮТ-тэй хамтран Баянхонгор сумын 7 шилдэг гэр бүлийн туршлагыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.</p> <p>Үндсэн чиглэл хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж хүргүүлснээр анги бүр 5 шатар, 5 даам, 10 дээш хөлөгт тоглоомтой болох, сургууль бүр үндэсний хөгжимтэй, бүжиг, дууны хамтлагтай, хүүхдийн бүтээх чадварыг хөгжүүлэх дугуйлан секцийг хичээллүүлэх аянг сургууль бүр дээр нийгмийн ажилтны баг хариуцан хийж байна. Нийгмийн салбарын 14 хоногийн ажлын хүрээнд хүүхдийн баяраар нийгмийн</p>

	хувийн хэвшил, төрийн бус байгууллага, хувь хүмүүсийн дунд бүтээлийн болон ажил үйлчилгээний тендер зарлан гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлж, хамтран ажиллана.		салбарын бүх байгууллага хүүхдийн сэтгэлгээ оюуныг хөгжүүлэх төрөл бүрийн арга хэмжээг авч, 1500 гаруй хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн. Хүүхэд хөгжил, төлөвшлийг сайжруулах цогцолбор хөтөлбөрийг 2010 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 92 хувьтай байна. “Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлье” аймгийн 2009 оны зөвлөгөөний шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган аймгийн Гэмт хэргээс урьдчилан ажлыг зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд 11 хүүхдэд эрх зүйн туслалцаа үзүүлсэн ба Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 37 болон 40 дүгээр зүйлд заасан эрхүүдийг хангуулахад чиглэсэн үйлчилгээ үзүүлж хуулийн байгууллагад тухайн хүүхдийн нэрийн өмнөөс хүсэлт гаргаж ажилласнаар 8 хүүхдийн ял хойшлуулж хамт олны батлан даалтад өгч, нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлэв. Ажлын төлөвлөгөөний хэрэгжилт --- хувьтай байна. <b>/Хэрэгжилт 100%/</b>
	5.1.4. Залуу гэр бүл болон залууст хөрөнгө оруулалт хийсэн, тэдний нийгмийн оролцоог идэвхжүүлэх төрөл бүрийн ажил үйлчилгээ явуулж буй төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтэд дэмжлэг үзүүлнэ.	Залуучуудад хандсан арга хэмжээний хөрөнгийн өсөлт, ажлын үр дүнгээр	<b>Төр - Иргэний нийгэм - Хувийн хэвшил</b> -ийн гурван талт түншлэлийн хүрээнд олон нийтийн оролцоонд түшиглэсэн нийгмийн халамжийн үйлчилгээг нээлттэй, ил тод, өрсөлдөөнийг хангах зарчмаар орон нутгийн Төрийн бус байгууллагуудын дунд 15,0 сая төгрөгийн санхүүжилттэй төслийн уралдаан зарласны дагуу 5 төрийн бус байгууллагаас төсөл ирүүлсэнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх, орлого нэмэгдүүлэх, архинд донтогсодыг нийгэмшүүлж, ар гэрийн орлого нэмэгдүүлэх төслүүд дэмжигдэж санхүүжүүлсэн. Аймгийн ЗДТГ-ын ёслолын гэрийг түшиглэн “Гэр бүлд зөвлөгөө өгөх төв” байгуулан төрийн бус байгууллагууд ээлжээр сууж, хөдөлмөрчид, гэр бүлд зөвлөн туслах үйлчилгээг 3 сар үзүүлсэн. Гэвч төрийн бус байгууллагуудын ажил үүргийн хуваариас болоод ээлжээр суух нь бэрхшээлтэй болсон учраас ажиллахаа больсон. Цаашид орон нутгийн төсвөөс тодорхой санхүүжилт өгч, сэтгэл зүйч мэргэжилтэй хүнийг тогтмол ажиллуулах шаардлагатай нь үйл ажиллагааны явцад харагдсан болно. <b>/Хэрэгжилт 100%/</b>
	5.1.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм хамт олонд	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн бодит ажил	Аймгийн Засаг даргын 2010 оны 189-р захирамжаар “Бид эрхээ эдлэе, Баялагаа бүтээе” уриан дор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих, чадваржуулах “Хүртээмжтэй орчин” аянг зохион байгуулах

	<p>тулгуурлан сэргээн засах ажил үйлчилгээг өргөжүүлж, нийгмийн амьдралд эрх тэгш оролцох нөхцөл, боломжоор хангаж, тэдний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.</p>	<p>үйлчилгээний тоо, чанар, үр дүнгээр</p>	<p>төлөвлөгөө гарган, “Нийгмийн салбарын хөгжлийн хөтөлбөр”-ийн сангаас 707,0 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 350, 0 мянган төгрөг гарган, ХБХүүхэдтэй 100 ээжийг чуулган, телевизийн хэлэлцүүлэг орлого бий болгох чадваржуулах сургалт бүтээлийн үзэсгэлэн, хөдөлмөр эрхлэлүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог бий болгон, өөртөө туслах бүлгүүдийг үүсгэн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>Италийн АЙФО байгууллагын санхүүжилтээр 20 сумын Тэгш дүүрэн хороодын гишүүд болох багийн бага эмч болон өрхийн эмнэлгийн эмч нарыг оролцуулан “Хөгжлийн брэхшээлтэй иргэдийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах нь” сэдэвт чадваржуулах сургалтыг үндэсний сургагч багш нартай хамтран зохион байгуулж, 28 сургагч багш бэлтгэн, ЭМЯ-ны кодтой 1,5 цагийн кредиттэй сертификат олгож, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй ажиллах нөөцийг бэхжүүлсэн.</p> <p>Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээгээр хөгжлийн бэрхшээлтэй 20 хүнийг ядуурлаас гаргахаар дэмжсэн ба НХХЯ-наас зарласан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих уралдаан 4 төсөл явуулснаас 1 төсөл батлагдаж, 6 хүн ажлын байртай болсон. Хүнс хоол тэжээлийн хөтөлбөр амжилттай хэрэгжиж, тус хөтөлбөрийг халамжийн хуулийн өөрчлөлтөд тусган хэрэгжүүлэх талаар санал өгсөн.</p> <p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аймгийн чуулган зохион байгуулан, хөдөлмөрэрхлэлтийг дэмжих сангаас 2,0 сая төгрөг зарцуулан, иргэдийн оролцоо эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100 %/</b></p>
	<p>5.1.6. Ахмадуудаас бүрдсэн зөвлөгөө өгөх, мэдлэг, ур чадвар дамжуулах баг, хоршоо, нөхөрлөл байгуулах болон ахмадуудын хөгжлийн бүлгийг дэмжинэ.</p>	<p>Иргэний боловсролд ахмадуудын оролцоо нэмэгдснээр</p>	<p>Аймгийн Ахмадын хороо Нийгмийн хөгжлийн хэлтэс хамтран бүх сумын ахмадын хороодын дарга нарын сургалт семинарыг хийж 2009 оны ажлын тайланг сум бүрээр сонсон хэлэлцэж ажлаа дүгнэсэн ба Эрдэнэцогт, Баянлиг, Галуут, Баянбулаг сумын Ахмадын хороодын дарга нар, тэргүүлэгч Өлзий нарыг Ахмадын байгууллагын хүндэт тэмдэгээр, Бөмбөгөр, Баацагаан, Баянхонгор, Өлзийт, Баянцагаан, Жаргалант, Бууцагаан сумын ахмадын хороодын хүндэт өргөмжлөлөөр шагнаж урамшуулсан. Ахмадын байгууллагууд 2010 онд “Хөдөлгөөнийг эрхэмлэн эрүүлийг сахье” уриан дор үйл ажиллагаагаа явуулж, 18 ахмадын баг байгуулан ажиллаж, төрөл бүрийн арга хэмжээг хэрэгжүүлсэн. Энэ жил анх удаа “Монгол наадам” сэдэвт арга хэмжээг зохион байгуулан 2,0 сая</p>

			<p>төгрөг зарцуулсан.</p> <p>13 сум чийрэгжүүлэлтийн танхимаа ашиглан үйл ажиллагааг явуулж тогтмолжсон байна. Ахмадын хороодын дарга нарт Баянхонгор сумын ахмадуудын концерт, чийрэгжүүлэлтийн дасгалын багийн тоглолтыг үзүүлж бүх сум ийм багтай болох талаар санал болгосон ба чийрэгжүүлэлтийг багийн гишүүд хөдөө явж, хөдөлгөөнийн дасгалаа ахмадуудад зааж, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх нөхцлийг бүрдүүлсэн.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100%/</b></p>
<p>5.2. Хөдөлмөрийн насны хүн амыг зохистой ажлын байраар хангахад чиглэсэн бодлого баримталж, 2010 оны эцэст эдийн засгийн идэвхтэй хүн амаар тооцсон ажилгүйдлийн түвшинг 5.1 хувьд хүргэж, ядуурлыг бууруулна.</p>	<p>5.2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, энэ онд 1600-гаас доошгүй ажилгүй иргэдийг зохистой ажлын байраар хангаж, өрхийн амьжиргааг дэмжинэ.</p>	<p>70-аас доошгүй хувь нь тогтвортой ажлын байраар хангагдснаар.</p>	<p>Тус хөтөлбөрийг Аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүдийн хуралдаанаар хэлэлцүүлж, Засаг даргын 2010 оны 128-р захирамжаар батлуулан, бүх сумдад хүргүүлсэн ба хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмжийг боловсруулан хүргүүлж хэрэгжилтийг Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс тооцон ажилласнаар 1610 хүнийг ажлын байртай болгосны 740 хүн бувуу 70,9 хувь нь байнгын ажилтай болсон.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100%/</b></p>
	<p>5.2.2. “Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан мэргэжилтэй ажилтанг бэлтгэх, хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 625 ажилгүй мэргэжилгүй иргэдэд мэргэжил эзэмшүүлнэ.</p>	<p>Сургалтад хамрагдсан иргэдийн 70 хувь нь ажлын байртай болсноор.</p>	<p>Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 20 сумын 638 иргэнийг 7 сургалтын байгууллагаар мэргэжил эзэмшүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 53,7 сая төгрөг, малчдын хоршоо бүлэг байгуулах сургалтаар 80 малчинг, бизнес эрхлэх сургалтаар 45 иргэнийг чадваржуулан 2,7 сая төгрөгийг зарцуулж, 73 хувийг ажлын байртай болгосон.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100%/</b></p>
	<p>5.2.3. Эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, малчид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлгүүдийн хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлж, дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p>	<p>Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрт хамрагдсан иргэдийн тоо өссөнөөр</p>	<p>Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд сумын 15 малчин өрхийг сонгон чадваржуулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрөл бүрийн арга хэмжээ авч хэрэгжүүлсний үр дүнд ядуурлаас гаргаж, бусдад загвар болгон туршлагыг түгээх ажлыг эхлүүлээд байна. Эдгээр арга хэмжээнд 2009-2010 онд 60,0 сая төгрөг зарцуулж, 30 хүнийг ажлын байрыг тогтворжуулсан. Аймгийн эмэгтэйчүүдийн холбооны дэмжлэгтэйгээр байгуулагдсан эмэгтэйчүүдийн 3 бүлгийн 18 иргэнд өрхийн бизнес эрхлэхэд нь зориулж 900,0 мянган төгрөгний дэмжлэг үзүүлсэнээр 18 ажлын байр шинээр, бизнес эрхлэгч 48 эмэгтэйд ХЭДСангаас 78,6 сая төгрөгийн зээл олгож, 69 ажлын байр, ОНОТХУ-ийн хүрээнд бизнес эрхлэхээр төсөл ирүүлсэн 19 өрхийн иргэдийн 6 бүлэгт 6,0 сая төгрөгийн</p>

			<p>бизнесийн гарааны дэмжлэг үзүүлж, 20 ажлын байр бий болгосон. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрөл бүрийн арга хэмжээний хүрээнд 82 залуу байнгын болон түр ажлын байранд зуучлагдаж, мэргэжил олгох сургалтанд 228 залуу хамрагдаж төгссөн байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдахаар Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны эцэг эхчүүдийн 3 бүлгийн 18 иргэн, өрхийн үйлдвэрлэл явуулахаар, мөн газар тариалан эрхлэхээр 2 ХБИ, мод модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахаар 3 иргэн төслөө ирүүлсэний дагуу төслийг Баянхонгор сумын АДЗ-ийн хурлаар хэлэлцүүлж, халамжийн сангийн санхүүжилтээр 3,9 сая төгрөгийг ажлын байр бий болгож, өрхийн амьжиргааг нь дээшлүүлэх зорилгоор олголоо.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100%/</b></p>
	<p>5.2.4. Аймгийн хэмжээнд ядуу 450 өрхийг сонгон, ур чадвар эзэмшүүлэх, мэргэжил олгох болон жижиг зээлийн үйлчилгээнд хамруулах замаар өрхийн амьжиргааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>Дундаж орлоготой өрхийн тооны өсөлтөөр</p>	<p>Аймгийн хэмжээнд 450 өрхийг ядуурлаас гаргах зорилтын хүрээнд сум бүрт 20 өрхийг, Баянхонгор суманд 70 ядуу өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхээр сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулан ажиллаж, эдгээр өрхийн гишүүдээс 235 иргэнийг чадваржуулах сургалтад, 132 иргэнийг мэргэжил олгох, бизнесийн санаа хөгжүүлэх сургалтад 19 иргэн, нийтийг хамарсан ажилд 18 сумын 108 иргэнийг хамруулсан ба ХЭДС-ийн жижиг зээлд 98 өрхийн 147 иргэнийг хамруулж 98,6 сая төгрөг олгож 147 ажлын байр гаргаж нийт 375 өрхийн 595 хүний орлогыг нэмэгдүүлсэн. Өлзийт, Жаргалант, Бууцагаан, Богд, Баянлиг сумдын Засаг дарга нарын харъяа нутаг нутаг дэвсгэртээ ажилгүйдэл ядуурлыг бууруулах талаар авч хэрэгжүүлж байгаа ажлын тайлан авч, зөвлөмж өгсөн ба 12 сард Засаг даргын зөвлөлд оруулахаар бэлтгэж байна</p> <p><b>/Хэрэгжилт 100%/</b></p>
<p>5.3. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах, аюулгүй байдал, үйлдвэрлэлийн осол, эрүүл ахуйн хууль тогтоомжийг мэргэжлээс шалтгаалсан хэрэгжүүлэхэд сэргийлэх сургалт нийгмийн сурталчилгааны ажилд аж түншлэлийг ахуйн нэгж, байгууллага,</p>	<p>5.3.1. Хөдөлмөрийн болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажилд аж ахуйн нэгж, байгууллага,</p>	<p>Ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлснээр</p>	<p>Аймгийн нийгмийн түншлэлийн 3 талт 2 жилийн гэрээг дүгнэж, дараагийн 2 жилийн гэрээг байгуулан НХХЯ-аар баталгаажуулан хэрэгжүүлж эхэлсэн. Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах аймгийн зөвлөлийг 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллуулж, аж ахуй нэгж, байгууллагын иргэдээс хөдөлмөрийн цалин хөлстэй холбоотой ирсэн --- өргөдлийг шийдвэрлэсэн. Гэрээний хүрээнд “Гурван талт түншлэлийг хөгжүүлэх замаар орон нутагт ядуурал, ажилгүйдлийн түвшинг бууруулах нь “ хэлэлцүүлэгийг 3-р сарын 11-13 хооронд “Мерси кор” ОУБайгууллагатай хамтран зохион байгуулж, төрийн бараа ажил үйлчилгээг нээлттэй ил тод өрсөлдөөнтэй болгох арга</p>

хөгжүүлнэ.	хувийн хэвшил, иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлнэ.		замууд, төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагууд, бизнес эрхлэгчдээр гүйцэтгүүлэх боломжуудыг гарган тавьсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>
5.4. Нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтод бүлэгт хүргэх арга зүй, зохион байгуулалтыг сайжруулж, чанар хүртээмжийг дээшлүүлнэ.	5.4.1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хэлбэрийн хүүхдийн асаргаа үйлчилгээний төв”-ийг ашиглалтад оруулна.	Ашиглалтад оруулснаар	Барилгын гүйцэтгэлийн ажил 100 хувь баригдсан. Төвийн статусыг тодорхойлох, санхүүжилтийг 2011 оны төсөвт суулгах талаар Санхүү төрийн сангийн хэлтэст хүсэлт, материалуудыг хүргүүлсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b>
5.5. Иргэдээ даатгалд бүрэн хамруулж, тэдний нийгмийн баталгааг найдвартай хангана.	5.5.1. 1960 оны 1-р сарын 1-нээс хойш төрсөн малчин, албан бус секторт хөдөлмөр эрхлэгч, ажилгүй иргэн, жижиг аж ахуй эрхлэгчдийн 20 хувийг сайн дурын даатгалд хамруулна.	20 хувийг сайн дурын даатгалд хамруулснаар	Энэ онд сумдын байцаагчдын үр дүнгийн гэрээнд заалт болгон оруулж, иргэдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөөтэй ажилласнаар 1960 оноос хойш төрсөн малчин албан бус секторт хөдөлмөр эрхлэгч , ажилгүй иргэн, жижиг аж ахуй эрхлэгчд нийт 7829 хүнээс 875 хүн хамруулж 11.2 хувийг хамруулсан байна. Ард иргэдэд нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн хууль тогтоомжийг сурталчлан таниулж, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулах зорилт тавин ажилласанаар 71 удаагийн мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулж 43261 хүнд хүрч ажилласны үр дүнд 1701 хүн сайн дурын даатгалд хамрагдаж, 183,3 сая төгрөгийн, эрүүл мэндийн даатгалд 13420 хүн хамрагдаж 80,5 сая төгрөгийн орлого оруулсан. Нийгмийн даатгалын шимтгэл 3751,4 сая төгрөг оруулахаас 3964,5 сая төгрөг оруулж, 105,6 хувиар биелүүлсэн ба хуримтлагдсан .Шимтгэлийн өр авлага 128,4 сая төгрөг байна. <b>/Хэрэгжилт 100%/</b>
	5.5.2. Хүн амын дундах буруу регистртэй даатгуулагчдын тоог холбогдох байгууллагуудын оролцоотойгоор 1.5 хувийг бууруулна	Иргэдийн эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын үйлчилгээ авах боломжийг бүрдүүлснээр	

	5.5.3. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлага шинээр үүсгэхгүйгээр урьд онуудын өр авлагыг 25 хувиар бууруулна.	Урьд оны өр авлага 25 хувиар буурснаар	Нийгмийн даатгалын шимтгэлийн он дамжсан өртэй Номгон хайрхан ХХК-г Цагдаагийн байгууллагад шилжүүлэн 25,0 сая төгрөгийн өрийг барагдуулсан ба нийт өрийн 33.2 хувийг барагдуулсан байна. <b>/Хэрэгжилт 100%/</b>
	5.5.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг байрыг шийдвэрлэнэ.	Байртай болсноор	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын байрыг одоогоор санхүүгийн асуудал нь шийдэгдээгүй учраас хийгдээгүй байна. <b>/Хэрэгжилт- 0%/</b>
<b>ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>			
6.1. Татварын баазыг өргөтгөн нягтлан бодох бүртгэл, статистик мэдээ, мэдээллийн чанар, хамралтын хүрээг нэмэгдүүлж, нэгдсэн сүлжээнд оруулан, орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь жигд	6.1.1. Төсвийн дунд хугацааны төлөвлөлт хийж батлуулна.	Төсвийн дунд хугацааны төлөвлөлт хийж батлуулснаар	2010 6,7-р сард 2011, оны төсвийн төсөл, 2012, 2013 оны төсвийн төсөөллийг сум байгууллага бүрээс бүрэн хүлээн авч хянаж нэгтгэн 2010 оны 8 дугаар сарын 20 нд Сангийн яаманд хянуулж нэгтгэлд өгсөн. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	6.1.2. Хөрөнгө оруулалтаар бий болсон оюуны өмчийг тоолох , бүртгэх үнэлэх, эзэмшигчийг тогтоох, санхүүгийн тайланд тусгах , хадгалах журмыг боловсруулна.	Журмыг боловсруулснаар	Оюуны өмчийг тоолох, бүртгэх, үнэлэх талаарх сургалтыг 2010 оны 5 сард зохион байгуулсан. Оюуны өмчийг тоолох, бүртгэх, үнэлэх, эзэмшигчийг тогтоох, санхүүгийн тайланд тусгах, хадгалах журам боловсруулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>

<p>биелүүлж, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулна.</p>	<p>6.1.3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшлийн үндсэн хөрөнгөд судалгаа хийж илүүдэлтэй хөрөнгийг бусад хөрөнгө дутагдалтай газар шилжүүлэн ашиглуулна.</p>	<p>Хөрөнгийг шилжүүлэн ашиглуулснаар</p>	<p>а.ХХААЖДҮГ-ын хуучин конторын барилгын 3 өрөөг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 78 дугаар тогтоолоор байгуулагдсан “Хот тохижилт үйлчилгээ” орон нутгийн өмчит үйлдвэрийн газарт конторын зориулалтаар</p> <p>б.Жинст сумын ИТХ-аас ирсэн хүсэлтийн дагуу Жинст сумын ЗДТГ-ын үйлчилгээнд ашиглагдаж байгаа Террона-3 маркийн автомашиныг сумын ИТХ-ын албаны үйл ажиллагаанд эзэмшүүлэхээр шийдвэр гаргах саналыг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдэд нь хүргүүлээ.</p> <p>в. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 55 дугаар тогтоолоор Төрийн өмчөөс орон нутгийн өмчид шилжиж ирсэн барилгыг Баянхонгор сумын ахмадын зөвлөл болон багуудын төвд конторын зориулалтаар ашиглуулахаар балансаас балансад шилжүүлсэн</p> <p>г.Аймгийн Засаг даргын тамгын газарт илүүдэлтэй байсан 10 ширхэг компьютерыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 154 дүгээр тогтоолоор Баацагаан, Эрдэнэцогт, Бөмбөгөр, Гурванбулаг, Баян-Өндөр сумуудад балансаас балансад шилжүүлж хүлээлгэн өгсөн./жагсаалтаар/</p> <p>д. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 154 дүгээр тогтоолоор аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчилгээнд ашиглагдаж байсан 00-04 БНА улсын дугаартай УАЗ-469 31519 маркийн автомашиныг Баянхонгор аймгийн “Хот тохижилт үйлчилгээ” ОНӨҮ-ийн газрын үйлчилгээнд зориулан балансаас балансад шилжүүлж хүлээлгэн өгсөн.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
---	---	--	--

	<p>6.1.4. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг эрчимжүүлэн мэргэшсэн, тэгш шударга үйлчилгээг эрхэмлэж олон нийтийн итгэлийг олж улмаар татварын хууль тогтоомжийн биелэлт сайжирснаар татвар төлөхөөс зайлсхийх явдал буурсан байна</p>	<p>Улсын болон орон нутгийн орлогын төлөвлөгөөг 100-аас доошгүй хувиар биелүүлснээр</p>	<p>Татварын ерөнхий хуулийн 8-р зүйлийн татвар хураалтын процессын дагуу татварын өртэй ААН, иргэний нийт 89879,3 мянган төгрөгийн татварын өрийг төлүүлэхээр шүүхэд хандаад байна. Татвар төлөгч “Номгон хайрхан” ХХК нь НӨАТатвараар хамгийн их өртэй буюу нийт 80839,2 мянган төгрөгийн өртэй байгаа бөгөөд аймгийн ҮХЭХБГазраас тухайн компанийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг гаргуулан авч шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор ИХШХШТХуулийн 69-р зүйлийн 69.1.1 дэхь хэсэгт заасны дагуу шүүхэд үл хөдлөх хөрөнгийг нь битүүмжлэх хүсэлт гаргаад байна. 2010 оны байдлаар ШШГА-нд нийт 9 ААН, иргэний 97442,7 мянган төгрөгийн өр байгаагаас 4794,9 мянган төгрөг барагдаж 92547,8 мянган төгрөг ШШГАжиллагаа хийгдэж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт- 90% /</b></p>
	<p>6.1.5. Татвар төлөгч аж ахуйн нэгж, иргэн бүр өөрийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх тааламжтай нөхцөл бүрдүүлж, татвар төлөгч бүртэй тэгш шударга харьцах, хуулиар тогтоосон татвараа төлөхөд нь туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ хууль тогтоомжийг биелүүлээгүй тохиолдолд хариуцлага ногдуулж ажиллана.</p>	<p>Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ тогтмолжиж, тэдний сэтгэл ханамжийг нэмэгдүүлж, байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй болсноор</p>	<p>Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээг хөнгөн шуурхай болгох, татвар төлөгчдөд нэг цэгээс үйлчлэх үйлчилгээг нэвтрүүлэн нээлттэй болгох зорилгоор татвар хураалтын үйл ажиллагааны журам, татвар төлөгчдөд нэг цэгээс үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журмыг шинээр боловсруулан баталж үйл ажиллагаандаа баримтлан ажиллаж байна.</p> <p>Татварын Ерөнхий газрын 2010 оны 08 дугаар сарын 19-ний 419 тоот тушаалыг үндэслэн Хэлтсийн даргын нэрэмжит дотоод хяналт шалгалтын удирдамжит ажлыг Баян-Өндөр, Баянговь, Баянлиг, Богд, Жинст гэсэн 4 сумдад 2010 оны 10 дугаар сарын 15-23-ны өдрүүдэд ажлын хэсэг томилон амжилттай зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	<p>6.1.6. Татварын байгууллага өөрт байгаа мэдээ мэдээлэл, мэдлэгээ татвар төлөгчидтэй хуваалцах, тэдний татвар төлөх үүргээ биелүүлэхэд нь туслалцаа үзүүлж тэднийг алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх зарчмыг баримталж ажиллана.</p>	<p>Татвар төлөгчдөд үзүүлэх үйлчилгээ хөнгөн шуурхай болж татвар төлөгчдийн татвар төлөх, тайлагнах сэтгэлгээ төлөвшиж хууль зөрчих явдал эрс буурснаар</p>	<p>Татварын ногдуулалт, хураалтын мэдээллийг зохих программд хуулийн хугацаанд үнэн зөв оруулж хэлтсийн болон сум орон нутгийн удирдлага, татвар төлөгч, иргэд аж ахуйн нэгж, байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллаж байна. Аймгийн татварын орлого төвлөрүүлэх данснуудыг харилцагч байгууллагуудын мэдээллийн самбарт байрлуулан, цахим тайлан илгээх нууц үг, татварын өрийн үлдэгдэл болон бусад мэдээллийг утсаар болон биечлэн өгч ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

	<p>6.1.7. Аймгийн нийгэм эдийн засгийн статистикийн мэдээллийн үзүүлэлтийн тоо, нэр төрлийг нэмэгдүүлж хамралтыг сайжруулан мэдээллээр хангана.</p>	<p>Мэдээллийн чанар хүртээмж сайжирч мэдээллийн санг бүрдүүлснээр</p>	<p>Хүн ам орон сууцны улсын тооллогын бэлтгэлийг хангах, зохион байгуулан явуулах улсын комисс Монгол улсын ерөнхий сайдаар, аймгийн комисс аймгийн Засаг даргаар ахлуулан байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд Сумдын тооллогын комисс, аймгийн түр товчооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 242 тоот захирамжаар батлан хэрэгжүүлж энэ дагуу нийт сумдад комисс, түр товчоод байгуулагдан үйл ажиллагаагаа явуулав. Аймгийн тооллогын комиссын анхны хуралдаанаар сумдыг гишүүдэд хуваарилан хариуцуулж ажилласан. Орон сууц, хашаа, гудамжны нэр хаягийг цэгцлэх, иргэний анхан шатны бүртгэлийг чанаржуулах, тооллогын зардлыг батлуулах, тооллогын ажилтныг сургах, тооллогын материалыг хуваарилан хүргүүлэх талаар төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж, бэлтгэл ажлыг хугацаанд нь бүрэн хангасан. Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийг сурталчилан таниулах ажлыг хийж, сумын Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, иргэний бүртгэл мэдээллийн ажилтан нарын сургалт семинарыг зохион байгуулж сумынхыг бүрэн хамруулсан. Тооллогод зориулсан Хүн амын урьдчилсан бүртгэлийг хугацаанд нь зохион байгуулж, дүн мэдээг хугацаанд нь Үндэсний Статистикийн Хороонд мэдээлсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	<p>6.1.8. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн урт хугацааны зээлийн ашиглалт, эргэн төлсөн байдлын талаар судалгаа дүгнэлт гаргаж тодорхой санал боловсруулан холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлнэ.</p>	<p>Үйл ажиллагааны үр дүнгээр</p>	<p>ОНӨ-т аж ахуйн нэгжүүдийн урт хугацаат зээлийн өнөөгийн байдлын талаарх гүйцэтгэх захирлуудын сонголыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцээд урт хугацаат зээлийн ашиглалт, эргэн төлөлтийн байдалд дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг тус Тэргүүлэгчдийн 2010 оны 54 дүгээр тогтоолоор томилон ажиллуулж байна. Ажлын хэсгийн тайлан 2010.12.16-ны аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэгдэнэ. <b>/Хэрэгжилт-100%/</b></p>

	<p>6.1.9. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон хандив, зээл, тусламжийн хөрөнгөөр бий болсон орон нутгийн өмчийг хүлээн авах, бүртгэх, эзэмшигчийг тогтоох, эзэмшил, ашиглалтад нь хяналт тавих явцад үүсэх маргааныг зохицуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.</p>	<p>Эрх зүйн орчин бүрдснээр</p>	<p>ОНӨ-т аж ахуйн нэгжүүдийн урт хугацаат зээлийн өнөөгийн байдлын талаарх гүйцэтгэх захирлуудын сонголыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцээд урт хугацаат зээлийн ашиглалт, эргэн төлөлтийн байдалд дүн шинжилгээ хийх ажлын хэсгийг тус Тэргүүлэгчдийн 2010 оны 54 дүгээр тогтоолоор томилон ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	<p>6.1.10. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн эрх баригч нартай "Өмч эзэмшлийн гэрээ"-г байгуулж, гэрээний заалтыг биелүүлээгүй, өмч хөрөнгө үрэгдүүлсэн, дутагдуулсан, бүртгэл тайланд тусгаагүй, хууль бусаар зарцуулсан буруутай этгээдэд гэрээ болон зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.</p>	<p>Өмчийн эзэмшлийн гэрээний хэрэгжилтийг</p>	<p>1. Төсвийн Ерөнхий менежерүүдийн үр дүнгийн гэрээнд өмч эзэмшлийн гэрээг байгуулах талаар тусгай заалтыг оруулсан.</p> <p>2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдтэй байгуулах өмч эзэмшлийн гэрээний загварыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 53 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар, гэрээний биелэлтийг дүгнэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлуулж байгууллагын дарга нягтлан бодогч нартай өмч эзэмшлийн гэрээг байгуулан ажиллаж байна.</p> <p>3. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өөрийн эзэмшлийн эд хөрөнгийг түрээсээр ашиглуулах журмыг 2009 оны 19 дүгээр тогтоолын нэгдүгээр, түрээсийн төлбөрийн доод үнийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлуулж төсөвт байгууллагуудын түрээсээр ашиглуулж байгаа хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулж байгаад хяналт тавин ажиллаж байна. 2010 онд Түрээсийн гэрээний зохих заалтуудад өөрчлөлт оруулах талаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн батлуулсан.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

<p>6.2. Малын индексжүүлсэн даатгалын тогтолцоог бүрдүүлэх нутгийн захиргаа, даатгалын компаниуд малчид, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулж, журмын дагуу нөхөн төлбөр олгоно.</p>	<p>6.2.1. Малын индексжүүлсэн даатгал төслийг туршиж хэрэгжүүлэхэд орон нутгийн оролцогч талуудын оролцоог нэмэгдүүлж, даатгуулагчдын хамралтын хүрээг нэмэгдүүлэх, нөхөн төлбөр олгох босго үзүүлэлтийг тогтооно.</p>	<p>Сум орон нутгийн удирдлага малчдын МИД-ын талаарх мэдлэг, хандлага өөрчлөгдөж даатгуулагчийн тоо нэмэгдсэнээр</p>	<p>Малын индексжүүлсэн даатгалнь Үндсэн даатгалын бүтээгдэхүүн, Гамшигаас хөнгөвчлөх бүтээгдэхүүн гэсэн 2 бүтээгдэхүүнтэй байсныг 2010 оноос эхлэн “Малын эрсдлийн даатгал” гэсэн нэг бүтээгдэхүүнтэй болж 9 аймагт хэрэгжлээ. 2010 оны борлуулалтын улиралд “Монгол даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Прайм даатгал” ХХК, “Практикалдаатгал” ХХК-нууд малын эрсдлийн борлуулалт хийх эрхийг авч Санхүүгийн зохицуулах хороо, МИДТХН-ээс зохион байгуулсан даатгалын төлөөлөгчдийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 85 төлөөлөгч МЭД-ын борлуулалт хийх эрх авч ажилласнаас Монгол даатгал ХХК 844, Бодь даатгал ХХК 660, Прайм даатгал 224, Практикал даатгал ХХК 155 бүгд 1883өрх буюу нийт малчин өрхийн 16,24 хувийг МЭД-д хамруулж 196,906,260,55 төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны үндсэн даатгалын бүтээгдхүүнд даатгуулсан өрхөөс 131 өрхөөр, малчин өрхийн хамралтын хувь 1,13 хувиар хураамжийн орлого 46,4 сая төгрөг буюу 31 хувиар тус тус өссөн байна</p> <p>Баянговь, Өлзийт, Шинэжинст, Богд, Хүрээмарал сумдын малчин өрхийн хамралт өссөн боловч Баян-Овоо, Бөмбөгөр, Баацагаан, Баянцагаан, Баян-Өндөр сумуудад урд оны хамралтаас 13-6 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Малын индексжүүлсэн даатгал төслийн хэрэгжилтийнталаар аймгийн ИТХТ-ээр хэлэлцэж тус аймагт малын индексжүүлсэн даатгал төсөл хангалттай сайн хэрэгжиж байгааг тэмдэглэж “Малын индексжүүлсэн даатгалын үйл ажиллагааг дэмжих тухай” аймгийн ИТХТ-ийн тогтоол гарч аймаг сумын Засаг дарга, МЭД-ыг борлуулагч даатгалын компаниудад уг ажлыг эрчимжүүлж ажиллахыг үүрэг болгож, малчид иргэдэд малаа даатгуулж заншихыг зөвлөв.</p> <p style="text-align: right;"><b>/ Хэрэгжилт 100%/</b></p>
<p>6.3. Төлбөр тооцооны шуурхай байдлыг сайжруулж зээлийн үйлчилгээг нэмэгдүүлж ажлын байрыг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.</p>	<p>6.3.1. Хөдөө сумдад Мобайл банкны үйлчилгээг сурталчлан, франчайзын үйлчилгээтэй хадгаламж зээлийн хоршоог нэмэгдүүлнэ.</p>	<p>Нэгдсэн мэдээлэлтэй болсноор</p>	<p>Хас банкны мобайль банкны Амар үйлчилгээ нь сүлжээ харгалзахгүйгээрээ давуу талтай бөгөөд хөдөө сумдын иргэдэд сургалт сурталчилгааг байнга хийж өргөнөөр ашиглаж байна. 2010 оны эхэнд Амар үйлчилгээний хэрэглэгчийн тоо 685 байсан бол 2010.10.31-ний байдлаар 1432 болж 109 хувиар нэмэгдсэн байна. ХААН банкны мобайль банкны үйлчилгээ нь Мобикомын сүлжээ орсон сумдын иргэд ашиглаж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд энэ үйлчилгээгээр 20541 мянган харилцагч үйлчлүүлж гүйлгээний тоо оны эхэн үеэс 22 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

**ГУРАВ. ХӨГЖЛИЙН БОДЛОГО**

7.1. Газрын харилцааны менежментийг боловсронгуй болгож, газар хамгаалах, нөхөн сэргээх сантай болж, мэдээллийн нэгдсэн сангийн сүлжээнд холбогдоно.	7.1.1. Сумдын анхан шатны мэдээллийг цахим хэлбэрт оруулж, нэгдсэн мэдээлэлтэй болно. .	Нэгдсэн мэдээлэлтэй болсноор	Үндэсний газрын мэдээллийн санд холбогдох бэлтгэл ажлыг ханган Газар эзэмшигч, өмчлөгч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрээр хувийн хэргийг баяжуулан, сум тус бүрээр мэдээллийг цахим хэлбэрээр мэдээллийн санд оруулан нэгтгэж холбогдоход бэлэн болсон байна. <b>/Хэрэгжилт- 100%/</b>
	7.1.2. Боломжтой сумдын газрын мэдээллийн санг улсын мэдээллийн сангийн сүлжээтэй холбох арга хэмжээ авна	Сүлжээнд холбогдсоноор	Үндэсний газрын мэдээллийн системийг улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд хийсэн сургалтад мэдээлэл технологийн ажилтан, кадастрын мэргэжилтэн болон бүх сумдын даамлууд хамрагдсан бөгөөд Компьютерийн программ хангамжийн мэргэжилтэй боловсон хүчнийг мэдээлэл технологийн ажилтанаар авч ажиллуулан сүжээнд холбогдох боломжтой Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Баянхонгор сумууд сүлжээнд холбогдсон байна <b>/Хэрэгжилт-100%/</b>
	7.1.3. Гэр болон орон сууцны хороолол байгуулах газрыг шинээр төлөвлөж, улсын чанартай авто замын дагуу иргэдэд газар өмчлүүлнэ.	Шинээр газрыг төлөвлөж инженерийн шугам сүлжээг шийдсэнээр хороолол байгуулах ажлыг эхлүүлэх, газар өмчлүүлэх	Өлзийт сумын Цагаан даваа орчмын газарт хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж байгаа бөгөөд, Өлзийт сумын Хар хошуу, Бууцагаан сумын Байдрагийн гүүрэн дээр газар өмчлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган, Байдрагийн гүүрэн дээр 10 иргэнд өмчлүүлж, 2011 онд байр зүйн зураг, Ерөнхий төлөвлөгөө, инженер геологийн судалгаа хийлгэх хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
7.2. Барилга, хот байгуулалтын бодлогыг оновчтой төлөвлөн зохион байгуулж,	7.2.1. Төв суурин газрын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж, ногоон байгууламжуудыг нэмэгдүүлнэ.	Хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, байгууламжуудын ажлыг эхлүүлснээр	Аймгийн Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөө, хотын Ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан тухайн жилийн аймгийн ГЗБ-ын төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 06, 61 дүгээр тогтоолоор батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>

хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлнэ.	7.2.2. "Хонгор -1000" орон сууцны хороолол байгуулах ажлыг төлөвлөж инженерийн шугам сүлжээ нь бүрэн шийдвэрлэгдсэн хорооллын эхний ээлжийн барилгын ажлыг эхлүүлнэ.	Инженерийн шугам сүлжээ болон хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлж ажил эхэлснээр	"Хонгор -1000" орон сууцны хороолол барих газрын байршлыг 3-р багийн нутаг дэвсгэрт 4-р сургуулийн орчимд сонгож байршлын зургийг гаргаж, төлөвлөлтийн ажлыг хийсэн. Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "100 мянган айлын орон сууц" хөтөлбөр төслийн хүрээнд /2010-2015 онд/ 200 айлын орон сууц, 440 хүүхдийн сургууль, 50 хүүхдийн цэцэрлэг, 120 хүнд үйлчлэх хүчин чадалтай ахуйн үйлчилгээний төв, 300 суралцагчтай МСҮТөв, өдөрт 30 хүнд үзлэг хийх хүчин чадалтай өрхийн эмнэлэг барихаар төлөвлөгдсний дагуу барилга байгууламжийн байршлын зураг гаргаж саналаа холбогдох газарт хүргүүлсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	7.2.3. Газрын доорхи барилга, байгууламжийг тоолж бүртгэлжүүлж засварлах, шинэчлэх, хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажилд хяналт тавих ажлыг зохион байгуулна.	Бүртгэлжүүлж, ажил зохион байгуулснаар	2011-2013 онд Азийн хөгжлийн банкны хөнгөлттэй зээлээр хэрэгжих "Хот байгуулалтын салбарын МОН-2301" төслийн хүрээнд 1.0 сая ам \$-ын санхүүжилтээр аймгийн төвийн усны эх үүсвэр, цэвэр, бохир усны шугам сүлжээг өргөтгөх, гэр хороололыг шугам сүлжээнд холбох, цэвэрлэх байгууламжийг өргөтгөх ажлын зураг төсвийг "Инж байгууламж " ХХК гүйцэтгэж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
8.1. Хот хоорондын болон орон нутгийн зорчигч, шуудан тээвэрт үйлчилгээний дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлнэ.	8.1.1. Зорчигчийн тийз бичилтэнд онлайн сүлжээг нэвтрүүлж, автобусны үйлчилгээний тоо чанарыг нэмэгдүүлснээр хот хоорондын нийтийн зорчигч тээврийн хүртээмжийг дээшлүүлнэ.	Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний чанарт ахиц гарснаар	"Баянхонгор тээвэрчин" хоршоо, "ЛОТОТ "ХХК-ны удирдлагууд хот хооронд нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг жолооч нарыг оролцуулан /48 хүн/ сахилга хариуцлагыг дээшлүүлэх уулзалт ярилцлагыг хууль хяналтын байгууллагатай хамтран зохион байгуулсан. 2010 онд том оврын 6 автобус шинээр авч парк шинэчлэлт хийсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	8.1.2. Орон нутгийн нийтийн тээвэр, сумдын зорчигч шуудан тээвэрлэлтийг төвлөрсөн зогсоол талбайгаас явуулж, бүртгэл хяналтын шинэ тогтолцоонд оруулна.	Тээвэр зохицуулалтын нэгдсэн зохион байгуулалтанд орсноор	Орон нутгийн зорчигч болон шуудан тээвэрлэлтийн ажлыг шуудан үйлчилгээний албанд хариуцуулж 2010 оны 4 сарын 1 нээс нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна. Таксинуудыг аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд оруулах ажлыг шуудан үйлчилгээний газар зохион байгуулж байна. Дүнг оны эцэст дүгнэнэ. <b>/Хэрэгжилт-70%/</b>

8.2. Техникийн хяналт оношлогоо, бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг жилийн турш явуулна	8.2.1. Тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилгаж, үнэн зөв мэдээллийн санг бүрдүүлж, тээврийн хэрэгсэлд тавигдах стандарт шаардлагыг чангатгана.	Тээврийн хэрэгслийн оношлогоо чанаржиж, бүртгэл мэдээлэл боловсронгуй болсноор	Тээврийн хэрэгслэлийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох, шилжилт хөдөлгөөнт хийх үйлчилгээг мобикомын интернет сүлжээгээр хийж байна. Нийт 7175 тээврийн хэрэгсэл үзлэг оношлогоонд ороод байгаа нь өнгөрсөн жилтэй харьцуулахад 1674-өөр илүү буюу 137.2 хувьтай байна. Урьд нь ЗЦГ-ын сүлжээ ашиглаж байсан бол 09 сараас эхлэн авто тээврийн газрын тээврийн хэрэгслийн бүртгэлийн VRS программыг шинээр ашиглаж бүртгэлийн мэргэжилтнүүдээ сургалтанд хамруулаад байна. <b>/Хэрэгжилт 100%/</b>
8.3. Авто зам барих, засварлах, арчилж хамгаалах, хөрөнгө бүрдүүлэх замаар орон нутгийн замын нөхцлийг сайжруулна	8.3.1. Хотын доторх хатуу хучилттай автозам, явган хүний зам 10000м <sup>2</sup> тавьж, замын гарц, автобусны буудал, замын байгууламж, тэмдэг тэмдэглэгээг хийж засварын ажлыг гүйцэтгэнэ.	Хийж гүйцэтгэсэн ажлын хэмжээгээр	Хотын дотор 1 км хатуу хучилттай авто замын тендер зарлан “МОПРОУД” ХХК гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулаад байна. 425 м урттай явган хүний замыг “Жигүүр богд” ХХК гүйцэтгэсэн. Мөн “Ганмөнхжин” ХХК эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр 5000 м явган зам төвих гэрээ байгуулсанаас энэ онд 500 м явган хүний зам тавиад байна. <b>/Хэрэгжилт -100%/</b>
	8.3.2. Орон нутгийн авто зам ашигласны төлбөр, хураамж авах журмыг боловсруулж мөрдөж эхэлнэ.	Журам батлуулж хэрэгжиж эхэлснээр	Аймгийн Засаг даргын 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 248 дугаар захирамж гарч орон нутгийн зам ашигласны төлбөр хураамж авах журам, төлбөрийн хэмжээг тогтоож өгсөн. Мөн аймгийн Хөгжлийн бодлогын хэлтэсээс орон нутгийн замын санд автозам ашигласаны төлбөр, хураамж төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах зөвлөмж гарган хэрэгжүүлж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	8.3.3. Галуут сумын “Нартын хясаа”-ны замыг засварлана.	Зам засварлагдсанаар	Галуут сумын “Нартын хясаа”-ны зам засварын ажилд “Замын сан”-аас 5,0 сая төгрөг төсөвлөж багийн иргэдийн оролцоонд тулгуурлан гүйцэтгэсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b>
8.4. Шуудан үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлнэ	8.4.1. Орон нутгийн шуудан хүргэлт, зорчигч тээврийн үйлчилгээг тодорхой графикайн дагуу 7 хоногт 1-ээс доошгүй удаа явуулж хэвшүүлнэ.	Шуудан хүргэлтийн үйлчилгээ шуурхай графикайн дагуу хүргэгдэж хэвшсэнээр	Аймгийн Засаг даргын захирамжаар үйлчлүүлэгчийн тарифийг батлуулан мөрдөж байна. Хөдөө сумдад шуудан хүргэлт зорчигч тээврийн үйлчилгээг 7 хоногт 2 удаа явуулж хэвшлээ. <b>/Хэрэгжилт 100%/</b>
	8.4..2. Шуудангийн автопаркийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Автопарк шинэчлэгдсэнээр	Авто парк шинэчлэлт хийгээгүй. /Хөрөнгө санхүүгийн чадавхиас шалтгаалан хийгдээгүй./ <b>/Хэрэгжилт 0/</b>

<p>9.1. Газар тариалангийн, ялангуяа усалгаатай тариалан, хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхийг бодлогоор дэмжинэ.</p>	<p>9.1.1. Төмс хүнсний ногоо, чацаргана, тэжээлийн ургамлын тариалалтыг өрнөжүүлэн га-гаас авах ургацыг нэмэгдүүлж, тариаланчдын тоог өсгөнө.</p>	<p>296 га-д төмс, 120 га-д хүнсний ногоо, 100-аас доошгүй га-д тэжээлийн ургамал тариалсанаар</p>	<p>ХХААЖДҮ-ын салбарын удирдах ажилтан мэргэжилтний аймгийн зөвлөгөөнийг 2010 оны 3-р сарын 13-14-ны өдрүүдэд нийт сумын Засаг дарга, ХАА-н түшмэл, сумын агрономич, тариаланч ногоочин 76 хүнийг оролцуулан тариалангийн бэлтгэлийг эртнээс хангуулах, төмс хүнсний ногооны үрийн хангамжийн судалгаа гарган, дутагдах үрийн нийлүүлэлтийг хэрхэн зохион байгуулах талаар сургалт, зөвлөгөө өгч, техник тоног төхөөрөмж, үр бордоо нийлүүлэх зах зээлийн мэдээлэлээр хангав. Аймгийн хэмжээнд төмсний 250 тонн үрийн нөөцтэй бөгөөд дутагдах 990 тонн үрийг Улаанбаатар хот, бусад гадны зах зээлээс хангахаар төлөвлөж байсан бөгөөд Энэ оны 9 дугаар сарын 5-ны байдлаар 35 аж ахуйн нэгж, 1403 өрх, иргэн 539,7 га талбайд үүний дотор арвай 6, төмс 278,3, хүнсний ногоо 127,9, тэжээлийн ургамал 116, жимс, жимсгэнэ 11,5 га талбайд тус тус тариалж, төмсний үрийн 30 хувь, хүнсний ногооны болон тэжээлийн ургамлын үрийг аймагтаа бүрэн хангаад байна.</p> <p>Өнгөрсөн ХХААЖДҮ-ын салбарын удирдах ажилтан мэргэжилтний аймгийн зөвлөгөөнийг 2010 оны 3-р сарын 13-14-ны өдрүүдэд нийт сумын Засаг дарга, ХАА-н түшмэл, сумын агрономич, тариаланч ногоочин 76 хүнийг оролцуулан тариалангийн бэлтгэлийг эртнээс хангуулах, төмс хүнсний ногооны үрийн хангамжийн судалгаа гарган дутагдах үрийн нийлүүлэлтийг хэрхэн зохион байгуулах талаар сургалт зөвлөгөө өгч, техник тоног төхөөрөмж, үр бордоо нийлүүлэх зах зээлийн мэдээллээр хангав.</p> <p>Аймгийн хэмжээнд төмсний 250 тонн үрийн нөөцтэй бөгөөд дутагдах 990 тонн үрийг Улаанбаатар хот, бусад гадны зах зээлээс хангахаар төлөвлөж байсан бөгөөд Энэ оны 9 дугаар сарын 5-ны байдлаар 35 аж ахуйн нэгж, 1403 өрх, иргэн 539,7 га талбайд үүний дотор арвай 6, төмс 278,3, хүнсний ногоо 127,9, тэжээлийн ургамал 116, жимс, жимсгэнэ 11,5 га талбайд тус тус тариалж, төмсний үрийн 30 хувь, хүнсний ногооны болон тэжээлийн ургамлын үрийг аймагтаа бүрэн хангаад байна урьд оныхоос тариалсан талбайн хэмжээ 2010 онд 48,3 га –аар нэмэгдэж, тэжээлийн ургамал, чацаргана тариалах иргэн, аж ахуйн нэгжийн тоо өссөн байна. Иргэд, аж ахуйн нэгжийн идэвхи, санаачилга, олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслийн дэмжлэгтэйгээр 3780 м<sup>2</sup> талбай бүхий 62 хүлэмж шинээр баригдан хүлэмжийн тариалан нэмэгдэж байна.</p>
<p>Баянхонгор</p>			<p>ХХААХҮЯ-ны ХАА-н үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв, аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, ХААИС, төслийн бусад байгууллагатай хамтран аймгийн төвд 2 удаагийн сургалтанд 51 хүн, Шинэжинст, Гурванбулаг, Хүрээмарал, Бууцагаан, Бөмбөгөр зэрэг суманд 182 тариаланч, ногоочдыг хамруулан сургалт явуулав.</p>

			<p>Тариалангийн ажилд тулгарч байгаа асуудлыг шийдвэрлэх зорилгоор Баянхонгор, Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумын Засаг дарга, ХАА-н түшмэл, газрын даамал, Баянхонгор сумын 9 багын 27 тариаланч оролцсон нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулав.</p> <p>2010 онд 2492 тонн төмс, 1194.5 тонн хүнсний ногоо, 336.4 тонн ногоон тэжээл хураан авч өмнөх жилээс 716.4 тонн ургац нэмж хураахаар тооцоо гарч байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
9.1.2. Аймгийн хөрсөнд нутагшсан төмсний үрийн сан бүрдүүлнэ.	60 тонн үрийн нөөц бүрдүүлсэнээр		<p>“Монгол төмс” хөтөлбөрийн хүрээнд Импала сортын 4 тонн элит үрийг “Жи Са Ой” ХХК, Баянхонгор сумын иргэн Д.Борхүү, Т.Батсуурь нар үржүүлж эхлэв. Төмсний нутагшсан сортын үрийн хангамж нийт тариалж байгаа үрийн 27 хувийг эзэлж байна.</p> <p>Бууцагаан сумын “Буянт цагаан- Өлзий” /Д.Батгэрэл/ ХХК, Эрдэнэцогт, Хүрээмарал, Баянлиг, Баянцагаан сумдад нутагшсан, сортын үрээр тариалалт хийгдэж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
9.1.3. “Чихэр өвс” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлгнэ	Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр		<p>“Чихэр өвс” хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХТ-ийн 2010 оны 11 сарын 19 ны хурлаар хэлэлцүүлсэн. Хурлаас: 1. 2011 оны 6 сарын аймгийн ИТХ-ын хуралдаанаар оруулах</p> <p>2. Чихэр өвс бүхий сумын иргэдэд дээрхи хөтөлбөрийг тараан хэлэлцүүлж санал авах</p> <p>3. Саналыг нэгтгэн дүгнэлт гарган хэлэлцүүлэх нь зүйтэй талаар зөвлөмж өгч хойшлууллаа.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-70%/</b></p>
9.1.4. Аймагт нэгээс доошгүй жишиг агропарк байгуулна.	Агропарк байгуулснаар		<p>Жишиг агропаркийг ХХААЖДҮГ-ын дэргэд төвлөрүүлэн байгуулахаар төлөвлөн, зураг, төсвийг боловсруулж, хэрэгжүүлэх ажлын тендерийг зарлан Медбенефит ХХК шалгарч ОХУ-д үйлдвэрлэсэн бага оврын трактор 3, төмсний иж бүрдэл, хадлангийн хадуур, тармуур, тэжээлийн ургамлын үрлэгч зэрэг тус бүр 2-ыг хүлээлгэн өглөө.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
9.1.5. Хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийг дэмжинэ	“Хүлэмж –Зоорь” болзол дүгнэснээр		<p>Болзолын материалыг хүлээн авч дүнг нэгтгэн ИТХуралд оруулахад бэлэн болоод байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100%/</b></p>

9.2. Мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	9.2.1. Малын халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх, лабораторын төлөвлөгөөт болон тандах шинжилгээнд хамрагдах малын тоог нэмэгдүүлнэ	-Урьдчилах сэргийлэх арга хэмжээнд 1.9 сая мал , - Малын паразитта өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 760.0 мянган мал - Мал эмнэлэг, ариун цэврийн шинжилгээнд 31.5 мянган мал тус тус хамруулж аймгийн төсвөөс 288.7 сая төгрөгийн санхүүжилт авснаар	Мал эмнэлэг, үржлийн ажил үйлчилгээг явуулах тухай аймгийн Засаг даргын 234 тоот захирамжаар мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1,7 сая мал, паразиттах арга хэмжээнд 1,2 сая мал хамруулаад байна. Малын шүлхийн өвчний тандах шинжилгээг 15 сумын 31 багийн малд явуулж, 960 дээжийг нарийвчлан бэлтгэж улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторитой хамтран шинжилж, бэлтгэгдсэн дээж 100 хувь эрүүл болох нь тогтоогдож мах экспортлох ажилд нэг томоохон үзүүлэлт боллоо. МЭАЦЛ-ийн шинжилгээнд 31,1 мянган мал хамруулж, 2000 малын ийлдсийн сан бүрдүүлээд байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	9.2.2. Мал эмнэлэг ариун цэврийн лабораторыг төвийн халаалтын системд холбуулж, мал эмнэлгийн итгэмжлэлд дахин хамруулна. Мал эмнэлгийн стандартын дагуу объектын хамгаалалтын хашаатай болно	Хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлснээр	Мал эмнэлэг ариун цэврийн лабораторийн дотоод засварын ажлыг дуусгаж, лабораторийн чанарын гарын авлагыг боловсруулан бэлтгэж улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори, аймгийн стандарт хэмжил зүйн төвд явуулж хянуулсан бөгөөд 9 сард дахин магадлан итгэмжлэлд хамрагдана. МЭАЦЛ-ийн халаалтын хөрөнгийн асуудлыг ХХААХҮЯаманд уламжилж шийдвэрлээд байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
9.3. Малын үржлийн ажил, үйлчилгээний чанар хүртээмж сүргийн бүтцийн сайжруулна.	9.3.1. Малын үзлэг ангилалтын ажлыг сайжруулж, бүртгэл мэдээллийн сүлжээнд хамрагдана.	-цөм сүргийн малын тоог 150 мянгад хүргэснээр - шилмэл мал шалгаруулснаар	Мал сүргийн үзлэг, ангилалтанд нийт 350 мянган мал хамруулж, цөм сүргийн малын тоо 120 мянгад хүрч, цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгч малыг бүртгэн гэрчилгээжүүлж, хувьслын ангилалтанд орсон малын 34 хувийг ээмэг, дугаартай болгов. Малын үзлэг, ангилалтын ажил 10-р сард үргэлжлүүлэх бөгөөд цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг бүртгэлд хамруулж гэрчилгээжүүлнэ. Аймаг, сумын хэмжээнд хээлтүүлэгч, хээлтэгч шилмэл мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд Баянхонгор, Галуут, Жинст, Баянхонгор сумдаас үржлийн мал оролцов. <b>/Хэрэгжилт-90%/</b>

	9.3.2. Мал сүрэг ялангуяа ямааны өсөлтийг тогтворжуулах, сүргийн бүтцийг шинжлэх ухааны үндэслэлтэй харьцаанд ойртуулах	Сүргийн бүтэц зохистой харьцаанд ойртсоноор	Мал сүргийг бэлчээрийн даац багтаамжид тохируулан, сүргийн зохистой бүтэцтэй байлган тоо толгойг хэт өсгөхгүй байх бодлого баримталж байгаа бөгөөд нийт сүрэгт эзлэх ямааны тоо толгой буурч, урд оныхоос 1 хуваарь буурсан дүнтэй байна. <b>/Хэрэгжилт-90%/</b>
9.4. Эрчимжсэн аж ахуй, хөгжүүлэх, төрөөс малчдын талаар баримтлах бодлого хэрэгжүүлэх	9.4.1. Төрөөс малчдын талаар баримтлах бодлого чиглэлийг хэрэгжүүлэх эхний үе шат /2010-2015 он/ -ны төлөвлөгөө батлуулж мөрдөх	Төлөвлөгөөг мөрдөж эхэлснээр	МУИХ-ын 39 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх зорилгоор УИХ-ын 39-р тогтоол,ЗГ-ын 208-р тогтоолоор батлагдсан бодлого,арга хэмжээний төлөвлөгөөг үндэслэн Баянхонгор аймагт хэрэгжүүлэх “Төрөөс малчидын талаар баримтлах бодлогын эхний шат/2009-2015 он/-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г ХХААЖДҮГ-аас боловсруулан ард иргэд, малчдад суртчилж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	9.4.2. Хонь, үхрийг мах сүүний чиглэлээр сайжруулж, бусад төрлийн малыг өөр дотор нь сонгон үржүүлнэ	Сайжруулсан малын тоогоор	Бог малын хээлтүүлэгчийн сан Өлзийт суманд байгуулах журмын төсөл боловсруулагдсан. МАА-н өвөлжилт, хаваржилтыг даван туулах, малчид оторчдод төрийн үйлчилгээ хүргэх, бог малын хээлтүүлэгч гаднаас авах зэрэг аймаг орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс 350 орчим сая төгрөг зарцуулав. Гаднаас сайжруулагчаар 200 хээлтэгч 43 хээлтүүлэгч худалдан авсан байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	9.4.3. Гахай, шувууны аж ахуй эрхлэх, үнээний ферм байгуулах асуудлыг дэмжинэ.	Туслах аж ахуй эрхлэгчид, гахайг-100, тахиаг-300- аас доошгүй толгойд хүргэснээр	Саалийн үнээний 2 ферм байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. ХХААХҮ-ийн яаманд хүсэлт гарган тэжээлийн ургамал/ арвай, хошуу будаа, хөх тарианы 9 тонн үрийг татан авч сумдын захиалгыг үндэслэн олгож, тэжээлийн ургамлын тариалалт өмнөх жилээс 50 гаруй га-аар нэмэгдэв. Баянхонгор сумын иргэн Жаргал тахианы аж ахуй байгуулах газрын асуудлыг шийдвэрлүүлж 1500 тахианы хүчин чадалтай байр барьж, 1200 өндөглөгч тахиа авч ирэн үйл ажиллагаа явуулж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>

9.5. Мал аж ахуйг аливаа эрсдлээс хамгаалах, бэлчээр ашиглалтыг сайжруулах	9.5.1 Мал аж ахуйн материаллаг баазыг нэмэгдүүлж, мал сүргийг даатгалд хамруулна.	Мал сүргийн 15-аас дээш хувийг даатгалд хамруулж, малын хашаа хороо-200, гар худаг-50-с доошгүйг барьж засварлан, хадлан 3000 тонн, гар тэжээл 1200 тонноос доошгүйг бэлтгэснээр	Сум бүр Засгийн газрын 2010 оны 166 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 01 тоот албан даалгаварыг хэрэгжүүлэх зорилгоор хадлан, тэжээл бэлтгэх ажилд идэвхитэй оролцож, иргэн, аж ахуй нэгж, байгууллага бүрт даалгавар өгч, хадлан авч болох газруудад бүлэг зохион байгуулан ажиллаж 9 дүгээр сарын 13-ны байдлаар 1746 тн хадлан, 271 тн гар тэжээл бэлтгэсэн нь өмнөх бүтэн жилд бэлтгэснээс хадлан 35,9 хувиар, тэжээл 2 дахин илүү байна. Энэ онд малчид өөрсдийн хүчээр 50 гар худгийг шинээр гаргаж, 28 худгыг сэргээн засварласны дээр 111 хашаа, хороог шинээр барьж, 422-г сэргээн засварлажээ. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	9.5.2 Отрын болон өвөлжөө, хаваржааны нутгийг тодорхой хугацаагаар малын хөлөөс чөлөөлж, хашиж хамгаалсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх, бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх,	Хашиж хамгаалсан талбайн хэмжээг 800 га-д хүргэснээр	Хашиж хамгаалсан бэлчээрийн талбайн хэмжээ 800 га-д хүрэв. Үлийн цагаан оготонотой тэмцэх арга хэмжээг Эрдэнэцогт, Өлзийт, Баянхонгор, Бууцагаан, Гурванбулаг сумын 30,0 мян га талбайд 45.0 сая төгрөгний санхүүжилтээр зохион байгуулсан. Ихэнх суманд өвөлжөө, хаваржааны болон нөөц бэлчээрийг малын хөлөөс чөлөөлж 1.8 мянган га талбайг хамруулав. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	9.5.3. Төв суурин болон бэлчээрийн худаг, усны хангамжийг нэмэгдүүлнэ	Шинээр гаргасан худгийн тоогоор	Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор инженерийн хийцтэй уст цэг шинээр гаргах, засварлаж шинэчлэх тендерийг зарлан гүйцэтгэгчийг шалгаруулан, одоогоор Шинэжинст, Баянлиг сумдад тус бүр гүн өрмийн нэг худгийг гаргаад байна. малын хашаа, хороо шинээр барих, сэргээн засварлахад ажлуудыг хийж улсын төсвийн хөрөнгөөр 6 суманд 8 гүн өрмийн худаг шинэчилэхээс 5 –ыг бүрэн хийсний дээр малчид өөрсдийн хүчээр 50 гар худгийг шинээр гаргаж, 28 худгийг сэргээн засварлаад байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
9.6. Бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлж, үйлдвэрлэлийн хэмжээг өргөжүүлэн үр ашгийг нэмэгдүүлнэ	9.6.1. “Бизнес мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, бизнес инкубатор төв байгуулах зорилт тавьж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	Бизнес инкубатор төв, худалдаа аж үйлдвэрийн танхимын үйл ажиллагааг идэвхжүүлснээр	Бизнес мэдээллийн төв, Худалдаа аж үйлдвэрийн танхимын салбарын хамтын ажиллагааг идэвхжүүлж “Бизнес хөгжлийн төв” байгуулан ажиллуулж бизнесийн зөвлөгөө өгөх, төсөл боловсруулах, сургалт явуулах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд “Төсөл боловсруулах аргачлал” сэдэвт сургалт зохион байгуулж тус сургалтад 19 сумын 102 иргэн хамрагдсан байна. Тус төвөөр дамжигдан 76 төсөл боловсруулж, 50 гаруй иргэнд зөвлөгөө өглөө. <b>/Хэрэгжилт-100%/</b>

9.7. Хүн амын хүнсний хангамж, аюулгүй байдлыг тогтвортой хангана	9.7.1. Мал аж ахуй эрхлэн хүн амыг мах, сүү, сүүн бүтээгдэхүүнээр, хөнгөн үйлдвэрийг түүхий эдээр хангаж, байгаль цаг уурын эрсдэл ихтэй хүнд нөхцөлд ажилладаг малчин өрхийг дэмжинэ.	Дэмжиж ажилласнаар	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлэнд хамрагдсан аж ахуй нэгж, иргэдээс 54 төслийг дэмжин банкинд хүргүүлсний хүнсний хангамж сайжруулах, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиглэлийн 14 аж ахуйн нэгж, иргэний төсөлд 188,9 сая төгрөгийн зээл олгогдсон ба үүнээс 8 нь газар тариалан, мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлтэй байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
9.8. Стандартыг мөрдүүлж ажиллана.	9.8.1. Аймгийн хэмжээнд шинээр суурилагдсан цахилгаан тоолуур, хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын ажлыг хийнэ.	Цахилгаан тоолуурыг стандартын дагуу баталгаажуулж гэрчилгээ олгосноор.	“Баянхонгор эрчим хүч” ХХК, стандартчилал хэмжил зүйн хэлтэс хамтран тоолуурын баталгаажуулалт хийх ажлыг 6 дугаар сарын 16 –наас эхлэн баталгаажуулсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>
9.9. Аймгийн хэмжээнд интернет, телефон үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлнэ.	9.9.1. Аймгийн төвийн интернет хэрэглэгчийн тоог нэмэгдүүлж интернет - ADSL үйлчилгээний DSLAM-ыг 48 хэрэглэгчийн портоор өргөтгөнө.	Аймгийн хэмжээнд шинээр баригдаж байгаа барилгууд батлагдсан зураг төсвийн дагуу телефон шугам, интернетийн сүлжээтэй баригдснаар	Аймгийн төвийн интернет хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авсны дүнд 192 хэрэглэгч интернет үйлчилгээгээр хангагдаад байна. Галуут, Эрдэнэцогт, Хүрээмарал сумд 40 сая төгрөгийн өртөгтэйгөөр интернетэд холбосон. Одоогоор хөдөө орон нутгийн 41 хэрэглэгч интернет ашиглаж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	9.9.2. Хэрэглэгчийн төлбөр тооцооны системийг орчин үеийн windows орчны программд шилжүүлнэ.		Төлбөр тооцооны системийг орчин үеийн windows орчны программыг шинэчлэн боловсруулж байна. Бэлтгэл ажлын хүрээнд аймагт 4 удаагийн сургалт явуулахаас 2 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна. Улсын хэмжээнд 70 хувьтай явж байгаа ба манайд 2011 оны 1-р улиралд багтаан шинэчлэлт хийгдэнэ. <b>/Хэрэгжилт-70%/</b>
9.10. Төв суурин газрын цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангана.	9.10.1. Баянхонгор-Хүрээмарал-Баянбулаг сумыг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих /1.423.0 сая төгрөг/	Шугам ашиглалтад орж 2 сумын хэрэглэгчид цахилгаантай болсноор	Хүрээмарал-Баянбулаг сумыг холбосон цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих ажлыг гүйцэтгэх аж ахуйн нэгжээр “Энергомонсеть” ХХК, “Эрчмийн ундраа” ХХК тендэрт шалгарч 100% гүйцэтгэсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	9.10.2. Баянхонгор сумын 110/35/6 дэд станцад нөөц трансформатор нэмж суурилуулах.	Нөөц трансформатор суурилагдснаар	Баянхонгор цахилгаан дамжуулах станцын өргөтгөл, нэмэлт трансформатор суурилуулах ажлыг “Ойгон нуур” ХХК тендэрт шалгарч ажил хийгдэж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>

	9.10.3. Зарим сумын 15/0,4 кВ-ийн шугам сүлжээ, дэд станцын засвар шинэчлэл хийж хэмжүүрийн хэрэгслээр хангана.	Засвар хийгдэж хэмжүүрийн хэрэгслээр хангагдснаар	Баянбулаг, Хүрээмарал сумдын 14/0,4 кВ-ийн шугам сүлжээ, дэд станцын засвар шинэчлэл хийх ажлын гүйцэтгэгчээр “Энергомонсеть” ХХК тендерт шалгарч ажил хийгдсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b>
9.11. Баянхонгор сумын дулаан, эрчим хүчний хангамжийг шийдвэрлэх эхлэлийг тавих	9.11.1. Баянхонгор аймгийн төвд барих “Дулааны цахилгаан станц”-ын судалгаа хийх ажлын эхлэлийг тавина.	Зураг төсөв хийх хөрөнгийг шийдвэрлэж, гүйцэтгэгчийг сонгон гүйцэтгүүлэх	Дулааны цахилгаан станц байгуулах, түүнд дэмжлэг үзүүлэх талаар яам, УИХ гишүүд, гадаад дотоодын хандивлагч нарт санал тавьсан одоогоор албан ёсоор хариу ирээгүй байна. <b>/Хэрэгжилт 10%/</b>
	9.11.2. Аймгийн төвийн дулааны шугам, сүлжээг засварлах, төвлөрүүлэх бэлтгэлийг хангана	Шугам сүлжээг засварлаж төвлөрсөн системд холбоход бэлтгэж, шаардагдах ажлын төсөл, хөрөнгийг шийдвэрлэснээр	Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсэг үзлэг тооллогыг хийж гүйцэтгэсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b>
9.12. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, агаарын бохирдлыг бууруулах, хог хаягдлын шинэ менежментийг нэвтрүүлснээр орчны бохирдлыг бууруулна.	9.12.1. Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлж, төвлөрсөн шинэ хогийн цэгийн ажлыг дуусгаж ашиглалтыг эхлүүлнэ.	Орчны болон, агаарын бохирдол тодорхой хэмжээгээр буурснаар	Агаарын бохирдлыг бууруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нам даралтын зуухтай иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг төвлөрсөн зууханд холбох талаар Аймгийн ИТХ-ын шийдвэр гаргуулсаны үр дүнд 41 байгууллага, иргэнд үүрэг өгч 23 байгууллага, аж ахуйн нэгж төвлөрсөн халаалтанд холбогдоод байна. Баянхонгор сумын албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн дунд мод тарих, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 200 тоот захирамж гаргуулан “Монголоо ногооруулья” аяныг зохион байгуулж 5900ш чацаргана, Гурван бүс цогцолборт хүрээлэнд 1600ш улиас, хайлаас, яргай 3739ш, иргэн С.Үнэнбуян өөрийн эзэмшлийн талбайдаа 1800ш чацаргана, 200ш жигд, улиас, хайлаас нийт 2000ш мод, намрын ойжуулалтаар 97ш нарс бүгд 10836ш мод, сөөг тарьж замын тусгаарлах зурваст 6000м <sup>2</sup> талбайг зүлэгжүүлсэн байна. Баянхонгор сумын 6 төвлөрсөн уурын зууханд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг эрх бүхий компаниар хийлгэхээр гэрээ байгууллаа

			<p>. Тээврийн хэрэгсэлд олгох Эко тэмдгийн загварын эхийг Улаанбаатар хотын хэвлэлийн компанид бэлтгэн, эко тэмдэг олгох Засаг даргын захирамж төлөвлөн Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд Тээврийн газраас олгодог зөвшөөрөлтэй давхцаж байгаа тул олгох шаардлагагүй гэсэн шийдвэр гаргав.</p> <p>“Баялаг орд” ХХК-ийн удирдлагатай тохиролцон Өвөрчулуутын нүүрсийг коксжуулж болох талаар дээжийг холбогдох лабораторийн байгууллагад дээжийг өгч шинжлүүлэхэд коксжүүлж болохгүй гэсэн хариу ирсэн байна. Хогийн бүтцийн судалгааг БОАЖГазар, Баянхонгор сумын ЗДТГазар хамтран комисс байгуулан 8 багийн 7612 айл өрх, байгууллагуудын дунд явууллаа. Судалгааны дүнд Баянхонгор сумын 7612 өрхийн 6832 өрх гэр хороололд, 780 өрх орон сууцанд амьдардаг ба жилд дунджаар 250.0мян тн хог хаягдал гаргадаг. Үүнээс дахин ашиглагдах боломжтой нь 102.8тн, ашиглагдах боломжгүй 147.2тн хог хаягдал байна. Ашиглаж болох хог хаягдалд гялгар уут, ундааны сав, ахуйн хэрэглээний савнууд, цаас, шил, төмөр орж байна. Аюултай хог хаягдал болох эмнэлгийн хог хаягдал 22.5мян тн, төвлөрсөн ба нам даралтын зуухнаас гарч байгаа үнс 283.6мян тн ялгарч байна</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
--	--	--	---

	<p>9.12.2. Гол, горхи булаг шандын эхийг хашиж хамгаалан орчныг тохижуулах, усан сан бүхий газар, ус хангамжийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоож, дэглэмийг мөрдүүлнэ.</p>	<p>Гол, горхи булаг шандын эх хамгаалагдснаар.</p>	<p>Усан сан бүхий газарт энгийн хамгаалалтын дэглэм тогтоож, тэмдэгжүүлэх журмыг сумдад хүргүүлж БОХУБ, Байгаль хамгаалагч нарт семинар өгч аймгийн Засаг дарга, сумдын Засаг дарга, Байгаль хамгаалагч нартай байгуулах үр дүнгийн гэрээнд тусган баталгаажуулсан. Усны газартай хамтран гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2010 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн “Орон нутагт ажлын хэсэг байгуулах тухай” 251 тоот захирамжийн дагуу аймгийн БОАЖГазрын дарга Л.Мандалаар ахлуулсан ажлын хэсэг “хангайн бүс”, “говийн бүс” гэсэн чиглэлд усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс тогтоох ажлыг хийж гүйцэтгэлээ. 19 сумын нутагт 53 гол горхи, 50 булаг шанд, 23 нуур цөөрөм, усны сан бүхий газруудад 1932 цэг дээр солбицол авч баримтжуулж говийн бүсэд усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийг 1000 метрээр, хангайн бүсэд 200-2500 метрээр тогтоолоо.</p>
			<p>Монголын байгаль хамгаалах бүлгүүдийг дэмжих холбооны Баянхонгор дахь салбар зөвлөл Эрдэнэцогт сумын Дунд Жаргалантын Хүрэн үзүүрийн булаг, Галуут сумын байгаль хамгаалах хэсэг Даваан амны булаг, иргэн Д. Сэр-Од Өлзийт сумын Бүлээн булаг, Байгаль ээжийн ирээдүй ТББайгууллага Бууцагаан сумын Цагаан булаг, иргэн Т.Эрдэнэчулуун Бөмбөгөр сумын Үнэгт булгуудын эхийг хамгаалах ажлыг хийж гүйцэтгэн орон нутагт хүлээлгэн өгсөн. Улсын төсвийн хөрөнгөөр 6 булгийн эхийг хамгаалах ажлыг хийв.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

	<p>9.12.3. Уул уурхайн аж ахуйн нэгжүүд, гар аргаар алт олборлогчдийн эвдсэн газрын биологийн нөхөн сэргээлт эрчимжүүлж шаардагдах хөрөнгийг шийдвэрлэж эвдэрсэн газрын мэдээллийн санг бүрдүүлж, нөхөн сэргээлтийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ</p>	<p>Эвдэрсэн газрын 30-50 хувьд нөхөн сэргээлт хийснээр</p>	<p>Эвдэрсэн газрын тооллогын материалд тулгуурлан эвдэрсэн газрыг нөхөн сэргээх аймгийн хөтөлбөр боловсруулан ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар батлуулан хэрэгжүүлж байна.</p> <p>Баянхонгор аймагт 2010 онд олборлох үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн нөхөн сэргээлт хүлээлгэж өгсөн байдал: Баян-Овоо суманд үйл ажиллагаа явуулж буй “Андын тэмүүлэл” ХХК - 5,1 га, Таван хангал трейд” ХХК - 2 га, Бөмбөгөр суманд үйл ажиллагаа явуулж буй “Бадамлах очир” ХХК - 28,5 га, “Дальня земля” ХХК - 0,5 га, Хайтек” ХХК - 2,5 га, “Ханшижир” ХХК - 26,2 га “Одод гоулд” ХХК Цагаан тохойд - 4,43 га, Галуут суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Монголболгаргео” ХХК - 18 га, “Тулгажаргалант” ХХК - 17 га, Жаргалант суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Жамп” ХХК 23 га –г тус тус хүлээлгэж өгөөд байна.</p> <p>” Одоогийн байдлаар эдгээр 10 компани техникийн нөхөн сэргээлтийг хүлээлгэж өгсөн боловч биологийн нөхөн сэргээлт хийсэн аж ахуйн нэгж байхгүй байна. Одод гоулд ХХК 2 талбай, “Жи энд Юу гоулд” ХХК 2 талбай Ти энд Ти юникс , БС санчир, “БаялагБог”д ХХК зэрэг аж ахуйн нэгжүүд нөхөн сэргээлтээ хүлээлгэж өгөөгүй байна.</p> <p>Гар аргаар алт олборлогчдын аймгийн зөвлөлгөөнийг 2010 оны 05 дугаар сарын 3-4-ний хооронд хийлээ.Уг зөвлөгөөнөөс уриалга, зөвлөмжийг гаргасан.Мөн Баян-Овоо сумын иргэн П.Банзрагч, Баян-Овоо сумын ЗДТГ, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай гурвалсан гэрээнийүндсэн дээр “Хоолтын Өндөр хүрэн”-д 50 га газар техникийн нөхөн сэргээлтийг хийж байна.Мөн Бөмбөгөр сумын нутаг “Гашуун ус” хэмээх газарт “Хайтик” ХХК 2 га-д техникийн, 1,0 га-д биологийн нөхөн сэргээлтийг хийхээр гэрээ хийн ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт -100%/</b></p>
--	---	--	---

	<p>9.12.4. Химийн хорт бодисын улсын тооллогыг аймгийн хэмжээнд зохион байгуулна.</p>	<p>Химийн хорт бодисын аюулгүй ажиллагааг хангаснаар</p>	<p>Химийн хорт бодисын тооллогод 13 сумын 28 байгууллага хамрагдаж 251 төрлийн 491491.677гр бодис бүртгэгдлээ. Тооллого хийх явцад химийн бодисын нэр хаяг байхгүй, ашиглалт, зарцуулалтын бүртгэл хөтлөдөггүй, зориулалтын бус цэгт хадгалдаг зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн ба цаашид ашиглалт, зарцуулалтын бүртгэл тогтмол хөтлөх, стандартын дагуу ашиглаж, хадгалахыг анхаарууллаа. Мөн Эрдэнэцогт сумын сургуулийн химийн танхимд нэр хаяггүй, устгалд оруулах шаардлагатай бодисууд байсан тул Мэргэжлийн хяналтын газар химийн бодисуудыг устгах хүсэлт тавиад байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
--	---	--	--

	<p>9.12.5. Лабораторийн ажлыг жигдрүүлж хөрс, ус агаарын дээжийг тогтмол авч шинжилгээ хийнэ.</p>	<p>Орчны бохирдолыг бууруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлснээр</p>	<p>УЦУОША-ны лаборатори хөрс, ус, агаарын дээжийг авч шинжилгээнд хамруулж байна. Аймгийн хэмжээнд агаарын бохирдлын хамгийн их байх саруудад 4 цэг сонгон явуул судалгаа хийсэн.</p> <p>Усны бохирдлын шинжилгээг 2, 4, 5-р саруудад усны харуулуудаас ирсэн дээжинд шинжилгээ хийж бохирдолын мэдээг сар бүрийн 05-ны дотор мэдээг өгч УБХ-1 хүснэгт тайланг боловсруулан тайлан мэдээг БОХЗТЛ-д хургүүлэв.</p> <p>Хөтөлбөрийн дагуу Баянхонгор сумын агаар, газрын гадаргын цацрагийн хяналтын ажиглалтад өдрийн 2 удаагийн хэмжилт хийж сар бүрийн 02, 12, 22-ний өдрүүдэд агаарын чанарын албанд мэдээг дамжуулан ИХХ-1 хүснэгтийг хөтлөн сар бүр БОХЗТЛ-д хургүүлж байна. Эхийн гол станцын цацрагийн 1, 2, 3, 4-р саруудын мэдээг ИХХ-1 хүснэгт, тайланг БОХЗТЛ-д хугацаанд нь хургүүлэв.</p> <p>Агаарын чанарыг хянах. шинжилгээний ажил хөтөлбөрийн дагуу Хүхрийн давхар исэл /SO<sub>2</sub>/, Азотын давхар исэл /NO<sub>2</sub>/-ийн агаарт агуулагдаж байгаа хэмжээг өдрийн 3 удаагийн ажиглалт хийж шинжилгээний дүнг боловсруулж , бохим мэдээгээр өдөр бүр агаарын чанарын албанд дамжуулж, тайлан мэдээг хөтлөн АБХ-1 хүснэгт, АБД-1 хүснэгт дэвтрийг БОХЗТЛ-д хургүүлэв.</p> <p>Усан дахь жинлэгдсэн бодис, рН тогтоох. Биогенийн элементүүд болох Фосфор /P/, төмөр /Fe/, сульфат /SO<sub>4</sub>/, фтор /F/, гол ионууд болох кальца /Ca/, магни /Mg/, усны хатуулаг, хлор /Cl/, гидрокарбонат /HCO<sub>3</sub>/, перманганатын исэлдэх чанар /ПИЧ/ болон нитрит /NO<sub>2</sub>/, нитрат /NO<sub>3</sub>/ эдгээр усны азотын нэгдлүүд дэх ионы агууламж зэрэг үзүүлэлтүүдийн усанд байх ёстой хэмжээнээс өөрчлөгдсөн үзүүлэлтүүдийг тогтооно.</p> <p>20, 30-ны өдрүүдэд зааврын дагуу хурааж БОХЗТЛ-ийн цацрагийн хяналтын салбарт дагалдах протоколын хамт хугацаа бүрд нь хургүүлж байна.</p> <p>Дулааны улирлын агаарын бохирдлын үзүүлэлтийг байнгын харуулын цэгээс авсан дээжинд хийсэн шинжилгээгээр стандарт хүлцэх агууламжаасаа даваагүй үзүүлэлт гарч байгаа ч өмнөх жилүүдийнхээс харьцангуй өссөн үзүүлэлт гарч агаарын бохирдол нэмэгдэж байгаа нь</p>
--	---	---	---

			<p>ажиглагдаж байна.</p> <p>Аймгийн хэмжээнд 9 нуур болон голын усанд. 02, 04, 05, 06, 07, 08, 09-р саруудад усны харуулуудаас ирсэн дээжийг хүлээн авч шинжилгээг хийж тайлан мэдээг боловсруулан БОХЗТөв Лабораторид хүргүүлж ажиллаж байна. Усны шинжилгээгээр бохирдлын түвшин гол төлөв хэвийн ангилалд багтаж байна. 2010 оны 09 сард “Жаст-ойл” ХХК-ны агаарын бохирдолын үзүүлэлт болон тоосжилтын түвшинг шинжилгээгээр тогтооход ноцтой бохирдол илрээгүй хэвийн үзүүлэлт гарч байна.</p> <p>10-р сарын Агаарын бохирдлын шинжилгээгээр агаарын бохирдлын хэмжээ дулааны улирлаас эрс нэмэгдэж, тоосжилтын хэмжээ байх хэмжээнээс хэд дахин давсан үзүүлэлт гарсан. Чандмань харуулд SO<sub>2</sub>, NO<sub>2</sub> –ийн хэмжээ стандарт хэмжээнээс багасч, харин тоосны хэмжээ 3-6 дахин ихэсч ажиглагдсан байна. Мөн энэ сарын усны дээрхи шинжилгээгээр Түй-Баянхонгор усны харуулын дээд, доод Баацагаан-Бөөнцагаан, Хөх нуур – Гурванбулаг усны харуулын дээжинд шинжилгээ хийхэд бохирдлын хэмжээ хэвийн хэмжээнд гарч байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	<p>9.12.6. Баян-Овоо суманд баруун бүсийн хүдэр баяжуулах үйлдвэр байгуулна.</p>	<p>Үйлдвэр барьж дууссанаар</p>	<p>Ашигт малтмалын газар, Аймгийн ЗДТГ, “Тогтвортой бичил уурхай” төслийн багтай хамтран Хүдэр баяжуулах үйлдвэр байгуулах тендер зарлаж “Хөх бүрдний эх” ХХК шалгарч үйлдвэрийн барилга, ажилчдын амрах байр, цайны газрын барилгуудыг барьж дуусгасан. Мөн шаардлагатай тоног төхөөрөмжүүдийг БНХАУ-аас оруулж ирсэн. Эрчим хүчийг Бөмбөгөрийн чиглэлийн 173-р анкераас 2,4 км шугам татаж холбохоор зураг төсвийг хийлгэсэн. Эрчим хүчний эх үүсвэр шийдэгдээгүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажил хийгдээгүй зэргээс шалтгаалан баяжуулах цехийн ажил эхлээгүй байна. Хүдэр баяжуулах үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг БОАЖЯ хийсэн.Ерөнхий үнэлгээний дүгнэлтийг үндэслэн “Хөх бүрдний эх” ХХК Улаанбаатар хотын Моонвеком” ХХК-тай байгаль орчны нарийвчилсан үнэлгээ хийлгэх гэрээ байгуулан ажиллаж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%</b></p>

<p>9.13. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх, “Ногоон хэрэм”, “Ойжуулалт 20” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.</p>	<p>9.13.1. “Эрдэнэмандал” хайрханыг тойруулан мод тарьж, моджуулах хөдөлгөөн өрнүүлж, ойжуулах /100000 мод тарих, Биологийн багш нарын хүчийг ашиглах /</p>	<p>Тарьсан модны амьдралт 70-аас дээш хувьтай байна.</p>	<p>Хайс хамгаалалт хийх зардлыг орон нутгийн төсвөөс гаргах боломжгүй тул Эрдэнэмандал хайрханыг тойруулж моджуулах ажлыг “Гурван бүсийн цэцэрлэгт хүрээлэнд хийлгэхээр ИТХ, аймгийн ЗДТГ-тай тохиролцон Улаанбаатар хотын “Саяаны-Ус” ХХК-аар ойжуулалтын ажил хийлгэсэн боловч үр дүн багатай боллоо.Тендерийн асуудлыг цуцлах талаар холбогдох газарт санал тавиад байна.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас зарласан “ОР-2010 0А5/28-04 багц тендерт “Саяана-Ус” ХХК шалгарч Баянхонгор аймгийн төвд 5 га талбайд цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэж байна. “Саяана-Ус” ХХКомпани нь цэцэрлэгжүүлэлтийн ажлыг технологийн дагуу хийгээгүй.Тарьц суулгацын хэмжээ 5 га талбайд тарих нормд хүрээгүй.Улиас 900 ширхэг, шар хуайс 550 ширхэг, бургас 200 ширхэг нийт 1650 ширхэг мод тарьсан байна.Нэг тогоонд гурав гурваар нь суулгасан 114 нүхэнд 342 ширхэг 86 метрийн урттай 40 см-ийн өргөнтэй шуудуунд нэг эгнээгээр 1308 ширхэг, нийтдээ 10836 ширхэг мод, сөөг тарьж суулгасан.</p> <p>“Саяана-Ус” компани мэргэжлийн түвшин, чадварын хувьд уг ажлыг гүйцэтгэх чадамжгүй гэж үзэж гэрээг цуцлаж өөр мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргаж ойн газарт санал тавиад байна.</p> <p>Гурван бүс цогцолборт хүрээлэнд “Хас банк”-ны нэрэмжит төгөл байгуулж 500 гаруй хайлаас тарьсан. Намрын ойжуулалтаар Хот тохижилт үйлчилгээний газар орхиод явсан 1600ш модыг шилжүүлэн тарьсан байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-70%/</b></p>
---	---	--	--

	<p>9.13.2. Үндэсний хөтөлбөрийг Бөмбөгөр, Богд суманд үргэлжлүүлэн зохион байгуулж аймгийн төвийн замын аюулгүйн зурвасыг цэцэрлэгжүүлж, мод тарина.</p>	<p>Ойжуулалт, тарьц суулгацын амьдралтыг 70-аас доошгүй хувьтай ургуулснаар.</p>	<p>Намрын ойжуулалтаар төв замын тусгаарлах зурвас аюулгүйн тойргоос аймгийн захиргаа зүүн тал хүртэл 57 ш, мөн аюулгүйн тойргоос 10 жилийн 2-р сургаалт хүртэл төв замын 2 талын хайсанд 20 ш, Ахмадын сааданд 5, Эв санааны нэгдлийн сааданд 10, аймгийн ХДТеатрын урд 3 хайсанд 8 ширхэг, нийт 100 ширхэг нарыг Тод газар ХХК нь Хэнтий аймгийн Биндэр сумаас авч ирэн тарихаар бэлтгэл хангагдаад байна. Мод тарих нүхийг аймгийн Барилгын цэргийн ангийн байлдагч нар ухаж мод тарих ажил бэлэн болоод байна. Дунд захаас доод зах хүртэлх замын 2 талаар мод тарих зураглал гарган Улаанбаатар хотын “Тод газар” ХХК-тай гэрээ байгуулан 4-5метр өндөр 97 ширхэг нарс модыг тариулж, арчилгаа, хамгаалалтын асуудлыг Хот тохижилт, үйлчилгээний газар хариуцаж байна.</p> <p>Намрын ойжуулалтаар Эрдэнэт хотоос 6000 ш хайлаас, 2000 ш бургас, 2000 ш улиасыг авч ирж Эв санааны нэгдлийн сааданд 5000 ш хайлаас, 1000 ш улиас, 1000 ш бургас, 3 бүс цогцолборт хүрээлэнд 1000 ш улиас, 1000 ш бургас, үлдсэн 1000 ш хайлаасыг төв замын 2 талаарх хайсанд нөхөн тарилт хийхээр бэлтгэл хангагдаад байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	<p>9.13.3. Аймгийн хэмжээнд мод үржүүлгийн газрын үйл ажиллагааг эхлүүлж модыг үрээр, суулгацаар тарьж эхлүүлнэ.</p>	<p>Мод үржүүлгийн газар байгуулж эхэлснээр.</p>	<p>Мод үржүүлгийн газарт 250 ширхэг жигд, цагаан хуайс, бургас зэрэг модны суулгац тарьж, үрийн талбайд 4.5 кг шинэс, шар хуайсыг үрээр тарив. 20х6 м хэмжээтэй хүлэмжинд чацаргана, шар хуайс үрээр тарив. Шар хуайсыг үрээр хүлэмжинд тарьсан нь намрын тооллогоор 81,2 хувийн амьдралттай байсан. Үрээр тарьсан шархуайсыг ил талбайд шилжүүлэн суулгах, цэнэг усалгааг хийж өвөлжүүлэх бэлтгэл ажил хийгдсэн. Мод үржүүлгийн газрын материаллаг баазыг бэхжүүлэх талаар БОАЖЯам, Ойн газарт асуудал тавьсаны үр дүнд иж бүрэн трактор, хүлэмж, гүний худгийн асуудлыг шийдвэрлүүлсэн.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

<p>9.14. Нэн ховор ан амьтны тархац нөөцийг тогтоож хамгаалалтын горимыг тогтоолгоно.</p>	<p>9.14. Халиун буга, идлэг шонхорын тархац нөөцийг мэргэжлийн байгууллагатай хамтран тогтооно.</p>	<p>Ховор амьтны тархац нөөцийг судалсаны үндсэн дээр хамгаалалтын горимыг тогтоолгож мөрдүүлснээр.</p>	<p>Халиун буга, идлэг шонхорын тархац нөөцийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх асуудлыг БОАЖЯ-нд албан ёсоор тавьсаны үр дүнд Биологийн хүрээлэнгийн судлаачдын баг шонхор шувууны тархац, нөөцийн судалгааг хийв. Баянхонгор, Говь-Алтай аймагт шонхор шувууны тооллогыг Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г. Майжаргалаар ахлуулсан баг хийв. Баянхонгор, Говь-Алтай аймгийн нутагт үлийн цагаан оготно тархан байршиж байсан нутагтаа үгүйрч, тэдгээрийг дагаж идэш тэжээлээ хийдэг идлэг шонхор болон бусад махчин шувууд нэн ховор байрших болсон нь цөөн тооны идлэг шонхор нутгийн хойд хэсэгт үзэж бүртгэгдсэнээр нотлогдож байна. Судалгааны багт 6ш идлэг шонхор шувуу бүртгэгдсэн байна. Нийтдээ улсын хэмжээнд 6 баг ажилласан бөгөөд 458 шонхор шувуу тоологдсон байна. Судлаачид нягтшил тооцдог 2 аргыг хэрэглэн Монгол оронд зуны улиралд 6835 шонхор шувуу байх боломжтой гэсэн тооцоо гаргасан байна. БОАЖЯ, НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Дэлхийн банк, Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэг хамтран Монгол улсын ойн тууртны тархац, нөөцийн судалгааг хийж байна. Энэ ажлын хүрээнд ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г. Цогтбаярын ахласан ажлын хэсэг Баян-Овоо, Жаргалант, эрдэнэцогт, Өлзийт, Галуут сумдын БОХУБ, байгаль хамгаалагч нартай хамтран дээрхи сумдын ойн тууртны тархац, нөөцийн судалгааг хийв. Одоо суурин боловсруулалтын ажил хийгдэж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
---	---	--	--

<p>9.15. Бэлчээрийн даац, ургамлын ургац, зун зуншлагыг сайжруулах зорилгоор зориудаар хур тундас нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>9.15. Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажлыг эрчимжүүлж, нөхцөл бүрдсэн тохиолдолд хугацаа алдалгүй экспедици ажиллуулан хур тунадас нэмэгдүүлэн ХАА-н үйлдвэрлэл, бэлчээрийн ургамлын ургацад дэмжлэг үзүүлж ажиллана.</p>	<p>Ган зуд, байгаль цаг агаарын гамшигт үзэгдлээс сэргийлэх ажлын чанар сайжирснаар.</p>	<p>Цаг агаарт зориудаар нөлөөлж Хур тунадас нэмэгдүүлэх экспедици энэ жилийн хугацаанд 3 удаа тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа зохион байгууллаа. Ажиллагааны явцад “Хурын Шим” төвтэй байнга хамтран ажиллаж заавар, зөвлөгөө авах жижүүрт гарч байгаа инженерүүдтэй санал солилцож, экспедицийн синоптик инженерүүд үйл ажиллагаандаа тоон прогнозын үр дүн, интернетийн бүтээгдэхүүнүүдийг ашиглаж ажиллав. 1. 2010 оны 05-р сарын 26-27-нд ажилласан ажлын талаар. Хээрийн экспедиц нутгийн баруун өмнөд хэсгээс орж ирсэн, зүүн хойш шилжилттэй үүлний массад тосож ажиллалаа. Харвалтыг Баацагаан сумын нутаг “Хавант” гэдэг газар 26-ны 11 цагт Sc хэлбэрийн үүлэнд нөлөөлөв. Үүлний өндөр нэлээд дээр байгааг харгалзан харвалт хийх цэгээр нэгэн толгойн оройг сонгосон ба пуужингууд үүлний дотор орж задран битүү нүргэлсэн дуу гарсан тул байг оносон гэж үзлээ.</p> <p>Ажиллагаа өдөр явагдсан тул үүлний хувирал өөрчлөлт сайн харагдаж ерөнхийдөө үүл бараантан, суурийн өндөр доош сууж байгаа нь ажиглагдсан. Хэсэг хугацааны дараа салхи тогтворжин, бороо орж эхэлсэн. Тунадасны мэдээ авахад харвалт хийсэн цэгээс урагш болон хойт зүгт нэлээд их талбайг хамран бороо орж байлаа. Иймээс дараагийн байрлалд шилжин ажиллаж байх үед бороо орж байсан учраас үүлэнд дэмжлэг үзүүлэх зорилгоор 3 пуужин харвасны дүнд орох хугацааг уртасгаж тунадасны хэмжээг нь ихэсгэж өгсөн.</p> <p>2. 2010 оны 07 сарын 30-аас 08 сарын 05-нд ажилласан ажлын талаар. Хээрийн экспедици нутгийн баруун урдаас орж ирсэн, зүүн хойшоо шилжилттэй үүлний массанд нөлөөлөв. Харвалтыг Шинэжинст сумын “Алаг-Овоо, Цагаан-Сайр, Шилийннуруу, Эхийн гол” гэдэг газруудад шилжин ажиллаа. Хээрийн экспедици нь 20 ширхэг пуужин зарцууллаа. Үүний үр дүнд сумдад 0,1 мм-7,6 мм тундас орсон.</p> <p>3. 2010 оны 08 сарын 29-нөөс 09 сарын 01-ний өдрүүдэд Хээрийн экспедици нутгийн баруун урдаас зүүн хойшоо шилжилттэй St хэлбэрийн үүлний массанд Баацагаан, Жинст сумдуудын нутагт ажиллалаа.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт 100%/</b></p>
---	---	--	---

	<p>9.16.1. Монголын улсын “Аялал жуулчлалын” үндэсний хөтөлбөрийг аймгийн “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-тэй уялдуулсан ажлын төлөвлөгөө гаргаж зохион байгуулна.</p>	<p>Орон нутагт аялал жуулчлалын сүлжээ бий болсноор.</p>	<p>Монгол улсын аялал жуулчлалын үндэсний хөтөлбөрийг “Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх мастер төлөвлөгөө”- тэй уялдуулсан дунд хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж байна.</p> <p>Аялал жуулчлалын мастер төлөвлөгөөнд тусгагдсан “Аялал жуулчлалын зөвлөл”-ийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 15 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан Аялал жуулчлалын талаар тулгамдсан асуудлыг хэлэлцэн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	<p>9.16.2. ”Шаргалжуут-Цагаан агуй-Бичигт хад” маршрутаар Аялал жуулчлалын аймгийн анхны шинэ маршрутыг нээнэ</p>	<p>Маршрут нээгдэж гадаад дотоодын жуулчдад үйлчилж эхэлснээр</p>	<p>Шаргалжуут, Цагаан агуйг холбосон говийн чиглэлийн аялалын маршрутыг гаргаж танилцуулга, хэвлэмэл брошуруудад ашиглаж сурталчилгааны ажлыг зохион байгуулаад байна. Аймгийн хөрш зэргэлдээ орших Завхан аймгийн “Отгонтэнгэр хайрхан”-ы Дархан Цаазат газрын чиглэлийн аялал жуулчлалын маршрутыг гаргах Завхан аймгийн аялал жуулчлалын ажил байдалтай танилцах зорилгоор 2010 оны 06 сарын 12-14-ны хооронд газрын дарга Л.Мандал, аялал жуулчлалын мэргэжилтэн Д.Содномсамдан нар тус аймгийн Отгон суманд ажилласан. Ажлын явцад Отгонтэнгэр хайрханы өвөрт орших “Отгон” жуулчны баазын захирал М.Болдбаатартай уулзаж тус баазруу зорин ирж байгаа жуулчдыг Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын “Хөх нуур”, Баянбулаг, Бөмбөгөр сумдуудын газруудаар дайран өнгөрүүлэхээр ярилцаж тохирсон. Шаргалжуут, Цагаан агуй, Бичигт хадыг холбосон говийн чиглэлийн аялалын маршрутыг гаргаж аймгийн аялал жуулчлалын танилцуулга, хэвлэмэл брошуруудад байршуулан сурталчилгааны ажлыг зохион байгуулж байна.</p> <p>Аймгийн аялалын маршрутаар “Хонгорын Түүчээ” ТББ-тай хамтран оюутан залуучуудын “Мэдлэгт аялал”- ыг зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-90%/</b></p>

<p>9.16.3. Орон нутагт аялал жуулчлалын хууль дүрэм стандартыг хангуулах, стандартыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Жуулчдын амрах үйлчлүүлэх таатай орчин бүрдснээр.</p>	<p>Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй буудлуудад зочид буудал, дэн буудлын стандартуудаар төрөл бүрийн хэвлэмэл брошур хийж тараан сурталчилгааны болон судалгааны ажлыг зохион байгуулсан. “Нэгдэлчин”, “Сөүл”, “Урандөш”, “Энх-Номун”, “Жаргалант”, “Хонгор” зэрэг 5 зочид буудал, “Баянхайрхан”, “Монос” зэрэг 2 дэн буудлуудын стандартад аймгийн МХГ-ын байцаагчтай хамтран 2010 оны 10 сарын 13-14 өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгууллаа. Зочид буудлын стандартыг хангасан тохиолдолд стандартчилал хэмжил зүйн төвөөс олгогдох тохирлын гэрчилгээг “Сөүл” зочид буудал авсан.Цаашид бусад зочид буудлуудад тохирлын гэрчилгээг олгуулах зочид буудлын стандартыг мөрдөж ажиллах талаар холбогдох байгууллагуудад санал тавин ажиллаж байна.“Өвгөнжаргалант”,</p>
		<p>“Шаргалжуут”, “Өхэг” зэрэг амралт сувилалын газруудын үйл ажиллагаатай 08, 09-р саруудад танилцлаа. Энэ жил “Өвгөнжаргалант” хүүхдийн зуслан хүүхэд 220, том хүн 250, нийт 460 амрагчдын хүлээн авсан статистик тоо гархбайна. “Өхэг” амралтын газар 2009 онд хувьчлагдаж урсгал засвар хийгдсэн. 2010 онд нийт 200 гаруй дотоодын амрагч сувилуулагчдыг хүлээн авсан. Цаашид амралтын газруудын үйл ажиллагааг сурталчилах, үзэсгэлэнт яармагт оролцуулах талаар хамтран ажиллахаар боллоо .“Говийн тэмээ”, “Мандухай” зэрэг жуулчны баазуудын үйл ажиллагаа, стандартын хэрэгжилтийн байдалтай 08 сарын 26-28 өдрүүдэд танилцаж, хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа. “Говийн тэмээ” жуулчны бааз нь энэ жил 150 гаруй гадаадын жуулчин авсан. Тогтмол 3 ажилчинтай, жуулчин ихээр ирсэн тохиолдолд сумаас нэмэж ажилчин авч ажлуулдаг. Говийн тэмээ жуулчны бааз нь жуулчны баазад тавигдах стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Стандартыг мөрдөж ажиллах талаар зөвлөмжийг дээрхи газруудад өглөө</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-70%/</b></p>

	<p>9.16.4. Аймгийн аялал жуулчлалын газрын зураг гаргах, Веб сайт, танилцуулга бэлтгэн, хэвлүүлж ард иргэд болон жуулчдад тараан сурталчилна.</p>	<p>Сурталчилгааны материалтай болсноор</p>	<p>Баянхонгор аймгийн аялал жуулчлалын англи, монгол хэлтэй танилцуулгыг 2000ш хэвлүүлж ард иргэд, албан байгууллага гадаад дотоодын жуулчдад тарааж сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. Баянхонгор аймгийн аялал жуулчлалын Вэб сайтын эхийг УБ-ын “Омогшил” ХХК-ны Вэб мастертай хамтран бэлдэж дуусгалаа. /Хэрэгжилт-100%/</p>
	<p>9.16.5. Аймгийн аялал жуулчлалын үйлчилгээний газрууд болон хувь хүмүүст аялал жуулчлалын мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулна</p>	<p>Орон нутагт аялал жуулчлалын үйлчилгээний чанар сайжирч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.</p>	<p><b>“Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх”</b> сэдэвт уулзалт, ярилцлагыг 2010 оны 02 сарын 23-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын “Экологи сургалт аялал жуулчлалын мэдээллийн төв”-ийн зааланд зохион байгуулсан. Уг уулзалт ярилцлагад Аймгийн ИТХ-ын дарга Г.Батжаргал, БОАЖГазрын дарга Л.Мандал газрын мэргэжилтэн, Их богдын ТХГазрын захиргааны дарга Б.Баярмагнай, жуулчны үйлчилгээний байгууллагын захирал эрхлэгч, аялал жуулчлалын чиглэлээр төгссөн болон сурч байгаа оюутан залуучууд оролцсоноороо онцлог болсон. Жил бүрийн 09 сарын 27-нд болдог “Дэлхийн аялал жуулчлалын өдөр”-ийг угтаж аймгийн Их дээд сургуулиуд, ЕБС, цэцэрлэг, багийн иргэдийг оролцуулан аялал жуулчлалын талаарх мэдээлэл, явган аялалыг ХҮДС, БСГ-уудтай хамтран зохион байгууллаа.</p>

			<p>Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор аж ахуй нэгж, албан байгууллага, ард иргэдээс судалгаа авч түүнд тулгуурласан аялалын маршрутуудыг гаргалаа</p> <p>Монгол улсын төрийн шагналт, гавъяат багш академич, доктор, профессор Шадавын Лувсанванданы мэндэлсний 100 жилийн ойд зориулан “Их эрдэмтний төрсөн нутгаар” тойрон аялалыг 2010.09.18-21 хооронд Өлзийт, Эрдэнэцогт сумын нутгаар аймгийн ЗДТГ, БСГ, Өлзийт сумын ЗДТГ, Ш.Лувсанванданы нэрэмжит сургууль, Улаанбаатар хот дахь Ш.Лувсанвандан сан зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулав.</p> <p>БНХАУ-ын Хэнан мужад болсон “Хүлэмжийн хийг багасгах ажлыг Зүүн өмнөд азиас эхлэе” сэдэвт сургалт семинарт Монгол, Солонгос, Хятад зэрэг 3 улсын төлөөлөгчид оролцлоо. Баянхонгор аймгаас оролцсон ЗДТГ, БОАЖГазруудаас оролцсон төлөөлөгчид аймгийн аялал жуулчлалын талаархи мэдээлэл, брошур зэргийг зочид төлөөлөгчдөд тарааж сурталчилгааны ажлыг зохион байгуулав.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-90%/</b></p>
--	--	--	---

<p>9.17. Халуун рашааныг түшиглэсэн жилийн турш жуулчин хүлээн авах бололцоотой амралт, сувиллын цогцолборуудыг байгуулахад дэмжлэг үзүүлнэ</p>	<p>9.17.1. Өхэг, Шаргалжуут халуун рашааныг түшиглэсэн жилийн турш жуулчин хүлээн авах бололцоотой амралт, сувиллын цогцолборуудыг байгуулахад дэмжлэг үзүүлнэ</p>	<p>Дотоодын амрагчдын амрах таатай орчин бүрдэж, жуулчдын тоо нэмэгдснээр.</p>	<p>Шаргалжуут рашааныг түшиглэсэн амралт сувилалын цогцолбор байгуулах саналыг орон нутгийн жуулчны баазын удирдлагууд, бизнесменүүд, гадаадын хандивлагч нарт тавиад байна.Төрийн болон мэргэжлийн байгууллагууд Шаргалжуут рашаан сувилалын үйл ажиллагаанд хяналт хийж ажил үйлчилгээний чанарыг сайжруулах, амрагчдын ая тухтай байдлыг хангах, үйлчилгээний газрын стандартыг хангуулах шаардлага тавьж ажилласаны үр дүнд компани санаачилга гарган мэргэжлийн хүмүүс авчран цэвэрлэх байгууламжыг шинэчлэх, амрагчдын зуны байрыг шинэчлэх, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор хүлэмжийн аж ахуй хөгжүүлэх, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор тодорхой ажлыг төлөвлөн ажиллаж байна. Жил бүрийн 12 сарын 2-4 өдрүүдэд УБ-ын “Мишээл экспо” дээр болдог “Mongolia ITF-2010” аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт оролцож Баянхонгор аймгийн аялалын маршрутыг сурталчлах ажлыг зохион байгуулж танилцуулга, брошур 1000 ширхэгийг компани,ард иргэдэд тараалаа. Шаргалжуут, Говийн тэмээ жуулчны баазууд лангуу түрээслэн үйл ажиллагаагаа сурталчлав. Баянхонгор аймаг бие даасан лангуу авч Хонгорын сор хоршоо бүтээгдэхүүнээ сурталчилж, зураач, багш өөрийнхөө бүтээлүүдээр үзэсгэлэн гаргалаа.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
---	--	--	--

<p>9.18. Тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдалд үнэлэлт дүгнэлт хийж тухайн газрын онцлог нөөц даацад тохируулан аялал жуулчлалын үйл ажиллагааг өргөжүүлнэ.</p>	<p>9.18.1. Аймгийн тусгай хамгаалттай газрууд, нутгийн иргэдийг түшиглэн аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах арга зүй боловсруулан мөрдүүлнэ.</p>	<p>Тусгай хамгаалттай газар нутагт дахь аялал жуулчлалын салбарын орлогын өсөлт, хамгаалалтад авсан олдворын тооны өсөлтөөр</p>	<p>Эрдэнэцогт, Галуут, Богд, Баянговь сумдын улсын тусгай хамгаалалттай газар нутагт 2010 онд нийт 9 нөхөрлөл байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Их богдын улсын тусгай хамгаалалттай газар нутагт аялал жуулчлалын бүсийг тогтоож, маршрут боловсруулан, брошюр бэлтгэж, аялагч жуулчлагч нарт ашиглуулж байна.</p> <p>2010 оны 3-р улирлын байдлаар Улсын Тусгай хамгаалалттай газар нутгаар нийт гадаадын 60, дотоодын 900 орчим аялагч нар аялсан байна. Үүнээс</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Баян-өхэг амралтын газарт дотоодын 250</li> <li>➤ Өвгөнжаргалантын зусланд 460</li> <li>➤ Мөн улсын тусгай хамгаалалттай газрын аялал жуулчлалын бүс нутаг Эрхэт, Тамчийн хавцал, Өртөмтийн урд хойд салаа зэрэг газар гадаадын 60, дотоодын 150 иргэн аялаж, аялах хугацаандаа тухайн газруудад байгуулагдсан нөхөрлөлүүдтэй хамтарч ажиллаа.</li> </ul> <p>Эрдэнэцогт сумын “Өгөөмөр өртөмт”, Богд сумын “Орогийн долгио “ зэрэг нөхөрлөлүүд нь гадаад дотоодын жуулчдад монгол малчдын ахуй амьдрал, уламжлалт зан заншлын тухай болон амьжиргааны гол эх үүсвэр болох малын гаралтай бүхий л түүхий эдээ хэрхэн боловсруулж, хэрэглэж байгаа талаараа өдөрлөг зохион байгуулсан байна. Мөн Эрдэнэцогт сумын “Өвгөнжаргалант” нөхөрлөлийн гишүүд байгалийн болон ан амьтдын зураг зуран гадаадын жуулчдад зарж борлуулан тухайн орон нутгаа сурталчилан таниулсан байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
--	--	---	--

	9.18.2. Тусгай хамгаалалттай газар нутагт байгаа динозаврын чулуужсан ясны хамгаалалтыг сайжруулна.		<p>Үлэг гүрвэлийн амьдарч байсан Баянговь сумын Бүгийн цав, Шинэжинст сумын Ногоон цавийн хоолой зэрэг газруудын хадгалалт хамгаалалтын байдлыг аймгийн засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг газар дээр нь очиж шалгалаа. Дээрхи газруудын зураг, цэгийг тогтоож ойролцоох айлуудад харж хандах, мэдээлэл дамжуулж байх талаар холбогдох сумдын БОХУБ-тай хамтран зөвлөгөө, зөвлөмжийг өглөө. Мөн дээрхи газруудын хадгалалт хамгаалалтын байдалд тавих хяналтыг өндөржүүлэх талаар Шинэжинст, Баянговь сумдын засаг дарга Өмнөд говийн БЦГазрын хамгаалалтын захиргаанд албан ёсоор санал тавилаа.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	9.18.3. Өлзийт сумын “Нарийн голд” аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах боломжийг бүрдүүлж нийтэд сурталчлах		<p>Улаанбаатар хотын “Нюком” ХХК Өлзийт сумын Бага Шаргалжуутыг аялал жуулчлалын бүс нутаг болгохоор 60 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийн судалгааны ажлыг хийж байна. Энэ ажлын хүрээнд “Нарийн гол”-д аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, аялал жуулчлалын маршрут бий болгох асуудлыг тусгаж байна. Мөн Бага Шаргалжуутад аялал жуулчлалын цогцолбор байгуулах зургийг мэргэжлийн байгууллага хийж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
<b>ДӨРӨВ. ТӨРИЙН ЗАХИРГАА, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН БОДЛОГО</b>			
10.1.Хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж мэдээллийн технологийн дэвшилттэй хэлбэрийг ашиглан төрийн үйлчилгээ, төрийн мэдээллийг	<p>10.1.1. Мэдээ мэдээллийг орон нутагт шуурхай хүргэх оновчтой шийдлийг олж, хэвлэл албан бичгийн саатлыг арилгана.</p> <p>10.1.2. Иргэд, төрийн бус байгууллагын үгийг сонсох нөхцлийг бүрдүүлж “Төр-иргэн”, “иргэн төр”-ийн харилцааг сайжруулна.</p>	Иргэдийн төрдөө итгэх итгэл сайжирч, харилцан мэдээлэл солилцох сүлжээтэй болсон байна.	<p>Хөдөө сумдыг факсын аппаратаар хангасан ч холбооны шугамын ачааллаас шалтгаалан бүрэн ажиллах боломжгүй байгаа ч сумдын төрийн сангийн сүлжээг ашиглан албан бичгүүдийг файл хэлбэрээр явуулж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p> <p>Засаг даргын Тамгын газраас шалгаруулж байгаа тендерийн хороонд Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөгчийг байнга оролцуулж байна. Аймгийн Залуучуудын холбоотой хамтран говь хангайн залуучуудын чуулга уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>Аймгийн нийт иргэдээс аймагт тулгамдаж байгаа асуудлуудын талаар санал авч нэгтгэж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

хүртээмжтэй шуурхай хүргэнэ.	10.1.3. 2009 оны сумдын үнэлгээгээр дээгүүр байр эзэлсэн сумдад говь, хангайн бүсчилсэн үзүүлэх сургууль зохион явуулна.		Сумдын ЗДТГазар, Засаг дарга нарын 2009 оны үйл ажиллагааны үнэлгээгээр тэргүүлэх байрт шалгарсан Бууцагаан, Жаргалант сумдад говь, хангайн сумдын бүсчилсэн үзүүлэх сургуулийг 2010 оны 9 сарын 23, 24 нд зохион байгуулсан. Үзүүлэх сургуульд нийт 150 алба хаагч хамрагдсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	10.1.4. Авилгатай тэмцэх хуулийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж “ авилгатай тэмцэх салбар зөвлөл, төрийн бус байгууллагын сүлжээний үйл ажиллагааг дэмжиж ажиллана		Авилгатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг ЗДТГ, ИТХ, ТББайгууллагын сүлжээ, аймгийн төвийн байгууллагууд хэрэгжүүлж байна. Төсвийн зарцуулалтын ил тод байдал, тендер төрийн худалдан авалтын ажиллагаа зэрэг сэдвүүдээр 440 хүнд 10 удаагийн сургалт хийсэн. Авлигаас урьдчилан сэргийлэх сэдвээр 7 байгууллагын алба хаагчдад мэдээлэл хийж, төрийн бус байгууллагууд хүүхдийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийж дүгнэлт гаргасан. <b>/Хэрэгжилт-100%/</b>
10.2.Боловсон хүчний хэрэгцээг судалж, эрэлтэд нийцсэн мэргэжилтнийг захиалгаар бэлтгэнэ.	10.2.1. Ажиллагсадын боловсрол, насны байдалд дүгнэлт хийж шаардлагатай мэргэжилтнийг гэрээгээр захиалгын дагуу бэлтгэж ажлын байраар хангахад мэргэжлийн байгууллагын хүчийг чиглүүлнэ..		Төрийн алба хаагчдын судалгааг нэгтгэн гаргаж яаманд хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд 3681 төрийн албан хаагч ажиллаж байна. Төрийн албаны шалгалт өгч тэнцэж төрийн албаны нөөцөд бүртгэгдсэн .....иргэн байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	10.2.2. Төрийн албан хаагчдыг сургах, давтан сургах, ажлын байран дээр нь сургахад анхаарч суралцах нөхцлийг бүрдүүлнэ.	Нийт эдийн засгийн бүх салбарт тогтвортой ажиллах мэргэжилтэй боловсон хүчний байнгын нөөцтэй болно.	

	<p>10.2.3.Төрийн байгууллагын зохион байгуулалтын бичиг баримт, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлнэ.</p>		<p>Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд Архивын ерөнхий газрын даргын 2009.07.07-ны өдрийн 68 дугаар тушаалаар батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын дагуу албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг мөрдөн ажиллаж байна.</p> <p>- Төрийн байгууллага, сум бүрд албан бичгийг стандартын дагуу бичих, бүртгэх, дугаарлах, архивлах, бүрдлийг бүрэн гүйцэт хийх зэрэг стандартын шаардлагуудыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>2010 оны 6 дугаар сард 21 аймгийг хамарсан “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийг нэвтрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулъя” нь сэдэвт үзүүлэх сургууль зохион байгуулагдаж амжилттай явагдсан.</p> <p>Аймгийн төрийн байгууллагуудад байгууллагын архивын шинэ программ суулгаж архивт хадгалагдаж байгаа материалуудыг бүгдийг шивж оруулсан.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
<p>10.2.1. Бүх шатны төрийн байгууллагад төрийн албаны стандартын хэрэгжилтийг хангана.</p>	<p>10.2.4. Хууль тогтоомж, аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын шийдвэрүүдийн биелэлтийн явцад шинжилгээ хийж хэрэгжилтийг хангуулна.</p>	<p>Төрийн алба хаагчдын сахилга, хариуцлага сайжирч, стандартын хэрэгжилт хангагдана.</p>	<p>“Аймгийн Засаг даргын шийдвэр, өгсөн үүрэг, даалгавар, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засгийн газрын тогтоол шийдвэр, улс, аймгийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэдээлэх, хяналт тавих төлөвлөгөө” –г батлан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдад хүргүүлж, тогтоол шийдвэрийн мэдээг сар, улирал, жилээр нь нэгтгэн холбогдох газруудад хүргүүлж хэвшсэн. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит хуралдаанд тогтоол шийдвэрийн биелэлтийг хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

	10.2.5. Байгууллага, сум бүрд хяналт шинжилгээ үнэлгээг нэг алба хаагчийн ажил үүргийн хуваарьт оруулж хэрэгжүүлнэ.		Төрийн захиргааны байгууллага болон сумдын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх талаар тусган хэрэгжүүлэхийг Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн даргын 2010 оны 3/1038 тоот албан бичгээр хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна. Ямар алба хаагч Засгийн газрын болон аймгийн ИТХ-ын тогтоол шийдвэрт хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч байх тухай жагсаалтыг гарган хүргүүлж, хэлтэс, агентлаг, сумдад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх явцад газар дээр нь хэрэгжилтийг шалгаж байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	10.2.6. Төрийн алба хаагчдын сахилга хариуцлагыг дээшлүүлж зөвлөлгөөний шийдвэрийг хэрэгжүүлнэ		Аймгийн Засаг даргын “Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх тухай” 2009 оны аймгийн Засаг даргын 374 дүгээр захирамжаар “Өөрчлөлтийг өөрсдөөсөө” ажлын төлөвлөгөөг баталж хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж, явц, үр дүнг тооцон ажиллалаа. 2010 онд дахин сахилга, хариуцлагын зөвлөлгөөнийг зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд зөвлөлгөөнөөр тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хэлэлцүүлнэ. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	10.2.7. Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. /Шифийн харилцаа/		Аймгийн Засаг даргын шөфийн харилцааг тогтоосон сум байгууллагын шөфийн харилцаа тогтворжсон. Шөфийн харилцаа тогтоогоогүй байсан 3 байгууллага8 аж ахуй нэгжийг 2010 онд нэмж оруулсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	10.2.8. “Монгол мэдлэгийн төв”-ийг бий болгоно.		Монгол орон, Баянхонгор нутгаараа бахархах түүх уламжлалын чиглэлээр 10 самбар бэлтгэн байрлууллаа. <b>/Хэрэгжилт-100%/</b>
11.1. Мэргэжлийн хяналтын байгууллагын үйл ажиллагааг ард иргэдэд нээлттэй ил тод болгож, төрийн	11.1.1. Төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагуудын нягтлан бодогч нарыг “Мэргэжлийн хяналтын газар”-аас аттестатчилалд хамруулан тэдний боловсролын баримт бичгийг нягтлан шалгана.	Төсвийн байгууллагын нягтлан бодогч нарын мэргэжил, мэргэшил баталгаажиж, санхүүгийн дутагдалгүй болно.	Төсвийн байгууллагын нягтлан бодогч нарын боловсролын баримт бичигтэй холбоотой асуудлыг нэгдсэн журмаар зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд хяналт шалгалтын ажил хийгдсэн <b>/Хэрэгжилт- 100%/</b>

<p>хяналт шалгалтыг шинэ шатанд гаргана.</p>	<p>11.1.2. Ерөнхий боловсролын сургуулиудын “Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулна.</p>	<p>“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилт сайжирсан байна</p>	<p>“Үдийн цай” хөтөлбөрийн хэрэгжилтэнд төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт 4 удаа хийлээ. 19 сумын сургуулийн үдийн цай хөтөлбөрийг дотуур байр түшиглэн зохион байгуулсан нь үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт урд онуудтай харьцуулахад харьцангуй дээшилсэн байна. Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих 3-5 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын баг томилсон. Баянхонгор сумын ерөнхий боловсролын 6 сургуулийн үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд эрүүл зүйн нян судлалын шинжилгээтэй хяналт тавьж, анги танхим болон 6 настай хүүхдийн тоглоом, хоол үйлдвэрлэлийн өрөөний нийт 120 цэгээс арчдас авч шинжлүүлж тодорхой арга хэмжээг авч байна. Үдийн цайтай холбогдуулан 2 албан тушаалтанд 60.0 мянган төгрөгийн шийтгэвэр ногдуулсан. Одоогийн байдлаар гепатит өвчний дэгдэлтийг буурах хүртэл хугацаагаар үдийн цай хөтөлбөрийг Баянхонгор суманд зогсоох арга хэмжээ авсан. Хөтөлбөрийн хэрэгжилтэнд төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалт 4 удаа хийлээ. 19 сумын сургуулийн үдийн цай хөтөлбөрийг дотуур байр түшиглэн зохион байгуулсан нь үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт урд онуудтай харьцуулахад өмнөх жилүүдээс харьцангуй дээшилсэн байна. Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих 3-5 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын баг томилон ажиллуулж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	<p>11.1.3. Уул уурхайн нөхөн сэргээлтийг зохих түвшинд хийлгэнэ.</p>	<p>Нөхөн сэргээлтийг зохих түвшинд хийснээр</p>	<p>Аймгийн Засаг даргын 2009 оны 334 дүгээр захирамжаар томилогдсон ажлын хэсэгтэй хамтарч уул уурхайн үйлдвэрлэл явуулсан аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлт хийсэн байдалтай газар дээр шалгаж дүгнэлт гаргав. 2010 онд уулын ажлын төлөвлөгөө, Засаг даргатай байгуулсан гэрээгээр 113.5 га талбай олборлолтонд өртөж техникийн нөхөн сэргээлтийг 113.5 га, биологийн нөхөн сэргээлтийг 50 га талбайд хийхээр төлөвлөсөн байна. Шалгалтын дүнд 11 аж ахуйн нэгж 142.1 га талбайд техникийн нөхөн сэргээлт 24.4 га –д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

	11.1.4. Лабораторын тоног төхөөрөмжид шинэчлэлт хийж, шинжилгээний төрлийг нэмэгдүүлнэ.	Аймаг орон нутаг хийгдэх шинжилгээний тоо нэмэгдсэнээр	Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар болон төслөөр хор судлалын шинжилгээний багаж төхөөрөмж, нимгэн үет хроматограф, Елиза, джитал микрископ, зейдийн аппарат, чийг хэмжигч зэрэг 8 төрлийн багаж тоног төхөөрөмжөөр хангасан. Үүний үр дүнд сүү сүүн бүтээгдэхүүнд меломин, цианид, пестицид илрүүлэх шинжилгээ, орчны шинжилгээнд анарод бактер зэрэг шинжилгээнүүдийг хийж эхлээд байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	11.1.5. Зөвшөөрөлгүйгээр бэлтгэгдсэн модны хулгайтай тэмцэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	Модны хулгайн тээврийн асуудал буурснаар	Ойн тухай хуулийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийж 40 иргэний 660м3 мод шалгагдсанаас 4 метр урттай 20м3 хэмжээтэй 86 ширхэг гуалин, 36.2м3 түлшний модыг улсын орлого болгож нийт модонд 2305680 төгрөгийн экологийн эдийн засгийн хохирол тогтоож, зөрчил гаргасан 4 иргэнд 400 мянган төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч бүрэн барагдуулсан байна. Аймгийн Засаг даргын захирамжаар холбогдох байгууллагуудтай хамтран байнгын эргүүл постыг зохион байгуулж ажилласан. Илэрсэн зөрчлийг урд жилтэй харьцуулж үзвэл 75-80 хувь буурсан байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
12.1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг төгөлдөржүүлнэ.	12.1.1. Иргэдийн иргэний бичиг баримт, иргэн, хуулийн этгээдийн эрхийн болон эд хөрөнгийн эрхийн бичиг баримтын зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулна.	Улсын бүртгэлийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэх үйл ажиллагааны үр дүнгээр	Аймгийн Засаг даргын 2010.02.19 ны өдрийн 63 тоот захирамжаар “Баримт бичгийн үзлэг хийж, зөрчил арилгах сарын аян”-ыг зохион байгуулах ажлын хэсэг томилон ажиллаж нийт 109 ажлын хэсэгт 426 хүн ажиллаж, хамрагдвал зохих 22934 өрх, 80845 иргэнээс 18855 өрх 68471 иргэн буюу хүн амын 84,2% нь хамрагдсан. Үзлэгээр 10746 зөрчил илэрснээс 96,72%-ийг бүрэн барагдуулж, иргэний бүртгэлийн маэдээллийн санд бүртгэн баталгаажуулсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	12.1.2. Эд хөрөнгийн болон хуулийн этгээдийн бүртгэлийг хөдөө сумдад эрхлэн хөтлөх нэгжийг бий болгох боломж нөхцлийг судлан, судалгааны дүнг холбогдох газарт уламжилж шийдвэрлэнэ.		Иргэний бичиг баримтын зөрчилтэй иргэдэд үйлчилэхгүй байх талаар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсүүдэд албан тоот 2 удаа явуулснаар иргэдийн үүргээ биелүүлэх байдал сайжирсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>

	13.1. Онцгой байдлын иж бүрэн, команд штабын сургууль, аймгийн Засаг даргын нэрэмжит онцгой комиссын үзлэгийг төлөвлөсөн сумдад зохион байгуулна.		Гамшгаас хамгаалах “Иж бүрэн” сургуулийг Өлзийт сумын Засаг даргын тамгын газарт 10 дугаар сарын 30-31-ний өдрүүдэд зохион байгуулан явуулав. Сургуульд аймгийн мэргэжлийн албадын эмч мэргэжилтнүүдтэй хамтран сумын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүн болон нийт 340 гаруй хүнд сургалт, сурталчилгааг зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах “Команд штабын “ сургуулийг 11 дүгээр сарын 04-05-ны өдрүүдэд зохион байгуулж сургуульд штаб, мэргэжлийн ангийн 67, аж ахуй нэгж байгууллагын удирдлага, ард иргэд нийт 220 гаруй хүн
13. Онцгой байдлын үзүүлэх сургалтуудыг шат дараатай зохион байгуулна.		Сумд, байгууллагуудын онцгой байдлын үйл ажиллагаа идэвхжүүлснээр	тус тус хамрагдсан. Сургуульд ХХААЖДҮГ-ын мал эмнэлгийн алба, БОАЖГазар, УЦУОШТөв, ЭМГазрын эмч, мэргэжилнүүд оролцож сургалт зохион байгуулав. Заг, Гурванбулаг сумдад Гамшгаас хамгаалах аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэгийг 11 дүгээр сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулж, галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэгт 2 сумын 30 аж ахуй нэгж байгууллага, 361 айл өрхийн 500 гаруй хүнд ухуулга, яриа таниулга хийж, гал түймрийн аюулд хүргэж болзошгүй 110 зөрчлийг илрүүлж, 64 зөрчлийг газар дээр нь арилгуулж, үлдсэн зөрчилд хугацаатай үүрэг өгч ажиллаа. <b>/Хэрэгжилт-100%/</b>
14.1. Иргэдийн хууль, эрх зүйн мэдлэгийг	14.1.1. Сургалтын олон хэлбэрийг нэвтрүүлнэ.	Иргэдийн дунд хууль эрх зүйн сургалт зохион байгуулснаар	Зорилтот бүлгүүдэд чиглэгдсэн, 5 төрлийн сургалтыг хийхээр төлөвлөснөөс 100% хэрэгжүүлсэн. <b>/Хэрэгжилт-100%/</b>

дээшлүүлэх ажлыг эрчимжүүлнэ.	14.1.2. Сургалт сурталчилгааны хөрөнгийн эх үүсвэртэй байх	Сургалтын үр дүнгээр	Хууль зүйн хэлтэс нь энэ онд байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнууд, албан газрын дарга, эрхлэгч, төлбөрийн чадваргүй болон Цагдаагийн хэлтэст эрүүлжүүлэгдсэн иргэд зэрэг нийт 190 хүнд төлөвлөгөөт, Хүрээмарал сумын ЗДТГ, “Нэгдэлчин” зочид буудал, “Чандмань-Баянхонгор” ХХК-ын захиалгаар 180 иргэнд захиалгат эрх зүйн албан бус сургалтыг Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран хийж, оролцогчдыг хууль тогтоомжоор бэлтгэсэн 3-5 төрлийн хялбаршуулсан гарын авлагаар хангаж ажиллалаа. Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ээр хялбаршуулсан гарын авлага бэлтгэж аймгийн нийт төрийн захиргааны албан хаагчдад, архидан согтуурахаас сэргийлэх, хяналт тавих үндэсний хөтөлбөр, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжоор бэлтгэсэн гарын авлагыг иргэдэд хүргэхэд бэлэн болгоод байна. <b>/Хэрэгжилт – 100%/</b>
	14.1.3. Архивын хайлтын системийг үйл ажиллагаандаа ашиглаж эхэлнэ.	Хайлтын систем ашиглаж эхэлснээр	Төрийн архивын үйл ажиллагаанд Архивын Ерөнхий газраас “ORMS” бүртгэл хайлтын программыг 2010 оны 02 дугаар сард авч үйл ажиллагаандаа ашиглаж, мэдээллийн технологийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтээр улсын хэмжээний үзүүлэх сургуулийг хийж байгууллага, сум бүр үйл ажиллагаандаа ашиглаж байна. <b>/Хэрэгжилт – 100%/</b>
14.2. Төрийн байгууллагуудын ажлын зохион байгуулалтыг сайжруулахад анхаарна.	14.2.1. Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийг бүртгэлийн программд шилжүүлнэ.	- Төрийн байгууллагуудын зохион байгуулалт, албан хэрэг хөтлөлт сайжирснаар	Аймгийн Засаг даргын Тамгын газарт албан хэрэг хөтлөлтийн бүртгэлийн программыг авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Программ хангамжийн ашиглалтыг улсын хэмжээний үзүүлэх сургуулийн үеэр нийт 128 оролцогчдод танилцуулсан болно. <b>/Хэрэгжилт- 100%/</b>
14.3. Төрийн байгууллагуудын ажилтнуудын амьдрах нөхцлийг сайжруулна.	14.3.1. Шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааны зардлын сан бүрдүүлэх эхлэл тавих	- Сангийн үйл ажиллагааны үрд дүнгээр	2009 оны 10 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өрх толгойлсон эмэгтэй, өндөр настан, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой тэтгэлэг авагч нарт шийдвэр гүйцэтгэх албаны зардлыг урьдчилан гаргах зорилгоор 1,0 сая/төг-ний “Эрсдэлийн сан” байгуулах шийдвэрийг гаргасан хэдий ч энэ асуудал бүрэн шийдэгдээгүй байна. <b>/Хэрэгжилт-50%/</b>

	14.3.2. Цагдаагийн алба хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулахад анхаарна.	- Цагдаагийн кабон баригдаж, хөдөлгөөнт эргүүлийн машинд парк шинэчлэл хийгдсэнээр.	2010 онд төсвийн хөрөнгө оруулалтаар Баянлиг суманд цагдаагийн кобан барихаар төлөвлөгдсөний дагуу зураг төслийг гаргуулан батлуулж ,Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын харъяа Хархорин дахь 423 дугаар хорих ангиар барилгын ажлыг гүйцэтгүүлэн 2010 оны 09 дүгээр сард улсын комисс хүлээн авч, ашиглалтанд оруулсан. <b>/Хэрэгжилт-100%/</b>
	14.3.3. Төрийн албан хаагчдын орон сууцны барилгын асуудлыг шийдвэрлэх, орон сууцны урт хугацааны зээлд алба хаагчдыг хамруулах	- Орон сууцтай болсон алба хаагчдын тоогоор	Төрийн албан хаагчдыг орон сууцанд хамруулахаар агентлагуудаас санал авсан ба одоогоор 50 албан хаагч орон сууцанд орох саналаа ирүүлсэн. Орон сууцны зээлд хамрагдах төрийн алба хаагчдад тус бүр нь 6,0 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлээд байна. <b>/Хэрэгжилт-100%/</b>
15.1. Орон нутгийн хамгаалалтын үндэсийг бүрдүүлэхэд чиглэгдсэн удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	15.1.1. Цэргийн дүйцүүлэх алба хааж байгаа иргэдийг орон нутгийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулна.	- Цэргийн дүйцүүлэх албаны чанарт ахиц гарна.	Цэргийн дүйцүүлэх албыг 2010 -2012 онд шинээр хааж байгаа иргэдтэй анхан шатны мэрэгжил олгох сургалтыг 2010 оны 5 дугаар сарын 17 - 31 – ны өдрүүдэд, 2009 - 2011 онд 2 дахь жилдээ алба хааж байгаа иргэдтэй үүрэг гүйцэтгэхдадлага олгох сургалтыг 2010 оны 6 дугаар сарын 14 - 28 – ны өдрүүдэд тус бүр 14 хонгийн хугацаатай сургалтыг Онцгой байдлын хэлтсийн оролцоотойгоор зохион байгуулан явуулсан. Сургалтын явцад 4 өдөр цэргийн дүйцүүлэх алба хаагч 50 иргэн Түйн голын сав, хуучин хогийн цэгийн орчныг цэвэрлэх нийтийг хамарсан ажилд оролцож, Цагаан чулуутын булгаас Ганц бургас хүртэлх газрыг бүрэн цэвэрлэж Баянхонгор хотын захирагчийн албанд хүлээлгэж өгсөн. Энэ ажлын явцад 14 машин хог хаягдлыг хогийн цэгт буулгасан. оролцоотойгоор Баян – Овоо сумын төвөөс хойш 5 км – т Талын Улаан гэдэг газар өвс хуримтлагдаж, мал идээшлэх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 1 х 1,5 х 500 м туршилтын хөмөг байгуулсан. Энэ ажлын явцад 3 хоногт 750 куб.м газар шорооны ажил хийгдсэн. 2010 оны 6 дугаар сарын сарын 1 – 13 – нд Цэргийн дүйцүүлэх албаны 30 иргэний хүчээр 12 хоногийн хугацаанд Баян – Өндөр сумын нутагт Таван - Овоогийн даваа, үрээгийн хөндийгөөр автомашин саадгүй явах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор давааны Таван - Овоогийн 7 км, Үрээгийн 11 км замыг зассан. <b>/Хэрэгжилт-100%/</b>

	15.1.2. Дайнд оролцсон ахмад дайчдад орон сууц олгох асуудлыг шийдвэрлүүлнэ.	- Дайнд оролцсон ахмад дайчдын амьдралын нөхцөл дээшилнэ.	Дайнд оролцсон 15 ахмад дайчинд орон сууц олгогдсон.  <b>/Хэрэгжилт-100%/</b>
15.2. Цэргийн ангийн албан хаагчдыг орон сууцаар хангана.	15.2.1. Баянлиг сумын цэргийн ангийн албан хаагчдыг орон сууцаар хангана.	- Албан хаагчид орон сууцаар хангагдснаар.	Зэвсэгт хүчний 103 дугаар салбарын цэргийн албан хаагчдыг 12 айлын орон сууцны төсөв 126 сая төгрөгөөр батлагдсан. Орон сууцны суурь тавигдсан.  <b>/Хэрэгжилт 100%/</b>
15.3. Барилгын цэргийн анги байгуулах	15.3.1. Барилгын инженерийн цэргийн анги байгуулах асуудлыг шийдвэрлэнэ.	- Барилгын цэргийн анги байгуулах асуудал шийдвэрлэгдсэнээр	Аймагт Зэвсэгт хүчний барилга, инженерийн 339 дүгээр анги байгуулагдаж үйл ажиллагаагаа явуулж байна.  <b>/Хэрэгжилт 100%/</b>
<b>Тав. Гадаад харилцааны бодлого</b>			
16.1. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, үр өгөөжийг шинэ шатанд гаргана.	16.1.1. Аймгийн гадаад харилцааг эдийн засагжуулахад бүх үйл ажиллагааг чиглүүлнэ.	Гадаадын туршлага, боломжит шинэ технологийг өөрийн хөрсөн дээр буулгаж, бүтээлч ажил хэрэг болгоно.	“Food Processing Management” компани болон Франц улсын зөвлөхүүдтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан аймагтаа мах боловсруулах үйлдвэр, цаашдаа сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулах талаар судалгаа хийн ажиллаж байна. ӨМӨЗОрны Эзний хошуунд хүлэмж бариулах, Бүрэн дунд сургуульд сурагчидыг сургах саналыг хүргүүлээд байна. ХХААЖДҮГазраас ажлын хэсэг Эзний хошуунд туршлага судлаад ирсэн. Мөн аймагт жишиг агропорк байгуулах санал хүргүүлээд байна.  <b>/Хэрэгжилт-100%/</b>
	16.1.2. ОХУ, БНСУ, Япон, БНХАУ-тай харилцах харилцааг улам боловсронгуй болгож бодит үр өгөөжийг дээшлүүлнэ.		ОХУ-ын Буриад улсын Кабанскийн районтой харилцаагаа бэхжүүлэн ажиллаж 2010 оны 4 сард аймгийн Тэмүүжин театрын сурагчид, бусад бүрэлдэхүүн тус районд айлчилж, туршлага судалж, мөн өөрсдийн тоглолтоо үе тэнгийн сурагчдад тоглов. Японы Ойта мужтай харилцаагаа өргөжүүлж Соого Сейко сургуулийн өргөтгөлийн барилгад 50 мянган долларын хөрөнгө оруулалт хийж барилгыг 2010 оны 08 сарын 31 нд нээлтээ хийсэн.  <b>/Хэрэгжилт-100%/</b>

	<p>16.1.3. Гадаадад аялагчдыг “Нэг боломж- Нэг технологи” удирдамжтайгаар ажиллуулж үр дүнд хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ.</p>		<p>БНХАУ-ын ӨМӨЗОрны эзний хошуу, Альшаа зүүн хошуу, Эзний хошуунд айлчлал хийж хамтран ажиллахаар тохиролцож Альшаа Зүүн хошууны төлөөлөгчдийг аймагтаа урьсан ч Альшаа аймгийн 30 жилийн ойтой холбоотойгоор төлөөлөгчид ирээгүй. Хятад Улсын Хенан мужид болсон аялал жуулчлалын бага хуралд БОАЖГазрын даргаар ахлуулсан ажлын хэсэг ажилласан.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>
	<p>16.1.4. Европын холбооны улсуудтай харилцах эхлэлийг тавина.</p>		<p>Тайланд улс болон Хойд Солонгос зэрэг улс орнуудад суугаа элчин сайдад эдгээр орнуудтай хамтран ажиллах чиглэлээр тоот боловсруулан хүргүүлээд байна. БНСУ-д суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдад хамтын ажиллагаагаа өргөжүүлэх талаар хүсэлт гаргасан тоотыг илгээсэн. NEAR холбооны үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллаж, түүгээр дамжуулан харилцаагаа өргөжүүлж байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-100%/</b></p>

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит  
7 дугаар хуралдааны .....-р тогтоолын хоёрдугаар хавсралт

**Монгол улсын 2010 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын жагсаалт  
МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2010 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил	хугацаа	Төсөвт өртөг	/сая төг/ 2010 онд санхүүжих
1	<b>ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА</b>			
	Сумын ЗДТГ-ын барилга /Баянхонгор, Галуут/	2010-2011	750.0	262.9
2	<b>ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД</b>			
	Авто зам			
	Баянхонгор-Арвайхээрийн 27 км хатуу хучилттай авто зам /Баянхонгор/	2008-2010	5,500.0	2,871.9
	Баянхонгор-Нарийнтээлийн 50 км хатуу хучилттай авто зам /Баянхонгор/	2008-2010	9,516.5	6,066.5
	Арвайхээр - Баянхонгор чиглэлийн 107 км хатуу хучилттай авто зам /Өвөрхангай/	2010-2013	40,660.0	-
	Баянхонгор - Алтай чиглэлийн 128 км хатуу хучилттай авто зам /Баянхонгор/	2010-2013	48,640.0	-

3	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД			
	Эмнэлгийн барилга, 50 ор /Баянхонгор/	2008-2010	1,205.6	140.0
4	БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД			
	Боловсрол			
	Цэцэрлэгийн барилга, 75 ор /Баянхонгор сум/	2009-2010	400.0	400.0
	Соёл			
	Номын өргөөний барилгын дуусгал /Баянхонгор/	2008-2010	1,498.2	400.0
	Соёлын төвийн барилга /Баянхонгор, Баян-Өндөр/	2007-2010	289.0	89.0
	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Бууцагаан/	2008-2010	460.0	460.0
	Соёлын төвийн барилга /Баянхонгор, Шаргалжуут/	2007-2010	290.0	90.0
	Соёлын төвийн барилга, 250 суудал /Баянхонгор, Баянцагаан/	2009-2011	600.0	200.0
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>109,809.3</b>	<b>10,980.3</b>

Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн ээлжит  
7 дугаар хуралдааны .....-р тогтоолын гуравдугаар хавсралт

**Монгол улсын 2010 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын жагсаалт  
БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2010 ОНД  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил	хугацаа	Төсөвт өртөг	/сая төг/ 2010 онд санхүүжих
1	Аймгийн ЗДТГ-ын халаалтын шугамын их засвар /Баянхонгор/	2010	50.0	50.0
2	Сумдын ЗДТГ-ын автомашин /Заг, Жаргалант, Жинст, Бөмбөгөр /	2010	60.0	60.0

3	Сумдын ЗДТГ-ын тоног төхөөрөмж /АЗДТГ, Бүх сумд/	2010	50.0	50.0
4	Тогтвортой амьжиргаа төслийн Монголын талын хөрөнгө /Баянхонгор/	2010	18.1	18.1
4	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөрөнгө оруулалт /Баянхонгор/	2010	155.2	155.2
6	"Цахим эмнэлэг" хөтөлбөр /Баянхонгор/	2010	50.0	50.0
6	Жижиг, дунд үйлдвэрлэлийн төсөл /Баянхонгор/	2010	270.0	270.0
8	"Өвөлжилт хаваржилтийг даван гарах" хөтөлбөр /Баянхонгор/	2010	250.0	250.0
9	Багийн хөгжлийг дэмжих /Баянхонгор бүх сум/	2010	70.0	70.0
10	Сумдын ЗДТГ-ын тоног төхөөрөмж, автомашин /Баянлиг, Баацагаан, Бууцагаан, Галуут, /	2010	70.0	70.0
11	Хүүхэд залуучуудын хөгжлийн төв, 4-р 10-н жилийн сургуулийн тоног төхөөрөмж /Баянхонгор/	2010	50.0	50.0
12	Сурагчдын хичээлийн хэрэгсэл /Баянхонгор бүх сум/	2010	30.0	30.0
13	Өрхийн эмнэлгүүдийн тоног төхөөрөмж, их засвар /Баянхонгор/			
	Автомашин / Оточ номгон өрхийн эмнэлэг/	2010	6.0	6.0
	Тоног төхөөрөмж халаалт /Энхбүрд өрхийн эмнэлэг/	2010	3.0	3.0
	Өрхийн засвар тоног төхөөрөмж /Эбсу өрхийн эмнэлэг/	2010	15.0	15.0
	Өрхийн эмнэлгүүдийн тоног төхөөрөмж, их засвар /Оточ мандал, Наранмандмал, Суперэссор, Оточ номгон, Энхбүрд, Эбсу өрхийн эмнэлэг, Биеийн тамир спортын газар	2010	36.0	36.0
14	ЕБС-уудын компьютер, тоног төхөөрөмж /Баянхонгор бүх сум /	2010	50.0	50.0
15	Жишиг агропарк байгуулах тоног төхөөрөмж, трактор /Баянхонгор, Өлзийт, Бууцагаан сумд/	2010	100.0	100.0
16	Төрийн албан хаагчдын орон сууцны барилга /Баянхонгор, Баянхонгор/	2010	177.0	177.0
17	Баянхонгор аймгаас УБ хотод шилжин суурьшиж буй өндөр настан, оюутан сурагчид, орон сууцны гачигдалтай байгаа иргэдэд зориулсан орон сууцны хөтөлбөр /УБ/	2010	400.0	400.0
18	Цахилгаан дамжуулах агаарын шугамын дэд станц барих /Баянхонгор, Хүрээмарал, Баянбулаг/	2010	1,423.0	1,423.0
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>3,333.3</b>	<b>3,333.3</b>

**ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР ГҮЙЦЭТГЭН ДАРАА ТӨЛӨГДӨХ НӨХЦЛӨӨР 2010 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ**

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүч чадал, байршил	хугацаа	Төсөвт өртөг /сая төг/	2010 онд
1	<b>ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД</b>			
1	Баянхонгор 110/35/6 кВ-ын дэд станцад 6.3 мВА трансформатор нэмж тавих /Баянхонгор/	2010	1,434.0	1,434.0
	<b>НИЙТ ДҮН</b>		<b>1,434.0</b>	

2.2.3. Ламын гэгээний цогцолборыг 157,0 сая төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж ашиглалтанд	-Цогцолборын барилга байгууламж ашиглалтанд орсноор	“Унага трейд” ХХК Цогцолборын барилгын суурийг тавьж эхэлсэн боловч барилгын зургийн алдаа гарсан тул барилгын ажил зогссон. /барилгын арматурын төмрийн голчийг буруу тооцсон байсан. 2011 онд шийдвэрлэхээр зохицуулалт хийгдсэн./
---	---	--

оруулах		<b>/Хэрэгжилт-10%/</b>
2.2.4. Аймгийн Музейн стандартын барилгын зураг, төсвийг хийлгэнэ.	-Барилгын газар, зураг, төсвийг бэлэн болгосноор	Аймгийн Музейн шинэ барилгын газрын зөвшөөрлийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 61-р тогтоол, аймгийн Засаг даргын 2010 оны 367-р захирамжаар батлуулан барилга барих 0,12 га газрыг хуучин АҮ-ний ард “Эв санааны нэгдэл”цэцэрлэг дотор авч, цахилгаан, дулааны инженерийн шугам сүлжээний зураглал, зөвшөөрлийг авсан. Одоо барилгын зураг, төсвийг хийлгэхээр саналаа холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна. <b>/Хэрэгжилт-90%/</b>
3.1.3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээг өргөжүүлж, өвчин эсэргүүцэх тарилга, вакцин, эм хангалтыг нэмэгдүүлнэ.	Халдварт өвчний эрт илрүүлэлт нэмэгдэж, халдварт өвчнийг эмчлэх вакцин, эмийг 70-аас дээш хувь хангаснаар	2010 оны эхний 11 сарын 29- ны байдлаар халдварт А хэлбэрийн шар нийт 524 тохиолдол бүртгэгдэн дэгдэлт хэлбэрээр гарч байгаа, мөн 12-24 сартай хүүхдүүдийг энэхүү өвчнөөс урьдчилан сэргийлэх үүднээс ЭМЯ, ХӨСҮТ-д халдварт “А” гепатитаас урьдчилан сэргийлэх вакциныг захиалсан бөгөөд улсын хэмжээнд вакцины нөөц хомсдолтой байдлаас 600 хүн тун вакцин тархвар судлалын заалтаар 2-9 насны хүүхдүүдэд хийсэн. Улаан бурхан, гахай хавдар, улаанууд өвчний хавсарсан вакцинд хамрагдвал зохих 9 сартай хүүхдийн 95,8 хувь, 2 настай 96,9 хувь хамрагдан аймгийн дундажаар 96,4 хувьтай байна. <b>/Хэрэгжилт-50%/</b>
3.2.1 50 ортой төрөх эмэгтэйчүүдийн эмнэлгийг ашиглалтад оруулж, эх хүүхдийн эндэгдлийг улсын дундажид хүргэнэ.	Эх хүүхдийн эндэгдэл буурч аймгуудын дундажид хүрснээр.	-2010 оны 11-р сарын 21-нд аймгийн Нэгдсэн эмнэлгийн төрөх эмэгтэйчүүдийн тасгийн 50 ортой барилгыг ашиглалтанд хүлээн авч ажиллаж эхлээд байна. Мөн ЭМЯ, НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 12,3 сая төгрөгний өртөг бүхий эхчүүдийн амрах байрны тавилга, тоног төхөөрөмжийг дээрхи тасагт хүлээлгэн өгснөөр аймгийн НЭ-т сумдаас ирж төрж буй эхчүүд төрөхийн өмнөх байранд тав тухтай амрах нөхцөл бүрдээд байна. -Эхний 11 сарын байдлаар эхийн эндэгдэлгүй байгаа боловч нялхасын болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл улсын дунджаас өндөр байсаар байна. Нялхасын эндэгдэл 1000 амьд төрөлтөд 27,5 промилль байгаа нь улсын дунджаас 8 промилиер өндөр, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 34,2 промилль байгаа нь улсын дунджаас 9,4 промилиер өндөр байна. <b>Хэрэгжилт 70%</b>
3.3.1. “Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер” зарлаж, хүн амыг өндөр идэвхтэй, чанарын баталгаатай үндэсний зайлшгүй шаардлагатай эм, биобэлдмэлээр жигд хүртээмжтэй хангаж, үр дүнг тооцож ажиллана.	Үндэсний зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангаснаар	Аймгийн Нэгдсэн эмнэлэг, сум, сум дундын эмнэлгийн эм, эмнэлгийн хэрэгслийг 2010 онд ханган нийлүүлэх нэгдсэн тендерээр 16 багцад 380 нэр төрлийн 388,3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийн бэлтгэн нийлүүлэх гэрээг 10 эм ханган нийлүүлэх байгууллагатай хийж, хэрэгжилтийн байдалд хяналт тавин ажилласнаар энэ оны эхний 11 сарын байдлаар хэрэгцээт эмийн 90%-ийг татан авч, зайлшгүй шаардлагатай эмийн хангалт аймгийн хэмжээгээр 85%-тай байна. 2010 оны эхний 11 сарын байдлаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 31 эмийн сангийн 96,8 хувь нь стандартын шаардлага хангасан

		байранд үйл ажиллагаа эрхэлж байна. Жор маягтын хангалт, жор бичилтийн стандартыг мөрдөх чиглэлээр сумдын эмнэлгээс захиалга авч 30 мянган ширхэг жорын маягтаар ханган, жор бичилтийн талаар сум, багийн эмч нийт 106 эмч, мэргэжилтэнг сургалтанд хамруулаад байна. <b>Хэрэгжилт-90%</b>
4.1.1. Хүн амын бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох судалгаа хийнэ.	Судалгаа хийгдэж, судалгааны үр дүнг тооцноор	Аймгийн хэмжээний ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, албан байгууллага, аж ахуйн нэгжийн ажилчдаас бие бялдрын хөгжлийн түвшин тогтоох сорилын дүнг нэгтгэн биеийн тамирын багш, биеийн тамирын арга зүйч нарт хүн амын бие бялдрын хөгжлийн түвшинг сайжруулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөн ажиллаж байна. <b>Хэрэгжилт-70%</b>
5.5.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлыг байрыг шийдвэрлэнэ.	Байртай болсноор	Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлын байрыг одоогоор санхүүгийн асуудал нь шийдэгдээгүй учраас хийгдээгүй байна./ <b>Хэрэгжилт- 0%/</b>
6.1.4. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг эрчимжүүлэн мэргэшсэн, тэгш шударга үйлчилгээг эрхэмлэж олон нийтийн итгэлийг олж улмаар татварын хууль тогтоомжийн биелэлт сайжирснаар татвар төлөхөөс зайлсхийх явдал буурсан байна	Улсын болон орон нутгийн орлогын төлөвлөгөөг 100-аас доошгүй хувиар биелүүлснээр	Татварын ерөнхий хуулийн 8-р зүйлийн татвар хураалтын процессын дагуу татварын өртэй ААН, иргэний нийт 89879,3 мянган төгрөгийн татварын өрийг төлүүлэхээр шүүхэд хандаад байна. Татвар төлөгч “Номгон хайрхан” ХХК нь НӨАТатвараар хамгийн их өртэй буюу нийт 80839,2 мянган төгрөгийн өртэй байгаа бөгөөд аймгийн ҮХЭХБГ-аас тухайн компанийн үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг гаргуулан авч шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор ИХШХШТХуулийн 69-р зүйлийн 69.1.1 дэхь хэсэгт заасны дагуу шүүхэд үл хөдлөх хөрөнгийг нь битүүмжлэх хүсэлт гаргаад байна. 2010 оны байдлаар ШШГА-нд нийт 9 ААН, иргэний 97442,7 мянган төгрөгийн өр байгаагаас 4794,9 мянган төгрөг барагдаж 92547,8 мянган төгрөг ШШГАжиллагаа хийгдэж байна. <b>/Хэрэгжилт- 90% /</b>
8.1.2. Орон нутгийн нийтийн тээвэр, сумдын зорчигч шуудан тээвэрлэлтийг төвлөрсөн зогсоол талбайгаас явуулж, бүртгэл хяналтын шинэ тогтолцоонд оруулна.	Тээвэр зохицуулалтын нэгдсэн зохион байгуулалтанд орсноор	Орон нутгийн зорчигч болон шуудан тээвэрлэлтийн ажлыг шуудан үйлчилгээний албанд хариуцуулж 2010 оны 4 сарын 1 нээс нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна. Таксинуудыг аж ахуйн нэгжийн зохион байгуулалтанд оруулах ажлыг шуудан үйлчилгээний газар зохион байгуулж байна. Дүнг оны эцэст дүгнэнэ. <b>/Хэрэгжилт-70%/</b>
8.4..2. Шуудангийн автопаркийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ.	Автопарк шинэчлэгдснээр	Авто парк шинэчлэлт хийгээгүй. /Хөрөнгө санхүүгийн чадавхиас шалтгаалан хийгдээгүй./ <b>/Хэрэгжилт 0/</b>

9.1.3. “Чихэр өвс” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлгнэ	Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээр	“Чихэр өвс” хөтөлбөр боловсруулан аймгийн ИТХТ-ийн 2010 оны 11 сарын 19 ны хурлаар хэлэлцүүлсэн. Хурлаас: 1. 2011 оны 6 сарын аймгийн ИТХ-ын хуралдаанаар оруулах 2. Чихэр өвс бүхий сумын иргэдэд дээрхи хөтөлбөрийг тараан хэлэлцүүлж санал авах 3. Саналыг нэгтгэн дүгнэлт гарган хэлэлцүүлэх нь зүйтэй талаар зөвлөмж өгч хойшлууллаа. <b>/Хэрэгжилт-70%/</b>
9.3.1. Малын үзлэг ангилалтын ажлыг сайжруулж, бүртгэл мэдээллийн сүлжээнд хамрагдана.	-цөм сүргийн малын тоог 150 мянгад хүргэснээр - шилмэл мал шалгаруулснаар	Мал сүргийн үзлэг, ангилалтанд нийт 350 мянган мал хамруулж, цөм сүргийн малын тоо 120 мянгад хүрч, цөм сүргийн хээлтэгч, хээлтүүлэгч малыг бүртгэн гэрчилгээжүүлж, хувьслын ангилалтанд орсон малын 34 хувийг ээмэг, дугаартай болгов. Малын үзлэг, ангилалтын ажил 10-р сард үргэлжлүүлэх бөгөөд цөм сүргийн болон хээлтүүлэгч малыг бүртгэлд хамруулж гэрчилгээжүүлнэ. Аймаг, сумын хэмжээнд хээлтүүлэгч, хээлтэгч шилмэл мал шалгаруулах үзэсгэлэн худалдаанд Баянхонгор, Галуут, Жинст, Баянхонгор сумдаас үржлийн мал оролцов. <b>/Хэрэгжилт-90%/</b>
9.3.2. Мал сүрэг ялангуяа ямааны өсөлтийг тогтворжуулах, сүргийн бүтцийг шинжлэх ухааны үндэслэлтэй харьцаанд ойртуулах	Сүргийн бүтэц зохистой харьцаанд ойртсоноор	Мал сүргийг бэлчээрийн даац багтаамжид тохируулан, сүргийн зохистой бүтэцтэй байлган тоо толгойг хэт өсгөхгүй байх бодлого баримталж байгаа бөгөөд нийт сүрэгт эзлэх ямааны тоо толгой буурч, урд оныхоос 1 хуваарь буурсан дүнтэй байна. <b>/Хэрэгжилт-90%/</b>
9.9.2. Хэрэглэгчийн төлбөр тооцооны системийг орчин үеийн windows орчны программд шилжүүлнэ.		Төлбөр тооцооны системийг орчин үеийн windows орчны программыг шинэчлэн боловсруулж байна. Бэлтгэл ажлын хүрээнд аймагт 4 удаагийн сургалт явуулахаас 2 удаагийн сургалтыг зохион байгуулаад байна. Улсын хэмжээнд 70 хувьтай явж байгаа ба манайд 2011 оны 1-р улиралд багтаан шинэчлэлт хийгдэнэ. <b>/Хэрэгжилт- 70%/</b>
9.11.1. Баянхонгор аймгийн төвд барих “Дулааны цахилгаан станц”-ын судалгаа хийх ажлын эхлэлийг тавина.	Зураг төсөв хийх хөрөнгийг шийдвэрлэж, гүйцэтгэгчийг сонгон гүйцэтгүүлэх	Дулааны цахилгаан станц байгуулах, түүнд дэмжлэг үзүүлэх талаар яам, УИХ гишүүд, гадаад дотоодын хандивлагч нарт санал тавьсан одоогоор албан ёсоор хариу ирээгүй байна. <b>/Хэрэгжилт 10%/</b>

<p>9.13.1. “Эрдэнэмандал” хайрханыг тойруулан мод тарьж, моджуулах хөдөлгөөн өрнүүлж, ойжуулах /100000 мод тарих, Биологийн багш нарын хүчийг ашиглах /</p>	<p>Тарьсан модны амьдралт 70-аас дээш хувьтай байна.</p>	<p>Хайс хамгаалалт хийх зардлыг орон нутгийн төсвөөс гаргах боломжгүй тул Эрдэнэмандал хайрханыг тойруулж моджуулах ажлыг “Гурван бүсийн цэцэрлэгт хүрээлэнд хийлгэхээр ИТХ, аймгийн ЗДТГ-тай тохиролцон Улаанбаатар хотын “Саяаны-Ус” ХХК-аар ойжуулалтын ажил хийлгэсэн боловч үр дүн багатай боллоо.Тендерийн асуудлыг цуцлах талаар холбогдох газарт санал тавиад байна.</p> <p>Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас зарласан “ОР-2010 0А5/28-04 багц тендерт “Саяана-Ус” ХХК шалгарч Баянхонгор аймгийн төвд 5 га талбайд цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэж байна. “Саяана-Ус” ХХКомпани нь цэцэрлэгжүүлэлтийн ажлыг технологийн дагуу хийгээгүй.Тарьц суулгацын хэмжээ 5 га талбайд тарих нормд хүрээгүй.Улиас 900 ширхэг, шар хуайс 550 ширхэг, бургас 200 ширхэг нийт 1650 ширхэг мод тарьсан байна.Нэг тогоонд гурав гурваар нь суулгасан 114 нүхэнд 342 ширхэг 86 метрийн урттай 40 см-ийн өргөнтэй шуудуунд нэг эгнээгээр 1308 ширхэг, нийтдээ 10836 ширхэг мод, сөөг тарьж суулгасан.</p> <p>“Саяана-Ус” компани мэргэжлийн түвшин, чадварын хувьд уг ажлыг гүйцэтгэх чадамжгүй гэж үзэж гэрээг цуцлаж өөр мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргаж ойн газарт санал тавиад байна.</p> <p>Гурван бүс цогцолборт хүрээлэнд “Хас банк”-ны нэрэмжит төгөл байгуулж 500 гаруй хайлаас тарьсан. Намрын ойжуулалтаар Хот тохижилт үйлчилгээний газар орхиод явсан 1600ш модыг шилжүүлэн тарьсан байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-70%/</b></p>
---	--	--

<p>9.16.2. "Шаргалжуут-Цагаан агуй-Бичигт хад" маршрутаар Аялал жуулчлалын аймгийн анхны шинэ маршрутыг нээнэ</p>	<p>Маршрут нээгдэж гадаад дотоодын жуулчдад үйлчилж эхэлснээр</p>	<p>Шаргалжуут, Цагаан агуйг холбосон говийн чиглэлийн аялалын маршрутыг гаргаж танилцуулга, хэвлэмэл брошуруудад ашиглаж сурталчилгааны ажлыг зохион байгуулаад байна. Аймгийн хөрш зэргэлдээ орших Завхан аймгийн "Отгонтэнгэр хайрхан"-ы Дархан Цаазат газрын чиглэлийн аялал жуулчлалын маршрутыг гаргах Завхан аймгийн аялал жуулчлалын ажил байдалтай танилцах зорилгоор 2010 оны 06 сарын 12-14-ны хооронд газрын дарга Л.Мандал, аялал жуулчлалын мэргэжилтэн Д.Содномсамдан нар тус аймгийн Отгон суманд ажилласан. Ажлын явцад Отгонтэнгэр хайрханы өвөрт орших "Отгон" жуулчны баазын захирал М.Болдбаатартай уулзаж тус баазруу зорин ирж байгаа жуулчдыг Баянхонгор аймгийн Гурванбулаг сумын "Хөх нуур", Баянбулаг, Бөмбөгөр сумдуудын газруудаар дайран өнгөрүүлэхээр ярилцаж тохирсон. Шаргалжуут, Цагаан агуй, Бичигт хадыг холбосон говийн чиглэлийн аялалын маршрутыг гаргаж аймгийн аялал жуулчлалын танилцуулга, хэвлэмэл брошуруудад байршуулан сурталчилгааны ажлыг зохион байгуулж байна. Аймгийн аялалын маршрутаар "Хонгорын Түүчээ" ТББ-тай хамтран оюутан залуучуудын "Мэдлэгт аялал"- ыг зохион байгууллаа.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-90%/</b></p>
<p>9.16.3. Орон нутагт аялал жуулчлалын хууль дүрэм стандартыг хангуулах, стандартыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулна.</p>	<p>Жуулчдын амрах үйлчлүүлэх таатай орчин бүрдснээр.</p>	<p>Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй буудлуудад зочид буудал, дэн буудлын стандартуудаар төрөл бүрийн хэвлэмэл брошур хийж тараан сурталчилгааны болон судалгааны ажлыг зохион байгуулсан. "Нэгдэлчин", "Сөүл", "Урандөш", "Энх-Номун", "Жаргалант", "Хонгор" зэрэг 5 зочид буудал, "Баянхайрхан", "Монос" зэрэг 2 дэн буудлуудын стандартад аймгийн МХГ-ын байцаагчтай хамтран 2010 оны 10 сарын 13-14 өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгууллаа.</p> <p>Зочид буудлын стандартыг хангасан тохиолдолд стандартчилал хэмжил зүйн төвөөс олгогдох тохирлын гэрчилгээг "Сөүл" зочид буудал авсан.Цаашид бусад зочид буудлуудад тохирлын гэрчилгээг олгуулах зочид буудлын стандартыг мөрдөж ажиллах талаар холбогдох байгууллагуудад санал тавин ажиллаж байна."Өвгөнжаргалант",</p>

		<p>“Шаргалжуут”, “Өхэг” зэрэг амралт сувилалын газруудын үйл ажиллагаатай 08, 09-р саруудад танилцлаа. Энэ жил “Өвгөнжаргалант” хүүхдийн зуслан хүүхэд 220, том хүн 250, нийт 460 амрагчдын хүлээн авсан статистик тоо гархбайна.</p> <p>“Өхэг” амралтын газар 2009 онд хувьчлагдаж урсгал засвар хийгдсэн. 2010 онд нийт 200 гаруй дотоодын амрагч сувилуулагчдыг хүлээн авсан. Цаашид амралтын газруудын үйл ажиллагааг сурталчилах, үзэсгэлэнт яармагт оролцуулах талаар хамтран ажиллахаар боллоо. “Говийн тэмээ”, “Мандухай” зэрэг жуулчны баазуудын үйл ажиллагаа, стандартын хэрэгжилтийн байдалтай 08 сарын 26-28 өдрүүдэд танилцаж, хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.</p> <p>“Говийн тэмээ” жуулчны бааз нь энэ жил 150 гаруй гадаадын жуулчин авсан. Тогтмол 3 ажилчинтай, жуулчин ихээр ирсэн тохиолдолд сумаас нэмэж ажилчин авч ажлуулдаг. Говийн тэмээ жуулчны бааз нь жуулчны баазад тавигдах стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. Стандартыг мөрдөж ажиллах талаар зөвлөмжийг дээрхи газруудад өглөө</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-70%/</b></p>
9.16.5. Аймгийн аялал жуулчлалын үйлчилгээний газрууд болон хувь хүмүүст аялал жуулчлалын мэдээлэл сургалт сурталчилгааг зохион байгуулна	Орон нутагт аялал жуулчлалын үйлчилгээний чанар сайжирч, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлнэ.	<p><b>“Баянхонгор аймагт аялал жуулчлал хөгжүүлэх”</b> сэдэвт уулзалт, ярилцлагыг 2010 оны 02 сарын 23-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын газрын “Экологи сургалт аялал жуулчлалын мэдээллийн төв”-ийн зааланд зохион байгуулсан. Уг уулзалт ярилцлагад Аймгийн ИТХ-ын дарга Г.Батжаргал, БОАЖГазрын дарга Л.Мандал газрын мэргэжилтэн, Их богдын ТХГазрын захиргааны дарга Б.Баярмагнай, жуулчны үйлчилгээний байгууллагын захирал эрхлэгч, аялал жуулчлалын чиглэлээр төгссөн болон сурч байгаа оюутан залуучууд оролцсоноороо онцлог болсон.</p> <p>Жил бүрийн 09 сарын 27-нд болдог “Дэлхийн аялал жуулчлалын өдөр”-ийг угтаж аймгийн Их дээд сургуулиуд, ЕБС, цэцэрлэг, багийн иргэдийг оролцуулан аялал жуулчлалын талаарх мэдээлэл, явган аялалыг ХҮДС, БСГ-уудтай хамтран зохион байгууллаа.</p>

		<p>Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор аж ахуй нэгж, албан байгууллага, ард иргэдээс судалгаа авч түүнд тулгуурласан аялалын маршрутуудыг гаргалаа</p> <p>Монгол улсын төрийн шагналт, гавъяат багш академич, доктор, профессор Шадавын Лувсанванданы мэндэлсний 100 жилийн ойд зориулан “Их эрдэмтний төрсөн нутгаар” тойрон аялалыг 2010.09.18-21 хооронд Өлзийт, Эрдэнэцогт сумын нутгаар аймгийн ЗДТГ, БСГ, Өлзийт сумын ЗДТГ, Ш.Лувсанванданы нэрэмжит сургууль, Улаанбаатар хот дахь Ш.Лувсанвандан сан зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулав.</p> <p>БНХАУ-ын Хэнан мужад болсон “Хүлэмжийн хийг багасгах ажлыг Зүүн өмнөд азиас эхлэе” сэдэвт сургалт семинарт Монгол, Солонгос, Хятад зэрэг 3 улсын төлөөлөгчид оролцлоо. Баянхонгор аймгаас оролцсон ЗДТГ, БОАЖГазруудаас оролцсон төлөөлөгчид аймгийн аялал жуулчлалын талаархи мэдээлэл, брошур зэргийг зочид төлөөлөгчдөд тарааж сурталчилгааны ажлыг зохион байгуулав.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-90%/</b></p>
<p>14.3.1. Шийдвэр гүйцэтгэлийн үйл ажиллагааны зардлын сан бүрдүүлэх эхлэл тавих</p>	<p>- Сангийн үйл ажиллагааны үрд дүнгээр</p>	<p>2009 оны 10 дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас өрх толгойлсон эмэгтэй, өндөр настан, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой тэтгэлэг авагч нарт шийдвэр гүйцэтгэх албаны зардлыг урьдчилан гаргах зорилгоор 1,0 сая/төг-ний “Эрсдэлийн сан” байгуулах шийдвэрийг гаргасан хэдий ч энэ асуудал бүрэн шийдэгдээгүй байна.</p> <p style="text-align: right;"><b>/Хэрэгжилт-50%/</b></p>